



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

(20 дахь жилдээ)

2021/01

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

[20 дахь жилдээ]

2021/01

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл
2021/01 (57)
Улсын бүртгэлийн дугаар 244
20 дахь жилдээ

- Б.Энхболд *Ерөнхий редактор (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор)*
- З.Өнөржаргал *Хариуцлагатай нарийн бичгийн дарга (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)*

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

**© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн
Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй,
зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.**

ISSN: 2617-9288

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ*Ц.Алтанцэцэг**О.Хишигмөнх*

Хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллага, иргэнд шилжүүлэх
эрх зүйн зохицуулалт, тулгамдсан зарим асуудал 5

С.Ганцэцэг

Хууль зүйн туслалцааны эрх зүйн зохицуулалтад анхаарах зарим асуудал . . . 29

Б.Мөнх-Эрдэнэ

Ялгаварлан гадуурхалт ба хүний эрх 41

*Б.Пүрэвсүрэн**М.Оюунхорол*

Хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт ба цензур 58

М.Хатанзориг

Хувь хүний дангаарших эрхийн талаарх Америкийн Нэгдсэн Улсын
Дээд шүүхийн голлох шийдвэр, түүний зарим
үр дагавар №1: Катзын маргаан 84

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

Бүх нийтэд боловсрол олгох, боловсролын салбар дахь хувийн
хэвшлийн оролцоог зохицуулах тухай улс орнуудын хүлээх хүний эрхийн
үүргийн талаарх суурь зарчмууд 97

ЗОЧНЫ ЯРИА

*Дотоод хэргийн их сургуулийн Ахисан шатны боловсролын
сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор,
цагдаагийн дэд хурандаа Б.Лхагвасүрэн*тэй хийсэн ярилцлага
“Шударгаар шүүлгэх эрхийн шинжлэх ухааны баталгаа нь
шинжлэн магадлах үйл ажиллагаа юм” 128

CONTENT

ARTICLES


- Ts. Altantsetseg*
O.Khishigmunkh
Legal regulations on the transfer of children to the care
of orphanage and an individual and some urgent issues 5
- S.Gantsetseg*
Some issues in addressing legal regulations of legal aid 29
- B.Munkh-Erdene*
Discrimination and human rights. 41
- B.Purevsuren*
M.Oyunkhorol
Implementation of right to freedom of press and censorship 58
- M.Khatanzorig*
United States Supreme Court landmark decision related to privacy,
and its impact №1: KATZ CASE 84

ONLY IN MONGOLIAN

- The guiding principles on the human rights obligations of states
to provide public education and to regulate the private sector's
involvement in education (Abidjan Principles) 97

GUEST INTERVIEW

- B.Lkhagvasuren, Lieutenant Colonel of Police, Associate professor, Doctor of law,
Director of School of Advanced Education, University of Interior Affairs*
"Scientific guarantee of right to fair trial is a forensic analysis process" 128





Ц.АЛТАНЦЭЦЭГ

Хуульч, дэд профессор



О.ХИШИГМӨНХ

Хуульч, хууль зүйн ухааны докторант

ХҮҮХДИЙГ АСРАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА, ИРГЭНД ШИЛЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

LEGAL REGULATIONS ON THE TRANSFER OF CHILDREN TO THE CARE OF ORPHANAGE AND AN INDIVIDUAL AND SOME URGENT ISSUES

Хураангуй: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалтад “гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, Хүүхдийн эрхийн тухай конвенцын 20 дугаар зүйлд “хүүхдийн дээд эрх ашиг сонирхолд нийцүүлэх, аюулгүй орчин бүрдүүлэх” үүргийн хүрээнд хүүхдийг хамгаалах зохих эрх зүйн орчинг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах ажил тодорхой хэмжээнд тасралтгүй хийгдэж байгаа хэдий ч хүүхэд хамгааллын эрх зүйн зохицуулалтын оновчтой, үр нөлөөтэй, хүүхдэд ээлтэй байдлыг судлах хэрэгцээ, шаардлага байсаар байна. Ялангуяа хүүхдийг зайлшгүй шаардлагаар асран хамгаалах эрхийг шилжүүлэх, шилжүүлсний дараах асуудлыг нэг мөр хуулиар тодорхой зохицуулах шаардлагатай байна. Хүүхдийн асрамж халамжийн асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн хүсэл зоригийг харгалзан авч үзэх, эцэг, эхийг орлохуйц байж чадаж байгаа эсэх, гэр бүлийн орчинтой дүйцэж буй эсэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэх, асран хамгаалж буй этгээдэд тавих хяналтын асуудал цогцоор нэг мөр шийдвэрлэсэн эсэхийг судлан үзэхийг зорилоо.

Түлхүүр үг: Асралт гэр бүл, хүүхэд хамгаалал, эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхэд, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ, төвлөрсөн асрамж, халамж, асрамж, хамгаалал.

Abstract: *There is still a need and demand to study adequacy, effectiveness, and child friendliness of legal provisions of child protection even though there have been various activities conducted regularly at certain level to create safe environment and legal provisions in compliance with Part 16.11 of Article 16 of the Constitution of Mongolia, which states, "The State shall protect the interests of the family, motherhood and the child," and Article 20 of the Convention on the rights of the child to ensure the consistency with "best interest of the." Especially, it is necessary to legally regulate the issues on the transfer of guardianship of a child out of utmost necessity and issues after the transfer. In this article we aim at exploring whether the legal regulations have covered the issues of considering will of a child in making decision on guardianship of him/her whether guardians can play the role of parents, whether guardianship can satisfy the requirements for family environment and safety of a child, and whether the oversight on the guardians is ensured.*

Keywords: *Compassionate family, child protection, a child at risk, alternative child care services, centralized nursing, care, and protection.*

Удиртгал

Төрийн зүгээс бодлогын хүрээнд хүүхдэд онцгой анхаарал хандуулах, хүүхдийг хамгаалах, хөгжүүлэх, амьдралын нөхцөлийг сайжруулах, хүүхдийн хууль ёсны ашиг сонирхлыг хангах чиглэлд холбогдох хууль тогтоомжийг баталж, шаардлагатай олон улсын гэрээ конвенцод нэгдэн орж, зохих эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулж ирсэн хэдий ч хүүхдийн эрх зөрчигдөх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх, хүүхэд хамгааллын тогтолцоонд дутагдал байсаар л байна. Учир нь "төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэнэ"¹ гэсэн зарчмын агуулгаар тодорхойлогдож буй хүүхэд хамгааллын асуудал нь зөвхөн төрийн байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүргээр хэмжигдэхгүй бөгөөд төр, хувийн хэвшлийн бүх байгууллагууд, иргэний оролцоо зайлшгүй шаардагдах, адил үүрэг хариуцлага хүлээх хууль зүйн агуулгыг илэрхийлж байгаатай холбоотой. Хүүхдийн эсэн мэнд амьдрах, нийгмийн амьдралд оролцох, хамгаалуулах эрхийг хангахад төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, хуулийн этгээд, иргэний хамтын ажиллагаа, оролцоо, хяналт болон шаардлагатай санхүүжилтийн асуудал нэн чухал юм.

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл

1

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, (2016).

санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүхий л орчинд хамгаалагдах эрхтэй боловч хамгаалах үүргээ биелүүлээгүй аливаа үйлдэл, эс үйлдлээс болж хүүхэд гэр бүлийн орчинд өсөж хүмүүжиж чадахгүй байх, хайр халамжаар дутах, гэр бүлийн орчноосоо өөр газар амьдрах, дасах шаардлага тулгардаг нь хүүхдийн хувьд маш том сорилт, бэрхшээл болдог. Сүүлийн жилүүдэд гэр бүл салалт болон гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх хандлагатай болж, мөн гэр бүлийн хүрэн дэх бусад эрсдэл нь хүүхдэд сөргөөр нөлөөлж байна. Гэр бүлийн маргаан сүүлийн 2 жил өсч, шүүхээс хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, эцэг, эх байх эрхийг хасах шийдвэр гаргах явдал нэмэгдэж, хүүхэд асран хамгаалалтгүй болоход нөлөөлж буй бусад хүчин зүйлс, нөхцөл байдал нь хүүхэд өөрийн гэр бүл, эцэг, эхтэйгээ хамт амьдрах, тэдний хайр халамжид байх “хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх, ашиг сонирхол” илүүтэй хөндөгдөн, хүүхдийн гэр бүл, эцэг, эхийг орлох асран хамгаалалтыг хэнд хэрхэн шилжүүлэх вэ? гэдэг асуудал үүсч улмаар хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох, үрчлэгдэх, эсхүл асран хүмүүжүүлэх хүсэлт гаргасан иргэний гэр бүлд шилжүүлэх, түүнчлэн асран хүмүүжүүлэх байгууллагад шилжихээс өөр аргагүй байдалд хүргэж байна. Хүүхдийн эрхэм дээд ашиг сонирхол нь өөрийн гэр бүл, эцэг, эхтэйгээ хамт амьдарч халамжид байх, тэдний анхаарал чиглэх гол зүйл юм. Тиймээс хүүхдийн хүмүүжил болон хөгжилд эцэг, эх буюу тодорхой тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчид гол хариуцлагыг хүлээдэг².

Хүүхэд эцэг, эхтэйгээ байхаас илүү жаргал үгүй боловч хүүхдийнхээ өмнө хүлээсэн үүргээ ухамсарладаггүй, хариуцлагагүй эцэг, эх, асран хамгаалагчид цөөнгүй байгаа нь харамсалтай байна. Хүүхдийн гэр бүл, эцэг, эхийг орлон асран хамгаалах үүрэг хэрэгжих эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, бэрхшээл, тулгамдсан асуудал тэр дундаа хүүхдийн асрамж халамжийн байгууллагуудын ихэнх нь олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хувь иргэний санхүүжилтээр шийдэгдэж байгаа нь сайшаалтай хэдий ч тухайн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хүүхдийн хөгжил, төлөвшил, хүүхэд хамгаалал, аюулгүй байдалд зохих анхаарлаа хандуулахад хүндрэл гарах, эрсдэл учруулах талтай байна.

Иймээс хүүхдийн хөгжил, төлөвшил болон үндэсний хэмжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх асуудалд анхаарал хандуулах нь чухал асуудлын нэг юм. Түүнчлэн хүүхдийг асран халамжлах явцад тэдний эрх ашиг хөндөгдөж хохирч буй нөхцөл байдал болон тэдгээрийн үйл ажиллагаанд гарч буй хүндрэл, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, асран хамгаалалтыг хэрэгжүүлж байгаа этгээдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Юуны өмнө нь гэр бүл төвтэй, гэр бүлдээ эргэн нэгдэх төрийн эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх асуудлыг нэн тэргүүнд тавьж, эрх зүйн орчныг боловсронгуй

2

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, (1989).

болгох шаардлагатай гэж үзэж байна. Хүүхдийн талаар баримтлах төрийн эрх зүйн бодлогын нэг болох “Хүүхдийн гэр бүл, эцэг, эхийг орлох асран хамгаалалт”-ыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлын хүрээнд энэхүү сэдвийг хөндлөө.

I. ҮНДСЭН АСУУДАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын нийт хүн амын гуравны нэг хувийг хүүхэд эзэлдэг бөгөөд Үндэсний статистикийн хорооны судалгаанд дурдсанаар улсын хэмжээнд 2019 онд 36,6 мянган өнчин хүүхэд байгаагийн 3,1 мянга нь бүтэн өнчин, 33,5 мянга нь хагас өнчин хүүхэд байна. “Хүүхэд” гэж Хүүхдийн эрхийн тухай конвенцод³ зааснаар “18 нас хүртэлх бүх хүнийг хүүхэд гэнэ”, Хүүхэд хамгааллын тухай хуульд “Монгол Улсын иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэлх, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэлх насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно”⁴ гэж тус тус заасан.

Монгол Улсын хэмжээнд 21 байгууллагын 31 асрамж, халамжийн төв үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс Улаанбаатар хотод 26, Дархан-Уул аймагт 2, Дорнод аймагт 1, Орхон аймагт 1, Өвөрхангай аймагт 1 тус тус ажилладаг. Эдгээр төвийн 3 нь улсын төсвөөс, 28 нь олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хувь иргэний санхүүгийн эх үүсвэрээс санхүүждэг. 2020 оны байдлаар эдгээр төвд хагас болон бүтэн өнчин 0-18 насны 1,032 хүүхэд, 18-аас дээш насны 37 хүн амьдарч байна⁵. Үүнээс үзэхэд асрамж, халамжийн төвүүд нь аймаг бүрд байдаггүй, улсын төсвөөс ихэнх нь санхүүждэггүй олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын эсхүл иргэний санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг нь харагдаж байна.

Монгол Улс нь хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Нийгмийн халамжийн тухай зэрэг хуулиуд болон дагалдах журмууд, түүнчлэн Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцоор зохицуулан хамгаалж байна. Харин хүүхдийг асран хүмүүжүүлэх эрхийг иргэн, асран хүмүүжүүлэх байгууллага руу шилжүүлэх асуудлыг Гэр бүлийн тухай, Нийгмийн халамжийн тухай зэрэг хуулиар голчлон зохицуулж байна. Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсад хууль ёсоор оршин сууж байгаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш

3 Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1990 онд нэгдэн орсон.

4 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, (2016).

5 <http://www.fcy.gov.mn/news/178>

байна⁶, ...гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална⁷ гэж заасны дагуу дээрх хууль тогтоомж болон Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколд нэгдэн орж, мөн “Хүүхдийн амьдралд ээлтэй дэлхий ертөнцийн тунхаглалын зарчим”-ын дагуу зохих эрх зүйн орчин бүрдүүлсэн байна.

“Хүүхдийн хөгжил, хамгааллын тухай үндэсний хөтөлбөр”⁸-т нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаална, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг орон нутгийн болон үндэсний хэмжээнд зохион байгуулагдах хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нас, хүйс, газар зүйн байршил, нийгэм, эдийн засгийн байдал зэрэг үзүүлэлтээр гаргаж дүн шинжилгээ хийх, зөвлөмжийг хэрэгжүүлэх, хүүхэд нийгмийн бүх орчинд хүчирхийлэлтэй холбоотой эрсдлээс хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлд ойр байгаа, эсхүл эрсдэлд өртсөн хүүхэд, гэр бүлд үзүүлэх тусламж үйлчилгээг өргөжүүлнэ, хүүхдийн асрамж, халамжийн төвлөрсөн үйлчилгээг хувилбарт үйлчилгээнд үе шаттайгаар шилжүүлж холбогдох журам, стандартыг батлан мөрдүүлэх, хараа хяналтгүй хүүхдийн нөхцөл байдал, гудамжинд гарахад нөлөөлж байгаа шалтгааныг судалж, гэр бүлд нь нэгтгэх ажлыг зохион байгуулах, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах, хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа байгууллагыг чадавхжуулах зэрэг ажлыг хийхээр тусгасан.

Хөтөлбөрт дурдсан хүүхдийг гэр бүлд нь нэгтгэх, хүүхдийн асрамж, халамжийн төвүүдийг хувилбарт үйлчилгээнд шилжүүлэх хүүхдэд гэр бүлийн орчин нөхцөлийг бүрдүүлэх, жил бүр холбогдох хуулиар үүрэг хүлээсэн албан тушаалтнуудыг сургах, чадавхжуулах, мэдлэг, мэдээлэлтэй болгох зэрэг ажлууд тодорхой хэмжээнд хийгдэж байна. Мөн Монгол Улс нь 2019-2020 оныг хүүхдийн хөгжил, хамгааллын жил⁹ болгон зарлаж хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зарим санхүүжилтийг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийсэн нь сайшаалтай.

Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг бол Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын

6 Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалт, (1992).

7 Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, (1992).

8 Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоол.

9 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 60 дугаар зарлиг.

харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Гэр бүлийн бүлийн тухай хуулиар эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан бол хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлнэ¹⁰, хүнд нөхцөлд байгаа бага насны буюу насанд хүрээгүй хүүхдийг иргэн гэр бүлдээ авч, өөрийн зардлаар асран хүмүүжүүлж болно¹¹ гэж тус тус зохицуулсан. Уг зохицуулалтын дагуу асран хүмүүжүүлэх байгууллага эсхүл хүүхдийг гэр бүлдээ авч өөрийн зардлаар хүмүүжүүлэх хүсэлт гаргасанд нь шилжүүлэх боломжтой байна. Холбогдох хуульд хүүхдийг шилжүүлэн өгөхтэй холбоотой зохицуулалтыг судлан үзвэл хүүхдийн эрх зөрчсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлэх¹²-ээр зохицуулсан. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэдгийг эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг¹³ хэлнэ гэж хуульчилсан.

Бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаална¹⁴, хүүхдийн тухай мэдээллийг ясли, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлгийн байгууллагын холбогдох албан тушаалтан болон иргэн, хүүхдийн оршин суугаа (оршин байгаа) газрын сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй¹⁵. Хараа хяналтгүй хүүхдийг хуульд заасны дагуу цагдаагийн байгууллагаас шилжүүлсэн хүүхдийг хүлээн авсан хүүхдийн буюу харгалзан дэмжих байгууллага нь 3 хоногийн дотор энэ тухай сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх үүрэгтэй. Сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор хүүхдийн амьдралын нөхцөлийг судалж, эцэг, эх

10 Гэр бүлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэг, (1999).

11 Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг, (1999).

12 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг, (2016) .

13 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, (2016) .

14 Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэг, (1999).

15 Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг, (1999).

болон төрөл садангийн хүн байхгүй нь тогтоогдсон бол түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ. Сум, дүүргийн Засаг дарга нь хүнд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, бүртгэл хөтлөн, түүнийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнд шилжүүлж болно. Хүүхдийг шилжүүлэх боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхээр¹⁶ хуульчилсан байна. Үүнээс үзэхэд:

- Бүтэн өнчин;
- Эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон;
- Эцэг, эх байх эрхээ хасуулсан;
- Удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа;
- Хорих газарт ял эдэлж байгаа зэрэг шалтгааны улмаас хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаалах, хүсэлт гаргасан иргэнд шилжүүлэх, шилжүүлэх боломжгүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг хуулиар тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргад олгожээ.

Дээрх нөхцөл байдал тогтоогдсон хүүхдийг шууд асрамжийн байгууллагад шилжүүлэх шийдвэрийг гаргахаас илүүтэй төрөл садан нь асран хамгаалж харгалзан дэмжих боломжтой эсэх, үрчлэн авах хүсэлтэй иргэн байгаа эсэх, өөрийн гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх хүн байгаа эсэхийг харгалзан үзэж байна. Энэ нь Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан “улсууд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч буюу түүний төлөө хуулийн дагуу хариуцлага хүлээх бусад этгээдийн эрх, үүргийг харгалзан, хүүхдийг хамгаалах, халамжлах зорилгоор хууль тогтоох болон захиргааны бүхий л зохистой арга хэмжээг авах”¹⁷ зохицуулалттай нийцэж байна. Мөн уг конвенцод “өөрийн гэр бүлээсээ түр буюу бүрмөсөн хагацсан эсвэл гэр бүлийнхээ дотор цаашдаа байвал язгуур эрх ашигт нь харшлах аюултай болбол тухайн хүүхэд улсаас онцгойлон асрамжлуулан хамгаалуулах, тусламж авах эрхтэй”¹⁸ байхаар заасан. Дэлхийн улс орон бүрт хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдэд онцгой анхаарал хандуулж, шаардлагатай арга хэмжээ авч хүүхдийг хамгаалах, өв тэгш хөгжүүлэх, хүүхдийн амьдралын нөхцөлийг сайжруулах, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулах¹⁹-ыг үүрэг болгосон.

16 Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6-25.10 дахь хэсгүүд, (1999).

17 Хүүхдийн эрхийн тухай конвенцын удиртгал болон 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, (1989).

18 Хүүхдийн эрхийн тухай конвенцын 20 дугаар зүйл, (1989).

19 Хүүхдийн эрхийн тухай конвенцын удиртгал болон 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, (1989).

Бүтэн өнчин хүүхэд гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх (эцэг) нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг²⁰ хамааруулахаар хуульчилсан. Хүүхэд бүтэн өнчин болох, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй болох, удаан хугацаагаар эмчлүүлэх зэрэг тохиолдол нь эцэг, эхийн хувьд хүндэтгэн үзэх, өөрсдөөс үл хамаарах шалтгаан нөхцөл байдаг бол эцэг, эх байх эрхээ хасуулах, гэмт хэргийн улмаас ял эдэлж байгаа эцэг, эхчүүдийн хувьд хууль зөрчсөн хариуцлагагүй үйлдэл юм. Ялангуяа архидан согтуурч хүүхдээ үл хайхрах, гачигдуулах, хүчирхийлэх, дарамтлах зэрэг нь хүүхдийн хөгжил, хүмүүжилд сөргөөр нөлөөлж гэрээсээ дайжих, тэнүүчлэх улмаар гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирох шалтгааны үндэс болж байна.

Хүүхдийг орон сууц, хувцас, хоол ундаар байнга санаатай гачигдуулсан, хөдөлмөрийг нь зүй бусаар ашигласан, гуйлгачлуулсан, орон гэрээсээ дайжуулсан, гадуурхсан хүний эцэг, эх байх эрхийг зургаан сар хүртэл хугацаагаар шүүх хязгаарлаж болно²¹. Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүн уг хүүхдийг биечлэн өсгөн хүмүүжүүлэх, төлөөлөх, хүүхэдтэй холбогдуулан хууль тогтоомжоор олгосон эрхээ алдах бөгөөд шүүх нь эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүнээс хүүхдийг тэжээн тэтгэхэд шаардагдах тэтгэлгийг гаргуулах асуудлыг шийдвэрлэнэ²² гэж заасан. Шүүхээс эцэг, эх байх эрхийг хассан хэдий ч хүүхдийн өмнө хүлээх үүргээсээ чөлөөлөгдөхгүй, тэжээн тэтгэх зардлыг гаргуулахаар хуульчилсан боловч ихэнх тохиолдолд уг зардлыг гаргуулах асуудал ихээхэн хүндрэлтэй, хэрэгжих боломжгүй байгаа бөгөөд хэрэв төлбөрийн чадваргүй бол түүний оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг дарга хариуцаж болно гэсэн зохицуулалтаар шийдвэрлэгдэж байна.

Хуульд зааснаар хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садан байхгүй, үрчлэн авах, өөрийн асрамжиндаа авах хүсэлтэй иргэн байхгүй бол асрамжийн байгууллагад Засаг даргын шийдвэрээр шилжүүлнэ. Монгол Улсад дээр дурдсан 21 байгууллагын 31 халамж, асрамжийн төв үйл ажиллагаа явуулж хүүхдэд зохих үйлчилгээг үзүүлж байна. Эдгээр асрамж, халамжийн байгууллага нь Нийгмийн халамжийн тухай хууль болон стандартын²³ дагуу нийгмийн халамжийн үйл ажиллагаа явуулдаг. Монгол Улсад нийгмийн халамжийн үйлчилгээ нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон төрөлжсөн асрамжийн

20 Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7, (2012).

21 Гэр бүлийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, (1999).

22 Гэр бүлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсэг, (1999).

23 Стандарт, хэмжил зүйн газар, "Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага", MNS58525:2017.

үйлчилгээ гэсэн төрөлтэй байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ гэж иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг²⁴ хэлэх бөгөөд дараах төрөлтэй²⁵ байна. Үүнд:

- Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;
- Зөвлөгөө өгөх;
- Сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
- Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;
- Өдрийн үйлчилгээнд хамруулах;
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
- Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
- Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах;
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах.

Дээрх дурдсан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх, 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд...” авч болохоор заасан. Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь уг үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно²⁶.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэж асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг²⁷ хэлэх бөгөөд

24 Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10, (2012).

25 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, (2012).

26 Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, (2012).

27 Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9, (2012).

төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна²⁸. Үүнд:

- Ахмад настны асрамжийн үйлчилгээ;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ;
- Хүнд нөхцөлд байгаа 18 хүртэлх насны хүүхдийн асрамжийн үйлчилгээ;
- 3 ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн үйлчилгээ.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй улмаас дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй, тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан, мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардагдсан болон тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд нөхцөлд байгаа, Гэр бүлийн тухай хуульд заасан болон байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхэд, улсын зардлаар төрөлжсөн асрамжийн газар асрамжлан өсгөхийг эцэг, эх нь зөвшөөрсөн дөрөв хүртэлх насны гурав ба түүнээс дээш ихэр хүүхэд үйлчилгээ авч болно²⁹. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үйлчлүүлэгчийн өвөрмөц хэрэгцээ, нас, хүйсийн онцлогийг харгалзан нарийвчлан ангилж, төрөлжүүлж болно. Хүүхэд ба иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга гаргана³⁰.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална. Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах, төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх болон түүний төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Хүүхдийг асран хүмүүжүүлэх үүргийг холбогдох хуульд зааснаар иргэн эсхүл асран хүмүүжүүлэх байгууллага шилжүүлэн авч болно.

Иргэн шилжүүлэн авч хүмүүжүүлэх асуудал нь Гэр бүлийн тухай хуульд зааснаар “Хүнд нөхцөлд байгаа бага насны буюу насанд хүрээгүй хүнийг иргэн гэр бүлдээ авч, өөрийн зардлаар асран хүмүүжүүлж болно. Хүүхдийг асран хүмүүжүүлэхдээ нийгмийн халамжийн байгууллага болон асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэний хооронд тодорхой хугацаагаар

28 Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, (2012).

29 Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, (2012).

30 Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг, (2012).

гэрээ байгуулна. Хүүхэд асран хүмүүжүүлэх тухай гэрээнд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, боловсрол олгох нөхцөл, асран хүмүүжүүлэгчийн болон нийгмийн халамжийн байгууллагын эрх, үүрэг, асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулал, хууль тогтоомжийн дагуу олгогдох бусад хөнгөлөлт, гэрээ дуусгавар болох үндэслэл, үр дагаврыг заана. Хүүхдийг асран хүмүүжүүлэхэд тухайн гэр бүлд тааламжгүй нөхцөл буй болсон нь тогтоогдсон, эцэг, эхэд нь буцаан өгсөн, үрчлүүлсэн бол нийгмийн халамжийн байгууллагын шаардлагаар, хүндэтгэн үзэх бусад шалтгаан (өвчилсөн, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдал өөрчлөгдсөн, харилцан үл ойлголцох, маргаантай байдал) болсон бол асран хүмүүжүүлэгчийн санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцалж болно. Хэрэв хүүхэд 7 нас хүрсэн бол өөрийн нь зөвшөөрлийг авсны үндсэн дээр шилжүүлнэ. Асран хүмүүжүүлэхээр шилжүүлсэн хүүхэд тэжээгчээ алдсаны болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах, хууль тогтоомжийн дагуу орон сууцаар хангагдах эрх эдэлнэ³¹.

Асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулалд шаардагдах зардлыг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ. Нийгмийн халамжийн байгууллага асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар асран хүмүүжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавина³². Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, асран хүмүүжүүлж байсан буюу үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлж байсан болон хорих ял эдэлж байгаа хүнтэй асран хүмүүжүүлэх гэрээ байгуулахыг хориглоно³³ гэж тухайн хувь хүн, иргэнд хамааралтай асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоохыг хориглох шалтгааныг заасан хэдий ч асран хамгаалах үүрэг хүлээж байгаа байгууллагын хувьд хамаарах заалт хуульд тусгагдаагүй харин стандартаар³⁴ зохицуулж байна.

“Стандарт” гэх ойлголт нь хэлбэр хэмжээ, чанарын нэг янзын тогтсон хэв загвар буюу тогтоосон хэмжээнд нийцэх гэсэн утга агуулгыг илэрхийлнэ³⁵. Стандартын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандартыг тогтоож, мөрдүүлэхэд орших тул бүтэн өнчин, эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээ үзүүлж буй хувь хүн, гэр бүл, байгууллагуудын үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хяналт тавих, үйлчилгээний

31 Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1-74.6 дахь хэсгүүд, (1999).

32 Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.8 дахь хэсэг, (1999).

33 Гэр бүлийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, (1999).

34 Стандарт, хэмжил зүйн газар, “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”, MNS58525:2017.

35 Я. Цэвэл, “Монгол хэлний их тайлбар толь”, УБ, 2016 он.

зөвшөөрөл олгох болон цуцлахад ашиглана гэж түүний хамрах ба хэрэглэх хүрээг заасан байна. Үүнээс үзэхэд үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагатай холбогдсон асуудал илүүтэй зохицуулагдаж байна. “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ” гэж эцэг, эхийн хайр халамжаас гадуур байгаа хүүхдэд урт, богино хугацаагаар асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг хэлэх³⁶ бөгөөд энэхүү үйлчилгээг үзүүлж буй орчноос нь хамаарч “төрөл, садан хүний асрамж халамж”, “асралт гэр бүлийн асрамж халамж”, “төвлөрсөн асрамж халамж” гэж ангилсан байна. Харин Гэр бүлийн тухай хуульд хүнд нөхцөлд байгаа хүүхдийг хамгаалах хамгаалалтын дараах хэлбэрүүдийг хуульчилсан байна. Үүнд:

- Гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнд шилжүүлэх;
- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох;
- Үрчлүүлэх;
- Хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх.

Субъектийн хувьд эрх зүйн харилцааны бие даасан субъект хэдий ч хүүхэд ямар ч нөхцөлд онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих тусгай хамгаалалт шаардлагатай онцлог субъект, нөгөө талаасаа бол дээрх хамгаалалтын хэлбэрүүд нь хүүхдийн гэр бүл, эцэг, эхийг орлох шинж бүхий асран хамгаалалтыг хэрэгжүүлэх нэг орчин болох тул “хамгаалалтын онцгой хэлбэр” гэж үзэх үндэслэл болно. Тиймээс дээрх хэлбэрүүд нь юуны өмнө хүүхдийн эцэг, эх, гэр бүлийг орлож чадах нөхцөл бүрдсэн орчин байхын зэрэгцээ хуульд заасан гэр бүл дэх хүүхэд хамгаалал, эцэг, эх, асран хамгаалагчийн хувиар хуулиар хүлээсэн үүргийн дагуу хүүхдийг өв тэгш хүмүүжүүлэх нэгдсэн шаардлага ч тавигдах тул төрөөс тогтоож буй стандарт чухал ач холбогдолтой юм. Аль ч хэлбэрээр хүүхдийг асран халамжлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тухайн хувь хүн, гэр бүлийн амьдралын болон байгууллагын үйл ажиллагааны түвшин, онцлог, тэдгээрийн эдийн засгийн нөхцөл байдлаар хязгаарлагдан зохицуулагдахгүй байх, нэн тэргүүнд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг эрхэмлэн хангах, хүүхэд хамгааллыг бэхжүүлэх асуудалд илүү анхаарах шаардлагатай юм.

II. ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хүүхдийг асрамжлан халамжлах, асран хамгаалалтын сонголт бүхий хувилбаруудыг тогтоож болох хэдий ч хүүхэд өөрийн эцэг, эх, гэр бүлийн орчноосоо өөр орчинд, өөр гэр бүлд, тэр дундаа асрамж халамжийн байгууллагад шилжүүлэх гэхээс илүүтэйгээр өөр орчинд шилжихээс урьдчилан сэргийлэх, шилжихэд хүргэж буй суурь шалтгаан

³⁶ Стандарт, хэмжил зүйн газар, “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”, MNS58525:2017, 4.5 дахь хэсэг.

түүнд нөлөөлөх хүчин зүйлд тулгуурласан бодлого, зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай юм. Өнөөгийн нийгэм, эдийн засгийн тодорхой хүчин зүйлүүдийн нөлөөлөл байгаа боловч хүүхдийн амьдрал, аюулгүй байдалд тулгарах аргагүй шалтгаан, нөгөө талаас эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагагүйн улмаас хүүхдийн аюулгүй байдал, эсэн мэнд амьдрах эрхийг нь хамгаалах зайлшгүй шаардлагаар шилжүүлэхээс өөр аргагүй нөхцөл байдалд хүрч байна. Хүүхдийн эрхийн тухай конвенцод оролцогч улс орнууд эцэг, эх, хууль ёсны хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.

Хамгаалалтын ийм арга хэмжээ нь хүүхэд, тэднийг асран халамжилдаг хүмүүст шаардлагатай тусламжийг үзүүлэх зорилгоор нийгмийн хөтөлбөр боловсруулах, түүнчлэн хүүхдэд хэрцгийгээр хандахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, авч хэлэлцэхээр шилжүүлэх, мөрдөн байцаалт явуулах, эмчлэх, шаардлагатай тохиолдолд шүүх ажиллагаа явуулах болон бусад арга хэмжээг тусгасан журмыг агуулна³⁷. Гэр бүлийн орчноосоо түр буюу бүрэн хагацсан, эсхүл ийм орчинд байх нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэхгүй бол хүүхдэд улсаас онцгой хамгаалалт, туслалцаа үзүүлнэ. Оролцогч улс орнууд үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу ийм хүүхдийг өөр орчинд асран халамжлах бололцоог бүрдүүлнэ³⁸ гэж заасны дагуу зайлшгүй шаардлагаар шилжүүлэх шаардлага үүсдэг. Хүүхдийн шилжүүлэх асуудал болон шилжүүлсний дараа тулгарч буй асуудлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Хүүхдийг асран халамжлах сонголт бүхий хувилбарт хамгаалалтын хэлбэрүүдийн талаарх хуулиудын уялдаа тэдгээрийн хамаарал, давхцал, хийдэл, зөрчлийг арилгах, нэг мөр болгох:

Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж буй Гэр бүлийн тухай хуулийг 1999 онд баталсан бөгөөд шинэчлэн боловсруулах ажил өнөөдрийг хүртэл хойшлогдож, хэт удаашралтай байгаагаас гадна түүнээс хойш гэр бүлийн харилцаанд хамаарах нилээдгүй хуулиуд шинээр батлагдсанаар эдгээр хуульд тусгагдсан нэр томъёолол, ойлголт, агуулгын болон зохицуулалтын зөрүүтэй байдлаас хамаарч хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хэрэглэхэд хүндрэл гарах, хуулиас давсан дүрэм, журам, стандартыг тогтоож хэрэгжүүлэхэд хүргэх, үүсээд байгаа юмс үзэгдэлтэй тэмцэх бодит

37 Хүүхдийн эрхийн тухай конвенцын 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, (1989).

38 Хүүхдийн эрхийн тухай конвенцын 20 дугаар зүйлийн 1-2 дахь хэсгүүд, (1989).

боломж бүрдэж чадахгүй болох зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулж байна. Хүний амьдралын анхдагч орчин болох гэр бүл түүний суурь харилцааг зохицуулж байгаа хуулиа нэн тэргүүнд шинэчлэх нь хүний хөгжил, улс үндэснийхээ аюулгүй байдлаа бэхжүүлэх үндсийг бүрдүүлнэ. Иймээс Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлыг нэн яаралтай хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудлын нэг болж байна.

2. Хүүхдийг асарч хүмүүжүүлж буй иргэн, байгууллагад тавих хяналтын талаар:

Хуульд төрөлжсөн асрамжийн үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална. Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах, төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх болон түүний төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж тус тус заасан. Журамд зааснаар асрамжийн газарт олгосон санхүүжилтийн зарцуулалтад нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага тус тус хяналт тавина. Асрамжийн газар нь үйл ажиллагаа, санхүүжилтийн зарцуулалтын тайланг улирал, хагас жилээр, асруулагчдын шилжилт хөдөлгөөний мэдээг сар бүрээр гаргаж, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь асрамжийн газруудын төсөв, орлого, зарлагын улирлын болон жилийн эцсийн нэгдсэн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж санал, дүгнэлтийн хамт нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ³⁹.

Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон бол хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан. Үүнээс үзэхэд асрамж халамжийн үйлчилгээнд гэхээсээ илүү хяналт нь санхүүжилтэд чиглэсэн зохицуулалт голлож байна. Мөн улсын төсвөөс санхүүжилт авсан тохиолдолд уг төсвийн зарцуулалтад хяналт тавихаар байна. Төрөөс санхүүжилт авдаггүй олон улсын байгууллага, хувь иргэний санхүүжилтэй асрамж, халамжийн байгууллагын хувьд дээрх хяналт хийгдэх эсэх нь тодорхойгүй, орхигдож байна.

Харин Нийгмийн халамжийн тухай хуульд нийгмийн ажилтан нь нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх байгууллага, иргэнийг сонгоход оролцох, үйлчилгээнийх

³⁹ Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 03/03 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”.

нь чанарт хяналт тавих, үнэлгээ хийх⁴⁰ эрхтэй байхаар тусгаж өгчээ. Уг хуульд тусгасан хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан мэдээлэл ил тод бус байна. Тиймээс хүүхдийг шилжүүлэн авсан иргэн болон байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд хяналт тавьсан тайлан, үнэлгээг олон нийтэд ил тод байлгах асуудлыг холбогдох байгууллага анхаарч мэдээлдэг байх нь хэрэгтэй байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд энэ хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг дараах байгууллагад хамаарна⁴¹ гэж зааснаас үзэхэд улсаас санхүүждэггүй ихэнх асрамж, халамжийн байгууллагуудын хувьд мэдээлэл өгөх, ил тод байлгах асуудал хуулиар үүрэгжээгүй нь харагдаж байна.

3. Асрамжлуулан халамжлуулж байгаа хүүхдийн мөнгө, тэтгэмжийн зарцуулалт, хяналтын талаар:

Насанд хүрсэн иргэний тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг хуулиар зохицуулж байгаа бол хүүхдийн мөнгөн тэтгэмжийн асуудлыг хэрхэн өгөх, авах талаар асуудлыг журмаар зохицуулж байна. Хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд, эсхүл түүнийг төлөөлөх хууль ёсны эрх бүхий (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд) Монгол Улсын иргэнд олгоно⁴². Бүтэн өнчин, эцэг, эхгүй болон асран хамгаалагч томилогдоогүй зэрэг шалтгаанаар асрамжийн газарт асруулж байгаа хүүхдийн мөнгийг асрамжийн газар нь тухайн хүүхдийн нэр дээр хадгаламжийн данс нээлгэж банкинд хадгалуулна. Хадгаламжийн дэвтрийг тухайн асрамжийн газрын байрлаж байгаа аймаг, дүүргийн Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага хадгалж, хүүхдийг 16 нас хүрч иргэний үнэмлэх авсны дараа өөрт нь хүлээлгэн өгнө. Хэрэв хүүхэд нас барсан тохиолдолд түүний хадгаламжийн дэвтрийг өв залгамжлагчид нь хууль тогтоомжид заасны дагуу хүлээлгэн өгнө. Бүтэн өнчин, эцэг, эхгүй болон асран хамгаалагч тогтоогдоогүй шалтгаанаар асрамжийн газарт амьдарч байгаа хүүхдийн мөнгийг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг харгалзахгүйгээр олгоно. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь асрамжийн газарт амьдарч байгаа хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, регистрийн дугаар, шилжилт хөдөлгөөний мэдээллийг сар бүрийн 5-ны дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ⁴³ гэж тус тус зохицуулсан.

40 Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9.1, (2012).

41 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, (2011).

42 Засгийн газрын 2017 оны 18 дугаар тогтоолын хавсралт "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам" 1.2 дахь заалт.

43 Засгийн газрын 2017 оны 18 дугаар тогтоолын хавсралт "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам", 3.4, 3.9 дэх заалтууд.

Асрамж халамжийн байгууллагад байгаа хүүхдийн хувьд мөнгөн тэтгэмж нь насанд хүртэл хадгалагдаж өөрөө зарцуулах боломжтой байхаар зохицуулсан нь сайн талтай хэдий ч хүүхдийг асран халамжлах, есгөхөд гарч байгаа зардал улсаас санхүүждэггүй асрамж халамжийн байгууллагуудын хувьд зуун хувь өөрөөс гаргаж байгаа асуудлыг эргэн харах шаардлага байна. Олон улсын өмнө хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд үндэсний нөхцөл, хөрөнгө бололцоондоо нийцүүлэн эцэг, эх, хүүхдийн төлөө хариуцлага хүлээж буй бусад хүнд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд материаллаг тусламж, ялангуяа хувцас, орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ⁴⁴ гэж заасан байна. Энэ нь хүүхдийг хамгаалах асуудлыг гэрээний үндсэн дээр даатгаад орхичих асуудал биш, тогтвортой үйлчлэх хөтөлбөр хэрэгжүүлэн шаардлагатай тусламжийг үзүүлэх нь зохистой гэдгийг харуулж байна. Хүүхдийг шилжүүлж авсан иргэний хувьд хууль ёсны эрх бүхий этгээд гэдгээрээ хүүхдийн мөнгийг авах, зарцуулах боломжтой байхаар байна. Харин хүүхдэд хэрхэн зарцуулах, хэрхэн хяналт тавих, зарцуулаагүй тохиолдолд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой зохицуулалт дутмаг байна.

4. Асрамж, халамжийн байгууллагад хүмүүжиж байгаа хүүхдийн хөгжил, төлөвшлийн талаар:

Монголчууд бид хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа гэж хүүхдийн хөгжил, төлөвшилд бага наснаас анхаарч үндэсний өв уламжлал, ёс заншлаа өвлүүлэн уламжлуулах асуудлыг баримталсаар ирсэн нь үндэсний аюулгүй байдалтай салшгүй холбоотой. Орчин үед нийгмийн аливаа асуудлыг хувь хүний хөгжил төлөвшилтэй холбон тайлбарлаж хүн төвтэй бодлого, хүний хөгжлийн асуудлыг чухалд үзэх нь нэн тэргүүний бодлого гэдгийг чухалчлан үзэж буй ч бодит байдал дээр бага балчраас нь хүүхдэд үндэсний өв соёл уламжлалыг хадгалуулах асуудал гэр бүлийн хүрээнд ч асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ч хэрхэн хэрэгжиж биеллээ олж байгаа нь тодорхойгүй байх тул зайлшгүй анхаарах асуудлын нэг мөн. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь Монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим нь эх оронч үндэсний үзлийг дээдлэх бөгөөд Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно⁴⁵ гэж заасан. Үүнээс үзэхэд хүүхдэд багаас нь эх оронч үзлийг төлөвшүүлэх, үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа өвлүүлэх, хамгаалж хөгжүүлэх

44 Хүүхдийн эрхийн тухай конвенцын 27 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, (1989).

45 Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" 1 дүгээр зүйл, (2010).

асуудал нь чухал байр суурь эзэлж анхаарлаа хандуулах асуудал болох нь харагдаж байна.

5. Гэр бүлийн талаарх төрийн эрх зүйн бодлого, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагын талаар:

Төрөөс хүүхдэд мөнгөн тэтгэмж олгож эхэлснээр хүүхдээ гэр бүлдээ авч өсгөхөд эерэгээр нөлөөлж эхэлсэн хэдий ч хүүхдийн мөнгийг хүүхдэд зарцуулах, хүүхдийг асран халамжлах бус архидан согтуурах явдал түгээмэл байна. Сүүлийн жилүүдэд гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэхийн хэрээр хүүхдүүд өртөх, хохирох, хараа хяналтгүй болоход нөлөөлж байна. Улсын хэмжээнд гэр бүлийн эрх зүйн маргаан 2018 онд 4763, 2019 онд 4449, 2020 онд 4732⁴⁶ харин гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүний тоо 2018 онд 1136, 2019 онд 1193, 2020 онд 1152⁴⁷ бүртгэгдсэн байна. Гэр бүлийн маргаан сүүлийн 2 жил өсч, гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх, хүүхдийг зайлшгүй шаардлагаар эрсдэлгүй орчинд шилжүүлэн хүмүүжүүлэх асуудал хөндөгдөж байна.

Монгол Улсад 2017 оноос хүчирхийллийн хохирогчид аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгжийг 3 дахин нэмэгдүүлж, 13 Түр хамгаалах байр, 9 Нэг цэгийн үйлчилгээний төвийг шинээр байгуулж, өнөөдрийн байдлаар 19 Түр хамгаалах байр, 13 Нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байна. Тухайлбал 2020 оны 6 дугаар сард Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд шинээр түр хамгаалах байрууд байгуулсан.

Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвөөр 2019 онд 0-18 хүртэлх насны 2020 хүүхдэд аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн нь 2018 онтой харьцуулахад 47,5 хувиар буюу 651 хүүхдээр өссөн байна. 2020 оны 5 дугаар сарын байдлаар 537 насанд хүрэгч, 948 хүүхэд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хүүхдүүдийн дийлэнх нь буюу 80,2 хувь нь гэр бүлийн орчинд эцэг, эх, асран хамгаалагчдын зүгээс хүчирхийлэлд өртсөн байна. Гэр бүлийн нөхцөл байдлыг судлахад тухайн гэр бүлд архины хамааралтай, зан үйлийн өөрчлөлттэй эцэг, эх, асран хамгаалагчтай, эрхэлсэн тодорхой ажилгүй, салсан, нийлсэн гэр бүлүүд 60 орчим хувийг эзэлж байгаа⁴⁸ нь хүүхдийг аюулгүй орчинд шилжүүлэх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, өсгөн хүмүүжүүлэх шаардлага байгааг харуулж байна.

46 Шүүхийн ерөнхий зөвлөл "Монгол Улсын шүүхийн тайлан" 2019, 2020 оны тайлангуудаас судалгааг авч нэгтгэв.

47 Шүүхийн ерөнхий зөвлөл "Монгол Улсын шүүхийн тайлан" 2019, 2020 оны тайлангуудаас судалгааг авч нэгтгэв.

48 <http://www.fcy.gov.mn/news/178>

Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд харагчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах⁴⁹ үйл ажиллагаа явуулна гэж заасан бөгөөд эцэг, эхчүүдэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх, хүмүүжлийн эерэг хандлага, арил барил олгох сургалтыг тогтмол явуулж эцэг, эхэд хүүхдээ хүмүүжүүлэх, хүүхэдтэйгээ зөв харилцах харилцааны боловсрол олгох нь хүүхдийг гэр бүлийн орчинд эрхийг нь хамгаалахад чухал нөлөөтэй юм. Үүнээс дүгнэхэд гэр бүлийн тогтвортой байдал, төлөвлөлт, хүний хөгжлийн асуудалд анхаарах хэрэгцээ, шаардлага байна.

III. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Гадаадын зарим улс орны хүүхэд хамгааллын туршлагаас авч үзвэл Сингапур, Япон зэрэг улсын хүүхэд хамгааллын тогтолцоо сайн хөгжсөн гэж судлаачид үздэг байна. Сингапур Улсын хувьд хүүхдийн халамжийн үйлчилгээний зөвшөөрөл, хяналт тавих стандарт (Child care centres act) тогтоосон, хүүхдийн хамгаалал, халамжийн үйлчилгээний газар (Ministry of community development and sports) хариуцдаг, хүүхэд гэртээ байж болохгүй нөхцөл үүсвэл түр асрамжлах, гэр бүл эргэн нэгтгэх эсхүл халамжийн төвд өгдөг байна. Сингапур Улсад гэр бүлийн хүчирхийлэл цөөн гардаг, гэр бүлийн орчинд хүүхдийн эрх хөндөгдөх асуудал бага байгаа шалтгааныг гэр бүлд чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлдэгтэй холбон үзэж болох юм. Тухайлбал хүүхэд хүмүүжүүлэх талаарх эцэг, эхэд зориулсан сургалт, гэр бүлийн харилцааны зөвлөгөө, сургалт, гэр бүлийн санхүүгийн сургалт гэх мэтчилэн сургалтаар дамжуулан гэр бүлийн асуудлыг шийдвэрлэх арга барил, зөвлөгөө өгч ажилладаг нь үр нөлөө үзүүлдэг байна.

Оросын Холбооны Улсын тухайд Гэр бүлийн тухай хуулиар эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхэд тэдний эрх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үрчлэх, асран хамгаалах, хүмүүжүүлэх, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх тэднийг авах, гэр бүлд шилжүүлэх болон бусад асуудлыг зохицуулдаг байна. Гэр бүл дэх хүүхдийн асрамжийн газрыг байгуулахад эхнэр, нөхөр хоёр өөрийн хүсэлтээр 5-10 хүүхдийг гэр бүлд тулгуурлан асран хүмүүжүүлж болохыг зөвшөөрсөн⁵⁰ байна.

Өнчин болон эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхдийн нийгмийн халамжийн нэмэлт баталгааны тухай хуулиар эцэг, эхийн асаргаагүй үлдсэн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, зэвсэгт мөргөлдөөн болон олон үндэстний зөрчилдөөн, байгалийн болон технологийн гамшигт өртсөн,

⁴⁹ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.6, (2016).

⁵⁰ Оросын Холбооны Улсын "Гэр бүл дэх хүүхдийн асрамжийн газрын тухай" Засгийн газрын 2001 оны 195 дугаар тогтоол.

дүрвэгсэд болон албадан нүүлгэн шилжүүлж байгаа гэр бүлийн хүүхэд, хүчирхийллийн хохирогч хүүхэд, бага орлоготой өрхөд амьдарч байгаа хүүхэд, амьдралын нөхцөлд нь хүндрэл учирч үүнийг өөрийн эсхүл гэр бүлийн тусламжтайгаар даван туулах боломжгүй зэрэг шалтгаантай хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзэж тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс нь Хүүхдийн тухай хуульдаа хүүхдийг асран хамгаалах хүнгүй, хаягдсан, тухайн хүүхдийн асран хамгаалагч хүүхдийг цаашид орон байраар хангах болон асран халамжлах чадваргүй болсон, хүүхэд 16 нас хүрсэн боловч аюултай байдалд орсон эсхүл орох боломжтой гэж хороо үзсэн, хүүхдийн аюулгүй байдал зөрчигдөж байна гэж үзсэн тохиолдолд тухайн дүүрэг нь хүүхдийг орон байраар хангах, хүүхдийг орон байраар хангахын өмнө тухайн хүүхдийн саналыг сонсох ба шаардлагатай тохиолдолд гуравдагч этгээдээс дүгнэлт гаргуулна⁵¹. Мөн тухайн дүүрэг эсхүл хүсэлт гаргагч этгээд хүүхдэд эрүүл мэнд сэтгэл санааны аюултай байдалд орсон эсхүл орох магадлалтай гэж үзвэл хүүхдийг өөрийн асран хамгаалтад авах хүсэлтээ шүүхэд гаргана. Шүүх нь хүүхдэд эрүүл мэнд сэтгэл санааны аюултай байдалд орсон, эсхүл орох магадлалтай гэж үзсэн болон хүүхэд эцэг, эхийн хяналтаас гарсан тохиолдолд хүүхдийг төрийн болон хүсэлт гаргасан этгээдийн асран хамгаалалтад өгөх шийдвэрийг аль нэгийг гаргана⁵² гэж хуульчилсан байна.

Австрали Улс нь хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцоо болон төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс хүүхдэд үзүүлж буй дэмжлэг тусалцааны хувьд дэлхийд тэргүүлэх байр суурьтай байгаа бөгөөд хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хангахад ихээхэн анхаардаг жишиг болохуйц сайн туршлагатай орны нэг юм⁵³.

Тус улсын Хүүхдийн тухай, Нийгмийн үйлчилгээний тухай хуулиуд нь хүүхэд хамгааллын гол хууль бөгөөд Хүүхэд үрчлэх тухай, Хүүхдийн асрамж үйлчилгээний тухай, Хүүхдийн тухай, Нийгмийн үйлчилгээний тухай гэх мэт хуулиудаар гэрээс гадуурх асрамжийн үйлчилгээ, асрамжийн дараах дэмжлэг, гэр бүл болон хүүхэд асрамжийн үйлчилгээ, хүүхэд үрчлэх болон асран хамгаалалтай холбоотой асуудлыг зохицуулж байна. Гэрээс гадуурх асрамжийн үйлчилгээ (out of home care) нь гэр бүлийн хүчирхийлэл болон бусад шалтгааны улмаас гэр бүлдээ амьдрах боломжгүй хүүхдэд үзүүлэх үйлчилгээ бөгөөд хүүхэд хамгааллын хамгийн эцсийн шатны хууль ёсны арга хэмжээ юм. Эцэг, эх хүүхдээ уг үйлчилгээнд сайн дураар хамруулж болох боловч ихэнх тохиолдолд

51 Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйл, (1989).

52 Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, (1989).

53 Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн "Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, тогтолцоо ба хэрэгжүүлэх механизмын талаарх гадаадын зарим орны туршлага" судалгаа УБ, 2018 он, 4 дүгээр хуудас.

шүүхийн шийдвэрээр гүйцэтгэдэг. Мөн Австрали Улсын хувьд асрамжийн дараах үйлчилгээнд асрамж халамжийн байгууллагаас гарч буй тодорхой насанд хүрсэн хүнийг хамруулан амьдрах нөхцөл, дасан зохицох бие даан амьдрах боломжийг бүрдүүлэхэд анхаардаг давуу талтай байна⁵⁴.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь 2020 онд Иргэний хуулиа баталж, уг хууль нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэхээс өмнө хүүхэд шилжүүлэх, үрчлэхтэй холбоотой асуудлыг зохицуулж байсан Хүүхэд үрчлэх тухай хууль нь хүчингүй болж, Иргэний хуулиараа зохицуулж байна. Мөн насанд хүрээгүй хүнийг хамгаалах тусгай хуультай байна. Иргэний хуульд өнчин хүүхдүүдийн асран хамгаалагч, нийгмийн халамжийн газар, онцгой бэрхшээлтэй, хүүхдээ өсгөх чадваргүй төрсөн эцэг, эх нь иргэн, байгууллагад хүүхдээ үрчлүүлэн өгч болно⁵⁵.

Хүүхэд үрчлэхэд тухайн хүүхдэд хамгийн ашигтай байх зарчмыг баримталж, үрчлэгдсэн болон үрчлэн авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаална. Насанд хүрээгүй хүүхдийг үрчлэх нэрээр худалдаж авах, худалдахыг хориглоно⁵⁶ гэж заасан байна. Нийгмийн халамжийн байгууллага нь өнчин, хаягдсан нярай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдлыг шалгах тогтолцоотой. Дүүргийн иргэний хэргийн хэлтэс (хот, дүүрэг) өнчин, хаягдсан нярай хүүхдийг хүүхдийн халамжийн байгууллага, нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлэх эсэхийг шийдвэрлэх эрхтэй байна. Өнчин, хаягдсан нярай хүүхдийг хүүхдийн халамжийн болон нийгмийн халамжийн төвүүдэд шилжүүлэхдээ үрчлүүлэхээр илгээсэн хүн тухайн орон нутгийн иргэний хэргийн хэлтэстэй холбоо барих үүрэгтэй байна. Үрчлүүлэхээр илгээсэн этгээд гэдэг нь өнчин, хаягдсан нярай хүүхдийн халамжийн байгууллага, нийгмийн халамжийн байгууллагад орох асуудлыг шууд хянан шийдвэрлэдэг иргэн, агентлаг, байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, тосгоны (орон сууцны) хороо, өнчин хүүхдийн хууль ёсны асран хамгаалагчдыг хэлдэг байна.

Насанд хүрээгүй хүний эцэг, эх нь насанд хүрээгүй хүний асран хамгаалагч байна. Хэрэв насанд хүрээгүй хүний эцэг, эх нас барсан эсвэл асран хамгаалах чадваргүй бол эмээ, өвөө, ойр дотны хамаатан садан найз, нөхөд зэрэг асран хамгаалах чадвартай хүн асран хамгаалагч байх бөгөөд насанд хүрээгүй хүний оршин суудаг газрын оршин суугчдын хороо, тосгоны хорооноос зөвшөөрөл авна.

Насанд хүрээгүй хүнийг хамгаалах тухай хуульд мужийн түвшний болон түүнээс дээшхи ардын Засгийн газар, тэдгээрийн Иргэний хэргийн яам

54 Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн “Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, тогтолцоо ба хэрэгжүүлэх механизмын талаарх Гадаадын зарим орны туршлага” судалгаа, УБ, 2018 он, 36-46 дугаар хуудас.

55 Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Иргэний хуулийн 5 дугаар хэсэг, 5 дугаар бүлэг-Үрчлэл 1094 дүгээр зүйл, (2020).

56 Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Иргэний хуулийн 5 дугаар хэсэг, 1 бүлэг 1044 дүгээр зүйл, (2020).

шаардлагатай бол туслалцаа үзүүлэх тусламжийн газрыг байгуулж, тэнэмэл гуйлга гуйдаг гэх мэт хүнд амьдралтай насанд хүрээгүй хүнд тусламж үзүүлж, түр асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг хүлээх ба цагдаагийн байгууллага болон бусад холбогдох байгууллага нь тэнэмэл, гуйлга гуйж байгаа болон гэрээсээ зугтсан хүүхдийг тусламжийн газарт хүргэж өгнө. Тусламжийн газарт хүүхдийг зохих ёсоор асран хамгаалж, даруй эцэг, эх болон бусад асран хамгаалагчид нь мэдэгдэж буцааж өгнө. Өнчин, эцэг, эх, асран хамгаалагчийг нь тогтоож чадахгүй байгаа болон бусад амьдрах чадваргүй насанд хүрээгүй хүнийг Иргэний хэргийн яамнаас байгуулсан Хүүхдийн халамжийн байгууллагад үлдээж хүмүүжүүлнэ. Насанд хүрээгүй хүний тусламжийн байгууллага болон хүүхдийн халамжийн байгууллага цаашлаад ажилтнууд нь хууль тогтоомжийн дагуу ажил үүргээ гүйцэтгэж, насанд хүрээгүй хүнийг хүчирхийлэх, ялгаварлан гадуурхах ёсгүй, хүүхдийг үлдээх, хүмүүжүүлэх ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил гаргаж болохгүй⁵⁷ хэмээн заасан.

Ихэнх улс орны хувьд хүүхэд бүр өөрийн гэр бүлд эсвэл гэр бүлтэй дүйцэх орчин нөхцөлд амьдрах ёстой, халамж, асрамжийн газар бол эцсийн хувилбар гэсэн зарчмыг баримталж байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хувьд Иргэний хэргийн яамнаас байгуулсан хүүхдийн халамжийн байгууллагад хүмүүжүүлж насанд хүрээгүй хүнийг хамгаалах тухай хуулиараа насанд хүрээгүй хүний бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, насанд хүрээгүй хүний ёс суртахуун, оюун ухаан, бие бялдар, урлагийн хөдөлмөрийг цогцоор нь хөгжүүлэх, үзэл баримтлал, ёс зүй, соёл, сахилга батыг төлөвшүүлэх, залгамжлагч шинэ үеийн иргэдийг бэлтгэх зорилго тавьсан нь хүүхдийн асуудалд анхаарлаа хандуулж буйн тод илэрхийлэл юм.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

57 Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Насанд хүрээгүй хүнийг хамгаалах тухай хуулийн 43 дугаар зүйл, (2020).

IV. ДҮГНЭЛТ

Хүүхдийн эрхийн тухай конвенцод Монгол Улс нэгдэн орсноор Засгийн газар, бүх салбарын байгууллагууд, хүн бүр хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах үүргийг хүлээсэн. Иймд тухайн үүргийг биелүүлэхэд төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, бүх хэлбэрийн хуулийн этгээд, иргэний хамтын ажиллагаа, оролцоо чухлыг сурталчлан таниулах, мэдээлэх, мэдээллийн нэгдсэн санд тулгуурласан суурь судалгаа хийх нь хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд нэн чухал ач холбогдолтой байна.

Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрт заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нас, хүйс, газар зүйн байршил, нийгэм, эдийн засгийн байдал зэрэг үзүүлэлтээр гаргаж дүн шинжилгээ хийх, зөвлөмжийг хэрэгжүүлэх⁵⁸ гэж заасан боловч харилцан адилгүй хэрэгжиж байгаа нь хууль тогтоомжийн биелэлт хангалтгүй, тэдгээрийг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулж ажиллахгүй байгааг илтгэнэ. Тиймээс гэр бүл, хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч, хуулийн механизмын “оновчтой байх”, “үр нөлөөтэй байх”, “хүүхдэд ээлтэй байх” зарчим түүний агуулгад нийцүүлэн үр нөлөөг судлах зохицуулалт-хамгаалалт-хариуцлагын оновчтой нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх асуудалд анхаарал хандуулах нь чухал юм. Хүүхдийг асран халамжлах тухайлбал “эцэг, эхийг орлох, гэр бүлтэй дүйцэх орчинд хэрэгжүүлэх асран хамгаалалтын хэлбэр”-үүд нь хамгаалалтын онцгой хэлбэр бөгөөд хүүхдийн нөхцөл байдлыг судлан тогтоох, дүгнэлт гаргуулах, гуравдагч этгээдийг оролцуулах, асран хамгаалалтын хэлбэрүүдийг сонгох, шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх гэх мэт тодорхой дарааллаар хэрэгжүүлэх цогц үйл ажиллагаа буюу процессын шинжтэй тул (стандартаар хязгаарлах боломжгүй) хуулиар нарийвчлан зохицуулагдах харилцаа болно. Мөн хүүхдийг асран халамжлах сонголт бүхий хувилбарыг тодорхой хуульчлахын зэрэгцээ “хувь хүний асран хамгаалалт”, “эд хөрөнгийн хамгаалалт”-ыг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай.

Хүний хөгжлийн анхдагч орчин, нийгмийн хөгжлийн үндсэн нэгж болсон гэр бүлийн амьдралд эцэг, эх, үр хүүхдээ дээдлэх, эв эеийг хичээх, эрдэм номыг шүтэх, өв уламжлалаа нандигнах соёл, зан заншил нь монгол гэр бүлийн өвөрмөц үнэт зүйл мөн боловч, гэр бүлдээ хүчирхийлэл үйлдэх, хүүхдээ үл хайхрах, гэр бүл салах, хүүхэдтэй зүй бус харьцах, эцэг, эхийн үүрэг хариуцлагаа ухамсарлахгүй байна. Энэ нь хүүхдийн өсөж хүмүүжих гол орчин болох гэр бүлд боловсрол олгох, гэр бүл төлөвлөлтийн асуудалд анхаарал хандуулж, гадаадын зарим улс орны туршлагаар эцэг, эхэд зориулсан сургалтыг тогтмол зохион байгуулж, эцэг, эхийн харилцаа, хандлагыг өөрчлөх хэрэгцээ, шаардлага байна.

58 Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын Үндэсний хөтөлбөр”-ийн 3.3.2.2 дахь заалт.

Хүүхдийг холбогдох хуульд заасан журмын дагуу шилжүүлэн авч өсгөн хүмүүжүүлж буй асран хамгаалагч, харгалзан дэмжигч, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих нийгмийн ажилтнуудын тоог нэмэгдүүлэх, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй юм. Хүүхдэд ногдох нийгмийн ажилтнуудын тоо харилцан адилгүй, цөөн байгаа нь үүргээ гүйцэтгэхэд тодорхой хэмжээнд нөлөөлж байна.

V. НОМ ЗҮЙ

1. Монгол эх сурвалж:

1. Я.Цэвэл, “Монгол хэлний их тайлбар толь”, УБ, 2016 он.
2. Шүүхийн ерөнхий зөвлөл, “Монгол Улсын шүүхийн тайлан”, УБ, 2019-2020 он.
3. Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба “Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн хэсэгчилсэн судалгаа”, УБ, 2019 он.
4. Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн “Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчин, тогтолцоо ба хэрэгжүүлэх механизмын талаарх гадаадын зарим орны туршлага” судалгаа, УБ, 2018 он.

2. Гадаад эх сурвалж:

1. Оросын Холбооны Улсын “Гэр бүл дэх хүүхдийн асрамжийн газрын тухай” Засгийн газрын 2001 оны 195 дугаар тогтоол.
2. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, (1989).
3. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Иргэний хууль, (2020).
4. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Насанд хүрээгүй хүнийг хамгаалах тухай хууль, (2020).

3. Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Гэр бүлийн тухай хууль, (1999).
3. Хүүхдийн эрхийн тухай хууль, (2016).
4. Хүүхэд хамгааллын тухай хууль, (2016).
5. Нийгмийн халамжийн тухай хууль, (2012).
6. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, (2011).
7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 60 дугаар зарлиг.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

8. Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 03/03 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”.
9. Засгийн газрын 2017 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”.
10. Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын Үндэсний хөтөлбөр”.
11. Хүүхдийн эрхийн тухай конвенц, (1989).
12. Стандарт, хэмжил зүйн газар, “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS58525:2017.

4. Бусад:

1. <http://www.fcy.gov.mn/news/178>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



С.ГАНЦЭЦЭГ

Удирдлагын академийн
Эрх зүйн тэнхмийн багш

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES IN ADDRESSING LEGAL REGULATIONS OF LEGAL AID

Хураангуй: Хууль зүйн туслалцаа гэх өргөн хүрээтэй ойлголтыг эрүүгийн, иргэний, захиргааны хэрэгт холбогдсон, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болон хөндөгдсөн аливаа этгээдэд хамааралтай гэсэн хүрээгээр ойлгох нь түгээмэл боловч өнөөдөр хууль зүйн туслалцааны хүртээмжийн асуудлыг хөндөх шаардлага үүсч байна.

Түлхүүр үг: Хууль зүйн туслалцаа, эрүүгийн хэрэг, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, төлбөрийн чадваргүй иргэн, өмгөөллийн үйл ажиллагаа

Abstract: The broad concept of legal aid applies to any person involved in criminal, civil or administrative cases, whose rights and legitimate interests have been violated or affected, but there is a need to address the issue of access to legal aid.

Keywords: Legal aid, criminal cases, legal profession, insolvent citizen, advocacy.

I. ОРШИЛ

“Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй”, “Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй” гэж хүний эрхийн олон улсын хэмжээнд баталгаажуулж, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд заасан байна. Энэ нь иргэн эрхээ хамгаалуулах тэгш боломжийг нээж, нөгөө талаас гэмт хэрэгт сэжиглэгдэж буй аливаа этгээд хууль зүйн туслалцаа авах боломжтой гэдгийг илэрхийлнэ¹.


Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалтад “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх заалт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь заалтад “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэж тус тус заасан. Үндсэн хуулиар баталгаажсан Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх, төрөөс иргэнийхээ өмнө хариуцсан үүргийг биелүүлэх зорилгоор сүүлийн жилүүдэд нилээдгүй хууль тогтоомж батлагдан гарч, хүчин төгөлдөр үйлчилж байгаа нь иргэн хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэх боломжтой билээ.

II. ҮНДСЭН ХЭСЭГ: ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА БА ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ХҮРЧ БҮЙ ХҮРТЭЭМЖ:

Хууль зүйн туслалцаа хэмээх өргөн хүрээтэй ухагдахуунд нэг талаас туслалцаа үзүүлэгч нөгөө талаас туслалцаа хүсэгч талын хүсэл зориг илэрхийлэгдэх ёстой. Үүний цаана туслалцаа үзүүлэгчийн үйлчилгээний хөлс, төлбөр зайлшгүй хөндөгдөх зүйл болно. Өөрөөр хэлбэл хууль зүйн туслалцаа гэдгийн цаана төлбөрийн асуудал хөндөгдөх бөгөөд зорилтот бүлэгт хамаарах иргэн² гэмт хэрэгт ялагдсан тохиолдолд төрөөс Үндсэн

¹ Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

² Энд дурдсан зорилтот бүлэгт хамаарах иргэн гэдгийг Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 7 дугаар зүйлийн 7.2.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.4-т тус тус заасан хүрээнд ойлгоно.



хуульд заасан эрхээ эдлэх боломжийг хангах үүднээс холбогдох хууль тогтоомж буюу Өмгөөллийн тухай хуулийг шинэчлэн баталж хэрэгжүүлж байна.

Хууль зүйн туслалцаа нь өргөн хүрээтэй ойлголт болохын хувьд үүнд зөвхөн иргэн, хуулийн этгээдийг шүүхэд төлөөлөх, өмгөөлөхөөс гадна хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа ч багтана.

Гэвч өнөөгийн нийгмийн харилцаанд эрх нь зөрчигдсөн гэх, гэмт хэрэгт сэжиглэгдэж буй иргэн бүр өмгөөлөгч хөлслөн авах боломж нь эдийн засгийн хувьд бүрдээгүй. Иймээс төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч авах боломжгүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрхээ хамгаалж чадахгүй байгаа, эрх нь зөрчигдөх магадлал бүхий иргэдэд Үндсэн хуульд заасан хууль зүйн туслалцаа авах, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог төрөөс бүрдүүлж өгсөн төдийгүй “Улсын өмгөөлөгч” гэдэг статус бүхий өмгөөлөгчтэй болж, төлбөрийн чадваргүй яллагдагчид төрөөс Улсын өмгөөлөгчөөр дамжуулан үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж байна³.

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин нь Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай болон бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.14 дэх хэсэгт хууль зүйн туслалцааны хүрээг “Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзэж байгаа хүн, хуулийн этгээд өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй, хүн, хуулийн этгээд хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа авах, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх боломж, нөхцөл, цаг хугацаагаар хангагдана” гэж зохицуулсан.

Хууль зүйн туслалцааг Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуульд хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх гэж тогтоожээ. Гэхдээ энэ хуульд зааснаар Улсын өмгөөлөгч зөвхөн гэмт хэрэгт буруутгагдан шалгагдаж байгаа яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх байдлаар хязгаарлагдана.

Монгол Улс зах зээлийн эдийн засагтай, ардчилсан нийгэмд шилжсэнээр аливаа салбарын мэргэжлийн ажил, үйлчилгээ нь чөлөөт өрсөлдөөнд суурилан өөрөө өөрийгөө санхүүжүүлэх болсны нэг нь өмгөөлөл, хууль зүйн үйлчилгээ гэж хэлж болно.

3 Хууль зүйн туслалцааны төв, “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмж” судалгаа, УБ, 2016 он, 4 дэх тал.

Энэ нь нэг талаас тухайн салбарыг хөгжүүлэх гол хүчин зүйл боловч нөгөө талаас хөрөнгө, санхүүгийн бэрхшээлтэй, төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг авч чадахгүйн улмаас эрх нь зөрчигдөх, цаашилбал улсын хэмжээнд хууль зүйн үйлчилгээний хүртээмж хумигдан, хязгаарлагдах сөрөг үр дагаврыг дагуулах болсон.

Улмаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.11-т "... төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заан Монголын Хуульчдын холбооны Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо ажиллаж байна. Эндээс үзвэл хууль зүйн туслалцааг өмгөөлөгчийн төлбөртэй үйлчилгээг авах боломжгүй иргэдэд Хуульчдын холбооны дэргэдэх Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо болон Хууль зүйн туслалцааны төвөөр дамжуулан үзүүлж байна.

Гэвч энэ 2 байгууллага нь ижил төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг хэдий ч харьяалал нь ялгаатай байгаа нь учир дутагдалтай байна. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо нь 141 өмгөөлөгч гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа бол Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд 2014 онд Хууль зүйн туслалцааны төвийг байгуулан төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлж байна.

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо нь 2013 онд байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш 4 жилийн хугацаанд нийт 638 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд үүний 424 нь иргэний хэргийн оролцогч, 207 нь эрүүгийн хэргийн хохирогч, 98 нь захиргааны хэргийн оролцогч байжээ⁴. Хууль зүйн туслалцааны төв болон тус хорооноос нийт төлбөрийн чадваргүй 8,247 иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлснээс Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо нь 2,238 хүнд буюу 27,1 хувьд туслалцаа үзүүлжээ.

Уг хороонд сайн дурын гишүүнчлэлтэй 141 өмгөөлөгч бүртгэлтэй бөгөөд төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны зардлыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт "...төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардлыг төр хариуцна" гэж заасан боловч уг санхүүжилтийг хаанаас, яаж олгох, хэдий хэмжээний санхүүжилтийг ямар журмаар гаргах зэрэг асуудал нь тодорхой тусгагдаагүй байна.

4 Хууль зүйн туслалцааны төв болон Монголын Хуульчдын холбооны 2014-2015 оны хууль зүйн үйлчилгээний тоон үзүүлэлт. (Дээрх оноос хойшхи хугацааны тоон мэдээлэл нэгтгэгдээгүй байсан болно).

Иймд сайн дурын гишүүнчлэлтэй өмгөөлөгчид төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд урамшууллын тогтолцоо бүрдээгүйгээс пробоно үйл ажиллагаа явуулах идэвхийг бууруулах, үйл ажиллагааг огт явуулахгүй байх, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол тууштай хамгаалагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Төлбөрийн чадваргүй иргэдэд тус хорооноос хууль зүйн туслалцааг үзүүлэх нь үйлчлүүлэгч өмгөөлөгчөө өөрөө сонгох боломжийг түлхүү олгох нь хууль зүйн туслалцааны төвөөс энэхүү үйлчилгээг үзүүлэх нь хүртээмжийн хувьд нэмэгдэх сайн талтай юм.

Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “Өмгөөлөгч нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлнэ. Өмгөөлөгч энэ хуульд заасан нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор өөрийн нэрийн өмнөөс төрийн байгууллага, шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй” гэсэн шинэ зохицуулалт орсон.

Монголын Хуульчдын холбооны мэдээллээс үзэхэд⁵ өмгөөлөгчид төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд урамшууллын тогтолцоо бүрдээгүйгээс пробоно үйл ажиллагаа явуулах идэвхийг бууруулах, үйл ажиллагааг огт явуулахгүй байх, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол тууштай хамгаалахгүй байх зэрэг сөрөг үр дагавар үүсч байна.

Япон Улсад эрүүгийн хэргийн холбогдогчид улсаас төлбөрийг гарган өмгөөлөгч томилдог тогтолцоотой байна. Улсаас өмгөөлөгч томилох ажлыг шүүхийн байгууллага гүйцэтгэдэг бөгөөд зардал, мөнгө нь ч шүүхээс гардаг ба шүүхээс аль өмгөөлөгч хэрэг дээр ажиллахыг нь зааж өгдөггүй байна. Шүүхээс Өмгөөлөгчдийн холбоонд хэргийн материалыг явуулан, түүнийг нь өмгөөлөгчид үзэж танилцаад өөрсдөө аль хэрэг дээр ажиллахаа сонгодог байна⁶.

Хууль зүйн туслалцааны төвийн статистик мэдээнээс⁷ үзэхэд Улсын өмгөөлөгчдөөс хэрэг, маргааны төрөл харгалзахгүйгээр 2015 онд төлбөрийн чадваргүй 7,351, 2016 онд 8,363, 2017 онд 6,631 иргэнд тус тус хууль зүйн зөвлөгөө өгч ажиллажээ.

Энэ нь нэг талаас Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2-т заасан Улсын өмгөөлөгчийн хориглох үйл ажиллагаанд хамаарах боловч нөгөө талаас

5 <https://www.mglbar.mn/?action=departments&id=41>

6 *Мика Изка, Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа, Өмгөөлөгч судлал, УБ, 2011 он, 290 дэх тал.*

7 *Хууль зүйн туслалцааны төвийн салбаруудын үйл ажиллагааны 2015-2017 онуудын жилийн эцсийн тайлан.*

Хууль зүйн туслалцааны төв байгуулагдахаас өмнө Эрх зүйн туслалцааны төв хэргийн төрөл хамаарахгүйгээр хууль зүйн зөвлөгөө өгч ажиллаж байсан нь иргэдийн дунд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах бодит хэрэгцээ, шаардлага байгаатай холбоотой.

Үүнээс гадна хууль зүйн туслалцааг үзүүлэгч гол этгээд нь өмгөөлөгч бөгөөд өнөөгийн байдлаар өмгөөлөгчид Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Хуульчдын холбоо гэсэн байгууллагад зэрэг харьяалалтай байгаа нь учир дутагдалтай гэж зарим судлаачид үздэг байсан. Учир нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль үйлчилж эхэлснээр хуучин үйлчилж байсан Өмгөөллийн тухай 2002 оны хууль хүчингүй болсон.

Харин 2019 онд Өмгөөллийн тухай хуулийг шинэчлэн баталснаар Үндсэн хуульд заасан иргэний өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэгч өмгөөлөгчдийн үйл ажиллагаанд хамааралтай бүхий л шийдвэрийг мэргэжлийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй чиг үүргийн хувьд байнгын ашиг, сонирхлын зөрчилтэй байдаг шүүгч, прокурорын давуу оролцоотойгоор шийдвэрлэдэг эрх зүйн орчныг бий болгосон, хуульчийн шалгалтад тэнцсэн хэн боловч Улсын Дээд шүүхэд бүртгүүлснээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх болсон нь өмгөөллийн үйл ажиллагааны бие даасан, өмгөөлөгчийн хараат бус байдлыг эрсдэлд оруулаад зогсохгүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны чанар, үр дүнд сөргөөр нөлөөлж байсныг зогсоох боломж бүрдсэн⁸.

Прокурорын тухай, Шүүхийн захиргааны тухай хуулиудад прокурорын болон шүүгчийн ёс зүй, сахилгын хариуцлагын асуудлаар Прокурорын ёс зүйн зөвлөл болон Шүүхийн ёс зүйн хороо үйл ажиллагаа явуулахаар тус тус зааж, ингэснээр Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо нь зөвхөн өмгөөлөгчдөд холбогдох маргааныг хянан шийдвэрлэж байгаа бөгөөд тус хороо нь зөвхөн өмгөөлөгчдөд хамаарах байдал бий болсон нь хуулийн гол үзэл санааны нэг болох хуульчийн нэгдсэн хариуцлагын тогтолцоог үгүйсгэсэн, түүнийг практикт хэрэгжих боломжгүй болгосныг шинэ Өмгөөллийн тухай хуулиар засах боломжийг бүрдүүлжээ.

Түүнчлэн хуульд заасан “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэх нэр томъёоны талаарх зохицуулалтыг Үндсэн хуульд нийцээгүй үндэслэлээр хүчингүй болгосноор хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэж юу болох талаар тодорхойгүй байдал үүссээр байна. Учир нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нэг хэлбэр нь хууль зүйн туслалцаа билээ. Харин Өмгөөллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд өмгөөллийн үйл ажиллагааг тодорхойлохдоо өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль

⁸ Улсын Их Хурлын Тамгын газар, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, УБ, 2017 он, 1 дэх тал.

зүйн мэргэжлийн туслалцаа, үйлчилгээг хамруулсан нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль дахь мэргэжлийн үйл ажиллагааг хууль зүйн туслалцаа гэдэг талаас нь нарийвчилсан зохицуулалт болжээ.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдаж, Хууль зүйн туслалцааны төв байгуулагдан ажилласнаас хойш 2014 онд 1,891 хэргийн 2,102, 2015 онд 2,888 хэргийн 3,145, 2016 онд 2,482 хэргийн 2,749, 2017 онд 2,687 эрүүгийн хэргийн 2,904 холбогдогчид тус тус өмгөөллийн үйлчилгээ үзүүлснээс 1,732 хэргийг шүүхээр, 188 хэргийг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлсэн байна⁹.

Монгол Улсын шүүхийн 2017 онд шийдвэрлэсэн нийт хэргээс үзэхэд анхан шатны шүүх эрүүгийн 8,839, иргэний 45,233, захиргааны 1,908, нийт 55,980 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэжээ¹⁰. Тодруулбал шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 19,5 орчим хувьд нь Улсын өмгөөлөгч ажиллаж байна.

Харин 2017 оны байдлаар Улсын өмгөөлөгч нь нийт өмгөөлөгчдийн 2,5 хувийг эзэлж байгаа ба 2014-2016 онд дунджаар нийт шийдвэрлэгдэж буй эрүүгийн хэргийн 30,8 хувьд Улсын өмгөөлөгч оролцсон байна¹¹.

Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай төлбөрийн чадваргүй бүлэгт 90,9 хувь нь “сэжигтэн, яллагдагч”, 50 хувь нь “хөгжлийн бэрхшээлтэй иргэд”, 43,1 хувь нь “хохирогч”, 43,1 хувь нь “насанд хүрээгүй этгээд”, 18,1 хувь нь “иргэн болон захиргааны хэргийн зохигчид” байгаа нь Улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгт хамрагдахгүй этгээд юм. Өөрөөр хэлбэл эрүүгийн хэргийн хохирогч, иргэн болон захиргааны хэргийн оролцогчдын зүгээс хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээ авах хүсэлтийн хувьд 50 хувь нь “байнга”, 38,6 хувь нь “хааяа”, 6,8 хувь нь “үгүй” буюу туслалцаа аваагүй байна.

Харин Хууль зүйн туслалцааны төвийн чиг үүрэгт хамаарахгүй чиглэлээр хууль зүйн туслалцаа авахыг хүссэн иргэдийн хүсэлтийг хэрхэн шийдвэрлэж байгааг үзэхэд 29,5 хувь нь “Монголын Хуульчдын холбооны Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороонд хүсэлтийг шилжүүлдэг”, 9 хувь нь “Монголын Өмгөөлөгчдийн холбоо болон хүний эрхийг хамгаалдаг олон нийтийн байгууллагууд руу хүсэлтийг шилжүүлдэг”, 34 хувь нь “бусад” хэлбэрээр шийдвэрлэжээ.

Хууль зүйн туслалцааны төвөөс 2020 онд хууль зүйн зөвлөгөө өгсөн тоог

-
- 9 *Хууль зүйн туслалцааны төвийн салбаруудын үйл ажиллагааны 2014-2017 онуудын жилийн эцсийн тайлан.*
- 10 *Монгол Улсын Шүүхийн 2017 оны шүүн таслах ажиллагааны тайлан, УБ, 60 дахь тал.*
- 11 *Монголын Хуульчдын Холбооны цахим хуудас. Хуульчдын тоо, нэгдсэн статистик. <https://www.mglbar.mn/?action=content&view=category&layout=detail&id=23>.*

үзэхэд 11,445 байна. Төрөөс үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ хүссэн иргэдийн тоог үзэхэд 2,747 хэрэгт 2,991 иргэн холбогджээ. Үүнээс насанд хүрээгүй 213, хөгжлийн бэрхшээлтэй 86, бичиг үсэггүй 495, харин бусад нь хууль зүйн анхан шатны зөвлөгөөг авсан зорилтот бүлгийн бус иргэд байна¹².

Өөрөөр хэлбэл дээрх дүнгээс үзэхэд зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагч бус гэмт хэргийн сэжигтэн, хохирогч, иргэний хэргийн зохигч болон захиргааны хэргийн нэхэмжлэгчид үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг илтгэнэ.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль нь зөвхөн эрүүгийн хэргийн яллагдагч гэж гарсан боловч эрүүгийн хэргийн хохирогч, иргэн болон захиргааны хэрэгт зөвлөгөө туслалцаа авч байгаа иргэд дээрх тоон дүнгээс их байгаа харагдаж байна. Эрх зүйн туслалцааны төв байх үед эрүү, иргэн, захиргааны хэрэгт туслалцаа үзүүлж байсан. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль гарснаар зөвхөн эрүүгийн хэрэгт ажиллах болсон. Голчлон ямар хэрэг маргаанд зөвлөгөө авч байсан гэдгийг судлахад захиргааны хэрэгт тэр дундаа газрын маргаан, иргэний хэрэгт үндэслэлгүйгээр ажлаас халагдсан, нийгмийн даатгал төлөөгүй, гэр бүл цуцлалт, тэтгэвэр тэтгэмжийн асуудал байна.

Гэхдээ иргэн, захиргааны хэрэг дээр хууль зүйн туслалцаа үзүүлэх нь асуудалтай бөгөөд нийтийг хавтгайруулан хамруулж болохгүй юм. Харин тодорхой хүрээнд туслалцаа үзүүлж болох юм. Тухайлбал газрын маргаан, гэр бүл цуцлалт, хүүхдийн тэтгэмжтэй холбоотой маргаан зэргийг дурдаж болно.

Өөр үүсч буй нэг асуудал нь Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулиар төлбөрийн чадваргүй гэдгийг хэрхэн тогтоох тухай юм. Төлбөрийн чадваргүй болохыг дараах байдлаар тогтоож байна. Үүнд:

- Эрх бүхий байгууллагын баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн;
- Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болохоо өөрөө тодорхойлсон хүн;
- Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр заасан.

Гэвч гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд Монгол Улсад гэмт

¹² <https://lac.gov.mn/backend/f/JFBt7D0ZJY.JPG>

хэрэгт холбогдсон тохиолдолд тэдгээрийг төлбөрийн чадваргүй эсэхийг тодорхойлох зохицуулалт байхгүй тул хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжгүй байгаа ч Хууль зүйн туслалцааны төвөөс 2014, 2015 онд тус бүр 5, 2016 онд 11, 2019 онд 11 харин 2020 онд 7 гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлжээ¹³.

Улсын өмгөөлөгчдийн 2017-2019 онд шүүхийн болон шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлсэн нийт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:¹⁴

2017 он	2019 он
Хулгайлах 744 буюу 38,7 хувь	Хулгайлах 811 буюу 41 хувь
Хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл санаатай учруулах 435 буюу 23 хувь	Хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол санаатай учруулах 572 буюу 29 хувь
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 129 буюу 6,7 хувь	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 7 буюу 0,3 хувь
Дээрэмдэх 120 буюу 6 хувь	Дээрэмдэх 99 буюу 5 хувь
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих 97 буюу 5 хувь	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих 85 буюу 4,2 хувь
Хүнийг алах 69 буюу 3,6 хувь	Хүнийг алах 47 буюу 2,3 хувь
Бусад гэмт хэрэг 326 буюу 17 хувь	Бусад гэмт хэрэг 365 буюу 18,5 хувь

Дээрх харьцуулсан үзүүлэлтээс харахад үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдийн 39,6 хувь нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон байгаа нь Улсын өмгөөлөгчид хандаж байгаа иргэд нэг талаас амьжиргааны түвшин доогуур, эрхэлсэн тодорхой ажилгүй, өөрийн үйлдлийн учир холбогдол, хариуцлагыг ухамсарлах чадвар сул байгаатай шууд хамааралтай байна. Мөн төлбөрийн чадваргүй иргэдийн холбогдсон гэмт хэргийн тоо өссөн дүнтэй байгаа нь энэхүү өвөрмөц зорилтот бүлэгт ажлын байрны асуудал, боловсролын асуудлыг анхаарах шаардлага байгааг харуулна.

Гадаадын зарим улс оронд хууль зүйн туслалцааг хэрхэн үзүүлж байгааг судлахад Бүгд Найрамдах Казакстан Улсын хувьд өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүйгээр дараах бүлэгт үзүүлж байна. Үүнд:

- Тэжээгчээ алдсан хохирлын нөхөн төлбөр гаргуулах талаар гаргасан

¹³ <http://lac.gov.mn/backend/f/TteNwl9nxR.pdf>

¹⁴ <http://lac.gov.mn/backend/f/TteNwl9nxR.pdf>

- маргааны нэхэмжлэгч;
- Эрүүгийн эрх зүйн зөрчил учруулсан эсхүл ажил хөдөлмөртэй холбоотой эрүүл мэндэд хохирол учирсны улмаас нөхөн төлбөр гаргуулах талаар гаргасан маргааны нэхэмжлэгч;
 - Эх орны дайнд оролцогчид, тэтгэврийн насныхан, 1, 2 дугаар группийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хугацаат цэргийн албан хаагчид, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоогүй маргааны хариуцагч, нэхэмжлэгч;
 - Хуулийн дагуу цагаатгагдсан хохирлыг нөхөн төлбөр гаргуулах маргааны нэхэмжлэгч.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь тус үйлчилгээний хамрах хүрээг гаргахдаа эрүүгийн хэрэг, иргэний хэрэг гэж заагладаг бөгөөд эрүүгийн хэрэгт хараагүй, хэлгүй, сонсголгүй, цаазаар авах ял шийтгэгдсэн этгээд, иргэний маргаанд Засгийн газрын нөхөн олговор, нийгмийн хамгааллын болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр болон тэтгэмж, хүүхдийн тэтгэмжийн асуудал зэргийг хамруулдаг байна. Украин Улс нь бага орлоготой иргэд, өнчин хүүхэд эсвэл гэр бүл нь салсан ахмад дайчин, иргэний чадвар, чадамж тодорхойлох, эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч, цагдан хоригдож буй этгээд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу өмгөөлөгч томилуулах шаардлагатай тохиолдолд, нийгмийн зорилтот бусад хүмүүст үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг. Австрали Улс нь эрүүгийн гэмт хэрэгт холбогдогчид, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн этгээд, нийгмийн болон хүний эрхийн зарим маргаан (нийгмийн даатгал, зээл, сэтгэцийн эрүүл мэнд, гэмтэл, цагаачлал, дүрвэгч асран хамгаалалт болон ялгаварлан гадуурхалтын эсрэг асуудал), замын хөдөлгөөний зөрчил болон их хэмжээний торгууль ногдуулсантай холбоотой асуудлаар үйлчилгээ үзүүлдэг. Америкийн Нэгдсэн Улсын Хууль зүйн үйлчилгээний корпораци нь зөвхөн иргэний хэрэгт эмэгтэйчүүд, хүүхдүүд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүст үйлчилгээ үзүүлдэг. Канад Улсын Хууль зүйн туслалцааны төв нь эрүүгийн болон гэр бүлийн хэрэг, маргаанд хууль зүйн зөвлөгөө болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг байна. Мөн уугуул болон цагаач иргэд, сэтгэцийн эмгэгтэй этгээдэд хууль зүйн туслалцаа үзүүлдэг. Бусад орны зохицуулалтаас харахад бие даасан Хууль зүйн туслалцааны тухай хуультай байх бөгөөд эрүүгийн хэргээс гадна зарим төрлийн хэрэг маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр хуульчилсан байна. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй иргэн, гэр бүлийн маргаан (гэр бүлийн хүчирхийлэл, тэтгэмж гаргуулах) зэрэг болно.

III. ДҮГНЭЛТ

Юуны өмнө хууль зүйн туслалцаа гэх ойлголтыг зөвхөн эрүүгийн хэрэгт холбогдсон этгээдэд өмгөөлөл үзүүлэх хэлбэрээр хязгаарлах нь учир дутагдалтай юм. Үүнд хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх гэсэн өргөн хүрээний ойлголтууд хамаарна. Манай Улсын хувьд хууль зүйн туслалцааг хэрхэн үзүүлэх талаар эрх зүйн орчин бүрдсэн. Гэвч хууль тогтоомжийн уялдааг хангах шаардлага зайлшгүй тулгарч байна. Тухайлбал Төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг Өмгөөллийн тухай хуультай нийцүүлэх шаардлага үүсч байна. Мөн хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа нь зөвхөн эрүүгийн хэрэгт холбогдсон иргэнд хамаарахаар байгаа нь учир дутагдалтай байна.

Зөрчлийн тухай хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэн, гэрлэлт цуцлалт, хүүхдийн тэтгэмжтэй холбоотой иргэний маргаан зэрэгт зорилтот бүлэгт хамаарах иргэн үнэ төлбөргүй туслалцаа авах боломжтой эсэх нь тодорхойгүй байна. Үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авсан иргэд 2020 оны байдлаар 46 хувь нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон байна. Энэ улсын өмгөөлөгчид хандаж байгаа иргэд нэг талаас амьжиргааны түвшин доогуур, эрхэлсэн тодорхой ажилгүй, тогтмол орлогогүй, зав чөлөө ихтэй, нөгөө талаас боловсролын түвшин доогуур, хуулийн мэдлэг багатайгаас өөрийн үйлдлийн учир холбогдол, хариуцлагыг ухамсарлах чадвар сул байгаатай шууд хамааралтай байна.

Гэхдээ тус төвд зөвхөн эрүүгийн хэрэгт холбогдсон иргэд бус Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр зорчих гэж буй иргэдэд 27 удаагийн сургалт явуулж, 880 иргэнд хууль эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан байна. Тиймээс хууль зүйн туслалцаа үзүүлэх бие даасан хуультай болох, эсхүл Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгайлан зохицуулалт оруулах шаардлага байгааг илэрхийлнэ.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

IV. НОМ ЗҮЙ:

1. Монгол эх сурвалж:

1. Улсын Их Хурлын Тамгын газар, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, УБ, 2017 он.
2. Хууль зүйн туслалцааны төв, “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмж” судалгаа, УБ, 2016 он.

2. Гадаад эх сурвалж:

1. Мика Изка, “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа”, Өмгөөлөгч судлал, УБ, 2011 он.

3. Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Ахмад настны тухай хууль, (2017).
3. Өмгөөллийн тухай хууль, (2019).
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, (2016).
5. Хүүхэд хамгааллын тухай хууль, (2016).
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (2015).

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Б.МӨНХ-ЭРДЭНЭ

Шихихутуг их сургуулийн Нийтийн эрх зүйн
тэнхимийн багш, Хууль зүйн магистр

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА ХҮНИЙ ЭРХ (ЯПОН УЛСЫН ЖИШЭЭН ДЭЭР)

DISCRIMINATION AND HUMAN RIGHTS (ON THE EXAMPLE OF JAPAN)

“Хүний эрхийг үгүйсгэдэг хүн өөрийн
хүн чанарыг үгүйсгэж байгаа хэрэг”
Нельсон Мандела.

Хураангуй: Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, бэлгийн чиг хандлага, хүйс, гэрлэлтийн байдал, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглодог. Мөн ажлын байрны ялгаварлан гадуурхалтын асуудал өнөөгийн цаг үед тулгамдаж буй томоохон хүний эрхийн зөрчил юм. Энэхүү нийтлэлээр ялгаварлан гадуурхах асуудлыг тэр дундаа ялгаварлан гадуурхах гэж үзэх зүйл нь юу гэдгийг санал болгохын зэрэгцээ хүний эрхийг хамгаалах болон хэрхэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар тусгалаа.

Түлхүүр үг: Ялгаварлан гадуурхалт ба хүний эрх.

Abstract: *The law prohibits discrimination on the basis of ethnicity, language, race, age, sexual orientation, gender identity, marital status, social origin, wealth, religion, opinion, education, or health. Discrimination in the workplace is also a major human rights violation today. This article suggests what discrimination is, in particular, what constitutes discrimination, and how to take precautionary measures to protect human rights.*

Keywords: *discrimination and human rights.*

I. ОРШИЛ

Хүний эрх нь хүн төрөлхтөн дунд хүний биеийг олж төрсөн хэн бүхэнд байгалиас хүлээн зөвшөөрөгдөх ёстой үндсэн эрх юм. Гэсэн хэдий ч хүн төрөлхтний түүхэнд байгалийн эрх болох хүний эрхийг бүрэн хамгаалж байсан цаг үе хэзээ ч байгаагүй гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл эрт дээр үеэс боолчлолын асуудал байнга яригдаж ирсэн бөгөөд өнөө үед дэлхийн өнцөг булан бүрт гэмт хэрэгтнүүд, хүний эрхийн мэдрэмжгүй хүмүүс бусдын эрхэнд ноцтой халдсан хэвээр байна.

Энэхүү нийтлэлээр ялгаварлан гадуурхах асуудлыг тэр дундаа “ялгаварлан гадуурхах” гэж үзэх зүйл нь юу гэдгийг санал болгохыг хүсч байна. Ялгаварлан гадуурхах асуудлыг шууд үгийнх нь утгаар ойлгосон явдал нь “ялгаварлан гадуурхах онол” өнөөг хүртэл төдийлөн сайн боловсруулагдаагүйтэй холбоотой. Дээрх асуудалтай холбогдуулан ялгаварлан гадуурхагч гэж хэнийг хэлэх, түүнтэй хэрхэн харьцах нь сайн судлагдаагүй гэж хэлэхэд болно.

Ялгаварлан гадуурхах асуудлын тухайд талбар бүрт эмпирик судалгаа хуримтлагдсан боловч ялгаварлан гадуурхах асуудалд нийтлэг байдаг онолын асуудлын талаарх хэлэлцүүлэг туйлын хангалтгүй байгаа нь практикт маш их төөрөгдөл үүсгэдэг. Бид ялгаварлан гадуурхагчийн үүднээс л зөвхөн асуудлыг тайлбарладаг учраас хүмүүс бусдыг ялгаварлан гадуурхах асуудалтай хэрхэн холбогддог гэдгийг нарийн гаргаж өгөх нь хүний эрхийн зөрчлийг бууруулахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

УИАН
СУДАЛГААНЫ САН

II. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Өнөө үед ялгаварлан гадуурхах явдал дэлхий дахинаа гарсаар байна. Нас, хүйсээс үл хамааран ялгаварлан гадуурхах үндэс суурь нь гүн гүнзгий бөгөөд өөрөөс нь ялгаатай гэсэн шалтгаанаар ялгаварлан гадуурхах үзлийг хөхиүлэн дэмжих нь нийтлэг юм. Өөрөөсөө өөр хүнийг хүлээн зөвшөөрөх чадваргүй байдлаас болж тэгш бус байдал улс орон, хүмүүсийн дунд таран түгдэг. Ялгаварлан гадуурхалтын түүх нь эзэн хааны колоничлолын дэглэм дэлгэрэхээс өмнө байсан гэж үздэг. Бусдыг өөрөөсөө дорд үзэж, ялгаварлан гадуурхах нь мөргөлдөөн үүсгэдэг. Энэ байдал нь өнөөдөр зөвхөн Африк, Ази төдийгүй Америк, Европ зэрэг тивийн өндөр хөгжилтэй улс орнуудад түгээмэл байгаа¹ нь асуудал дагуулж байгаа юм.

Дэлхий дээр гарч буй арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахыг мэдэхийн тулд бид 19 дүгээр зууны сүүлийн хагаст эргэж очих хэрэгтэй. Энэ үед Европт империализм хүчтэй дэлгэрч, хар арьстнуудыг ялгаварлан гадуурхах үзэл хүчээ авсан юм. Учир нь их гүрнүүд гэж нэрлэгддэг Европын улс орнууд Африкийн улс орнуудыг колони болгож байсан түүхтэй холбоотой байна.

Ялгаварлан гадуурхахтай холбоотой хамгийн тод илэрч гардаг үзэгдлийг энгийнээр тайлбарлахад спортын салбараас жишээ авахад болно. Тухайлбал хөл бөмбөгийн спортод өндөр түвшний алдартай тоглогчид нь янз бүрийн угсаа гаралтай хүмүүс байх нь нийтлэг бөгөөд тэд мэргэжлийн лигт дэлхийн өнцөг булан бүрээс өрсөлдөж байна. Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг хөл бөмбөгийн спорт олон жил нууж, аль болох дарж байсан юм. 1995 оны Босманы тогтоол нь Европын лигүүд болон клубуудын багуудын далд байсан ялгаварлан гадуурхалтыг ил гаргасан билээ. Шийдвэрийн агуулга нь Европын холбоо дахь мэргэжлийн тоглогчид өөрсдийн багтай байгуулсан гэрээний хугацаа дуусахтай зэрэгцэн чөлөөтэй шилжих боломжтой болсон бөгөөд энэ нь хожим хөл бөмбөгт арьс өнгөөр ялгаварлан гадуурхалт хүчтэй тархах хүчин зүйл болж хувирчээ.

Хамгийн нийтлэг ялгаварлан гадуурхалтын хэлбэр нь тамирчдыг арьс өнгөөр ялгаварлан гадуурхдаг хөгжөөн дэмжигчид тоглолтын үеэр болон өдөр тутмын амьдралд нь тамирчдад дарамт учруулах зорилгоор доромжилсон олон зурвас, илгээмж явуулдаг асуудал юм. Түүнчлэн бие биетэйгээ хамтран ажиллаж, ур чадвараа дээшлүүлэхийн тулд хоорондоо шударга өрсөлдөх ёстой тоглогчдын дунд хүртэл тэмцээний үеэр нэгнээ доромжилсон үг хэллэг, дохио зангаа гаргах үйлдлүүд ихсэх болжээ². Цагаан арьстнууд давамгайлдаг Европт өнгөт арьстнууд, ялангуяа хар арьстнуудыг ялгаварлан гадуурхах явдал маш их ажиглагдаж байгаа бөгөөд еврей, ази тамирчдыг ч мөн ялгаварлан гадуурхдаг болжээ.

1 内藤準. 会現象の規範的概念化に関する一つの考察. 33 頁.

2 Amnesty International. *What drives discrimination and how do we stop it?*. 2020.

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг үйлдлийг арилгахын тулд 1998 онд зохион байгуулагдсан Дэлхийн аварга шалгаруулах хөл бөмбөгийн тэмцээнд олон улсын уралдаанд оролцох эрхгүй байсан Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсыг оролцуулах боломжтой болгосон билээ. Энэ түүхэн үйл явдал нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бодлогын золиос болсон улс орон, үндэстнүүдийн төлөө хийсэн дэвшилтэд алхам бөгөөд олон улсын хүний эрхийн байгууллагуудын олон жилийн хичээл зүтгэл байсан юм. Гэсэн хэдий ч дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үеэр Франц Улсын шигшээ багийн тоглогч нэгэн арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл гаргасанд дургүйцсэн Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын тоглогч тоглолтын үеэр хариу цохилт хийж асуудал дагуулсан билээ.

Дээрх цочирдом үйл явдлын хариуд 2006 оны дэлхийн аварга шалгаруулах хөл бөмбөгийн тэмцээнийг “Арьс өнгөөр ялгаварлах үзэлд үгүй гэж хэлье”³ гэсэн уриатай зохион байгуулсан. Европт хөл бөмбөгийн тоглогч болоод хөгжөөн дэмжигчийн аюулгүй байдал нь нийгмийн гажуудал, тогтворгүй байдалтай шууд холбоотой бөгөөд хөл бөмбөгийн холбоо, лиг, клубуудын дунд арьс өнгөөр ялгаварлан гадуурхахтай тэмцэх ажил одоо ч гэсэн үргэлжилж байна.

Дээр дурдсанчлантай адил ялгаварлан гадуурхалт Монгол Улсад бас бий. Тухайлбал жендэрийн асуудал, эмэгтэйчүүд, хүүхдийн болон ахмад настнуудын, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, ажлын байрны ялгаварлан гадуурхалт, ХДХВ/ДОХ болон хамгийн сүүлд цар тахал буюу коронавируст халдвараар өвчилсөн хүмүүсийн эсрэг хийсэн ялгаварлан гадуурхалтын асуудал орно. Монгол Улсын хувьд дээрх хүний эрхийг зөрчсөн гадуурхалтуудыг зөв мэдлэг, боловсрол олгох байдлаар арилгах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад олон улс орны иргэд ажиллаж, суралцахаар түүнчлэн аялахаар ирэх нь нэмэгдсэн. Энэ бол даяаршсан ертөнцөд энгийн үзэгдэл боловч харийн хүн гэдэг байдлаар ялгаварлан үзэх дарамтлах тохиолдол гарч байна. Монголчууд бид нийтээрээ гадны улсыг ялгаварлан гадуурхах үзэлгүй боловч тодорхой яс үндэс, угсаа гарал, үндэс угсаагаар ялгах асуудал бас бий. Энэ байдал даамжирч болохгүй бөгөөд ялгаварлан гадуурхахыг уриалсан орчин бүрдэх эрсдэлийг үүсгэх аюултай.

Ялгаварлан гадуурхах шалтгаан нь санаатай гэх боловч нөгөө талдаа ухамсаргүйгээр хийгддэг гэж хэлж болно. Орчин үед ялгаварлан гадуурхах үзэл нь ямар ч байдлаар гарч болохоор байгаа нь хүн төрөлхтний нийтлэг сул тал, гажуудалтай холбоотой гэж үзэж байна. Ялгаварлан гадуурхах байдлыг хувь хүн биш харин тодорхой бүлэглэл зонхилон хийдэг бөгөөд

3 Say no to racism.

нөгөө талд нь тодорхой хүмүүсийн болоод бүлэглэлийн эрх зөрчигдөж, хохирдог. Хувь хүнийг тойрсон нийтлэг бүлэг, нийгмийн бүтэц нь ялгаварлан гадуурхахад нөлөөлдөг гол хүчин зүйл болдог.

Ялгаварлан гадуурхалтын шалтгаан нь ихэвчлэн хувь хүний төдийгүй адил бүлгүүдийн хооронд өрсөлдөөний харилцаа үүсэхээс эхлэлтэй бөгөөд зорилгодоо хүрэхэд бусад хүн, хүмүүс болон бүлгүүд саад болж, ашиг сонирхолд нь заналхийлж байна хэмээн ялгаварлан гадуурхалтын хандлага илэрхийлдэг. Эдгээр ойлголт нь хууль ёсны өрсөлдөөнөөс үүдээгүй бол өрөөсгөл, ялгаварлан гадуурхалт мөн бөгөөд бусдын эрхэнд халдсан ноцтой асуудал болно.

III. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ХЭЛБЭРҮҮД

Ялгаварлан гадуурхах нь олон хэлбэртэй бөгөөд тухайн илэрч гарч буй хэлбэр болгон нь хүний эрхийн зөрчил болж байдаг. Гэхдээ ялгаварлан гадуурхах хэлбэр нь цаг хугацаа, газар нутгаас хамааран утга агуулгын хувьд өөр өөр байдаг хэдий ч дараах хэлбэрүүд нь өдгөө хүлээн зөвшөөрөгдөж нийтлэг байдлаар хүний эрхийг хамгаалахын тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авагдаж байгаа болно.

Статусын ялгаварлан гадуурхалт: Хуулийн нэрт эрдэмтэн Хенри Сумнер Мейн “статусаас гэрээ хүртэл” гэсэн хэллэгийг анх ашигласан юм. Тэрээр статус гэдэг нь өргөн утгаараа тодорхой нийгэм, бүлэгт байгаа байр суурийг ойлгоно гэжээ. Статусын ялгаварлан гадуурхалт гэдэг нь хувь хүний авъяас чадвар, хүчин чармайлтаас үл хамааран нийгмийн байр сууринаас хамаарч тодорхойлогддог харилцааг хэлнэ⁴. Тодруулбал нас, хүйс, ураг төрлийн холбоотойгоор нь гадуурхдаг хэлбэр болно.

Анги давхарга, мэргэжлээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалт: Анги давхаргын ялгаварлан гадуурхалт нь ажил мэргэжил, боловсрол эзэмшсэн байдал, өмч хөрөнгө гэх зэргээр дээд анги, ажилчин анги гэх байдлаар илэрдэг бол мэргэжлээс үүдэлтэй ялгаварлал нь ажлын байран дээрх албан тушаалаас хамааралтай байх нь нийтлэг байна. Тухайлбал цагдаа, цэргийн анги, байгууллагад цол зэрэг, тэмдэг зэргээс шалтгаалан нэгнээ ялгаварлан гадуурхах байдал бий болдог.

Арьс өнгө, угсаа гарал, шашин шүтлэг, соёлын ялгаварлан гадуурхалт: Арьс өнгөөр болон үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах үзэл эрт дээр үеэс оршин тогтнож ирсэн. Эртний Грекээс үүдэлтэй “угсаатны үзэл” нь хожим ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр болсон гэж үзэж болно. 19 дүгээр зууны барууны улс орнуудад арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг колоничлолын худалдааг зөвтгөхийн тулд

4 社会科学大事典18. 鹿島研究所出版会. 332頁.

шинжлэх ухаантай холбож сүүлдээ хуурамч шинжлэх ухаанд суурилсан идеализм болгосон. Арьс өнгө, гарал угсаагаар ялгаварлан гадуурхах нь колонишлол дээр үндэслэгдэж, уугуул иргэдийн хэлмэгдүүлэлт, хар арьст африкчуудын боолын худалдаа, боолчлолыг хэрэгжүүлсэн хөрс суурь болсон билээ. Орчин үед үндсэрхэг үзлийн хүчирхийлэл гарах нь ихэссэн бөгөөд тусгаар тогтнолын хөдөлгөөнийг дарангуйллын аргаар янз бүрийн хавчлага, ялгаварлан гадуурхалтаар зогсоох байдал газар авч байна⁵. 1930-аад онд Герман Улсад нэвтэрсэн еврей, цыган гэх мэт үндэстнүүдийг ялгаварлан гадуурхах, хавчин шахах явдлыг зөвтгөсөн туйлширсан арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бодлогыг хэрэгжүүлсэн нь хүн төрөлхтний түүхэнд томоохон хар мөр үлдээсэн билээ. Дэлхийн 2 дугаар дайны дараа ялгаварлан гадуурхалт багассан ч сүүлийн жилүүдэд угсаатны мөргөлдөөн, терроризм, дүрвэгсэд, цагаачдын тоо нэмэгдэж байгааг нь тодорхой угсаатны бүлэг болон шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхах, хавчих хандлага байгаагийн нэг тод илрэл юм.

Хэл яриа, бүс нутгийн ялгаварлан гадуурхалт: Хэлний ялгаварлан гадуурхалт нь юуны түрүүнд нийгмийн үзэгдэл болдог. Зарим салбарт хэлний ялгаварлан гадуурхалтыг тодорхой хэлний бүлэгт зориулсан бодлого боловсруулах хэлбэр гэж үздэг. Гэхдээ арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл нь нийгмийн шинжтэй бол хэл, бүс нутгаар ялгаварлан гадуурхах нь улс төрийн шинжтэй байдаг. Хэл гэх ойлголтын хүрээнд авч үзэж болох гол хэсгүүд нь авиа зүйн өргөлт, үгсийн сангийн цар хүрээ юм. Энэ нь тухайн хүний нэг хэлнээс өөр хэл ашиглах чадварыг зайлшгүй чухалчлахтай холбогдож байдаг. Жишээлбэл Франц Улсад байдаг монгол хүн тухайн улсынх нь хэлээр ярьж чадахгүй бол түүнд франц хэлтэй хүнээс өөрөөр хандах нь тодорхой. Хэл яриагаар ялгаварлан гадуурхах хэлбэр нь бусад ялгаварлан гадуурхах хэлбэрүүдээс илүү ухамсартай байдаг. Учир нь хүний соёлын талаар хэсэгчлэн хэл шинжлэлийн чадвар дээр үндэслэсэн дүгнэлт гаргах байдлаар энэ гадуурхалт хийгддэг. Хэл шинжлэлийн эрдэмтдийн анхааруулж байгаагаар хүмүүсийг логик болоод ёс суртахууны хувьд үндэслэлгүйгээр хэл яриагаар ялгаварлан гадуурхах хандлага гаргах аюул нэмэгдэж байна гэжээ.

Хүйсийн ялгаварлан гадуурхах байдал: Олон салбарт эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарлаж олон нийтийн өмнө үг хэлэх боломж олгодоггүй байсан цаг үе саяхан. Өнөөгийн цаг үед ихэнх улс оронд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд нь сонгуулийн эрхийг зөвшөөрдөг бөгөөд эмэгтэйчүүдийн нийгмийн дэвшлийг нааштай хүлээн авч үздэг болсон. Тухайлбал хууль эрх зүйн тогтолцооны хувьд хүн бүр тэгш эрхтэй гэдгийг тунхаглаж байна. Финланд Улс 1906 онд Европын түүхэн дэх эмэгтэйчүүдэд анхны сонгуулийн эрхийг олгосон улс орон болсон нь хүний эрхийн томоохон дэвшил байсан. Гэсэн хэдий ч өнөөгийн цагт Ойрхи

5 性差別と暴力—統一性の法律学. 角田由紀子 有斐閣選書.

Дорнодын зарим улс оронд эмэгтэйчүүдийн сонгох эрхийг зөвшөөрдөггүй, зөвшөөрсөн ч хязгаарладаг байдал хэвээр үлджээ.

Эртний Грекийн дэлхийн анхны ардчилал болох Афин хотод өрхийн тэргүүн эрэгтэй хүн цэргийн алба хааж, хот суурин газарт амьдрах, сонгуулийн эрхээ эдлэх эрхтэй байсан. Францын хувьсгал нь орчин үеийн ардчиллыг бүрдүүлж, цэргийн албыг зөвхөн эрчүүдэд оногдуулсан юм. Энэ нь Конгресст өгсөн сонгуулийн эрхтэй салшгүй холбоотой байв. Өнөөдөр олон улс оронд зөвхөн эрчүүдийг цэрэгт татдаг. Одоогийн байдлаар эрэгтэй, эмэгтэй аль аль нь цэрэг татлагад хамрагдаж байгаа улс оронд Израиль, Малайз, Норвеги, Хойд Солонгос, Швед зэрэг улс орон ордог.

Европын холбоо 2006 оны 1 дүгээр сард ижил хүйстнүүдийн талаар хамтарсан тогтоол гарган ижил хүйстнүүдийг ялгаварлан гадуурхах үзлийг арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахтай адилтгаж үзсэн юм. 2000 онд баталсан Европын холбооны Үндсэн эрхийн дүрмийн 21 дүгээр зүйлд бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахыг хориглохыг мөн заажээ.

Бие махбодын болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхах: Хүний үндсэн эрх болоод амьдрах таатай орчинг бүрдүүлэхтэй холбоотой асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хүсэл зоригоос үл хамааран албадах хандлагатай байдаг. Тодруулбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, гүтгэлэг, амьдрах, зорчин явахтай нь холбоотой эрхийг нь зөрчсөн бүх л үйлдэл, үйл ажиллагаанууд нь хөгжлийн бэрхшээлийн улмаас нийгмийн оролцоог хязгаарласан ялгаварлан гадуурхалт юм⁶. Урт хугацааны асаргаа шаардагдаж буй хүмүүсийн хувьд ялгаварлан гадуурхах хандлага төрөл садан, ойр дотныхн нь түлхүү гардаг байна.

Өвчнөөр нь ялгаварлан гадуурхах байдал: Өвчний талаар төдийлөн сайн ойлголтгүй хүмүүс бусдын өвчнөөс үүссэн гадаад төрхийн өөрчлөлтийг хараад эсвэл өвчтэй гэдгийг нь мэдсэн үедээ ялгаварлан гадуурхах хандлага гаргадаг. Анагаах ухаан төдийлөн сайн хөгжөөгүй эрин үед өвчтөнүүдийг гаднах төрх байдал болоод халдвар авахаас эмээн хэт их ялгаварлан гадуурхах асуудал байсан гэдэг. Гэхдээ өнөөдөр ч гэсэн өвчин туссан гэдэг шалтгаанаар ялгаварлан харьцах байдал хуучин цаг үетэй адил байгааг саяхны цар тахал буюу коронавируст халдвартай хүмүүсийг ялгаварлан харьцаж байсан⁷ үйлдлээс харж болохоор байгаа юм.

Бусад ялгаварлан гадуурхалт: Бусдыг үзэл бодол, гадаад төрх, авъяас чадвараар, мөн тодорхой байгалийн гамшиг, бөмбөгдөлтөд амьд үлдсэнийг нь ялгаварлан гадуурхах нь бусад ялгаварлан гадуурхалт гэдэгт багтдаг.

6 土居健郎、「甘え」の構造、1971年（昭和46年）、弘文堂、39頁。

7 田南さん。日本財団ジャーナル編集部。恐れるべきはウイルスで人ではない。社会をむしろ「コロナ差別」をなくすためには。2020。

IV. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХТАЙ ХОЛБООТОЙ ОНОЛЫН АСУУДАЛ

Ялгаварлан гадуурхахыг тодорхойлох гэсэн олон удаагийн оролдлого бий боловч харамсалтай нь ихэнх нь ялгаварлан гадуурхалтыг оновчтой тодорхойлж чадаагүй байна. Ялгаварлан гадуурхах нь биднийг “шударга нийгэм” гэсэн асуулт руу ороход хүргэдэг тул тодорхойлоход хэцүү байдаг. Өөрөөр хэлбэл ялгаварлан гадуурхалтыг тэгш, шударга бус байдал гэх мэт үгсийг ашиглахгүйгээр тодорхойлсон бол бүх ялгааг ялгаварлан гадуурхалт гэсэн ойлголтод хамруулах эрсдэлтэй бөгөөд эсрэгээр нь “тэгш” ба “шударга бус байдал” гэх зэрэг үгсийг ашиглах нь ялгаварлан гадуурхах шалгуурыг “тэгш байдал” ба “шударга бус байдал” гэсэн шалгуураар орлуулдаг нэр томъёо⁸ болгох аюултай юм.

Саяхан ялгаварлан гадуурхалт гэдгийг субъектив тодорхойлолт болгон бэрхшээлийг даван туулах арга зам мэт гаргаж ирсэн тохиолдол ч байдаг. Тиймээс “ялгаварлан гадуурхалт гэж юу вэ?” гэсэн асуулт нь өөрөө маргаантай байгаагаараа бодит байдлыг олж харах оролдлогуудыг хийлгэж байна. Япон Улсын эрдэмтэн Казүэ Сакамото ялгаварлан гадуурхалтыг “Хэм хэмжээнээс гажсан асуудал” гэж үзээд дараах байдлаар тодорхойлжээ. Тэрээр “ялгаварлан гадуурхах нь хүмүүсийн ангиллын хоорондох хүний эрхтэй холбоотой хууль ёсны шалгуураар буруутгагдсан үйл явдал юм” гэсэн байна.

Харин өөр нэгэн хүний эрхийн төлөөх зүтгэлтэн Ёшикацү Мизүцү нь Сакамотогийн тодорхойлолтыг дэмжих байдалтайгаар гадуурхалтыг дахин тодорхойлсон юм. Тэрээр “ялгаварлан гадуурхалт нь бодит нөхцөл байдлын хэм хэмжээ болон хийсвэр хэм хэмжээний хоорондох зөрүүтэй холбоотойгоор хүний эрхийн зөрчил болсон асуудлыг хэлнэ” гэжээ.

Онолын хувьд хүний эрхийн томоохон зөрчил болох ялгаварлан гадуурхах үйлдлийг хүчирхийлэл гэж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл ялгаварлан гадуурхах нь буруу үзэл суртал, итгэл үнэмшил эсвэл ялгаварлан гадуурхсан хүний санаатай үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой байдаг. Энгийнээр авч үзвэл ялгаварлан гадуурхах нь хүчирхийлэл үйлдэж буй хэлбэр гэж хэлж болно. Өрөөсгөл буруу ойлголттой хүн түрэмгий аашилдаг гэсэн ойлголтыг огт үндэслэлгүй гэж хэлэмгүй⁹. Гэхдээ ялгаварлан гадуурхалттай холбоотой бүх нөхцөл байдлыг ухамсраар тайлбарлахыг оролдох нь туйлын нэг талыг барьсан асуудал бөгөөд өргөжүүлэн тайлбарлах нь энэ төрлийн хүний эрхийн зөрчлийн хүрээ хязгаарыг зөв тогтооход чухал ач холбогдолтой. Тиймээс хүчирхийллийн нэг хэлбэр дотор ялгаварлан гадуурхалт зүй ёсоор багтдаг төдийгүй илрэн гарч буй хэлбэрүүд нь өөр өөр байдаг.

8 江原由美子. 女性解放という思想. 勁草書房. 1985年.

9 Baert, S., Norga, J., Thuy, Y., Van Hecke, M. (In press) Getting Grey Hairs in the Labour Market: An Alternative Experiment on Age Discrimination.

Онолын өөр нэгэн түвшинд “гэнэн” сэтгэлгээтэй ялгаварлан гадуурхалтыг холбож байгаа төдийгүй хүмүүс хоорондын харилцаанд онцгойлон авч үзэхээсээ илүү өнгөрсөнд нь орхих тухай яригддаг¹⁰. Энэ нь ялгаварлан гадуурхалтын талаарх ойлголт нэгдсэн байдлаар хүлээн зөвшөөрөгдөөгүй, өргөн тархаагүй учраас ялгаварлан гадуурхах асуудлыг бодит байдалд найдах замаар орхигдуулах асуудал бий болгодог.

Хэрэв хор хөнөөл нь ялгаварлан гадуурхах үйлдлийг тодорхойлж чадахгүй бол ялгаварлан гадуурхах үйлдлийг зөвхөн гадуурхсан үйлдэл, эс үйлдэхүйтэй холбон нотлох замаар тодорхойлж болно гэж үзэх талтай. Энэ тохиолдолд ялгаварлан гадуурхсан үйлдэл, эс үйлдэхүй нь шударга бус байсан гэдгээрээ ялгаварлан гадуурхалттай шууд болон шууд бусаар холбогдсон болох нь нотлогдох ёстой.

Гэсэн хэдий ч нотолгоо гаргах тийм ч амар биш байдаг. Шууд бус нөлөөллийг тайлбарлахын тулд бид хийсвэр ойлголттой нүүр тулахаас гадна зарим тохиолдолд ялгаварлан гадуурхах ухамсарыг тодорхойлохоос өөр аргагүй болно. Ялгаварлан гадуурхах онол¹¹ нь ялгаварлан гадуурхах бодит байдалд тулгуурладаг тул дээрх шууд болон шууд бусаар ялгаварлаж байгаа асуудлыг хариуцлагад татах үндэслэл үгүйсгэгдэх талтай байдаг.

Тэгэхээр ялгаварлан гадуурхалтад өртсөн гэх нотолгоог хэрхэн хийдэг вэ? Нотолгооны гол арга бол “доройтлын баталгаа” юм. Энэ нь ялгаварлан гадуурхагдсан хувь хүн, бүлэг хүмүүс нь хүнд байдалд байгаа, ирээдүй цаг дээр яригдах боломжтой байсан үр дүн болоод одоо байгаа нөхцөл хоёрын хооронд ялгаа гарсан цаашлаад ялгаварлан гадуурхалт үргэлжилсэн гэдгээр нотлогдон тогтоогддог. Дээрх аргыг хүний эрхийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхтэй холбоотой харилцааг зөв дүгнэн тайлбарлахад ашигладаг. Тиймээс хууль ёсны нотолгоо нь шударга бус нотолгоог үгүйсгэж тодорхой ойлголтыг нэг мөр болгоход дөхөм үзүүлдэг. Судлаач Сакамотогийн үзэж байгаагаар “шударга бус нотолгоо” нь хэм хэмжээ дэх зарим төрлийн буруу ойлголтыг илрүүлж нээх үүрэг хүлээдэг. Өөрөөр хэлбэл тэгш эрхийн хэм хэмжээ байдаг боловч тогтолцооны хэм хэмжээ байдаггүйтай холбоотойгоор хоосон зайг нөхөх үүргийг шударга бус нотолгоо хүлээдэг гэжээ.

10 江原由美子. 差別の論理. とその批判, 女性解放という思想. 61 .1985 頁.

11 差別論.

V. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай конвенцыг дэлхийн өнцөг булан бүрт ялгаварлан гадуурхахыг арилгах зорилгоор 1965 онд Нэгдсэн Үндэстэний Байгууллагын Ерөнхий ассемблейгаас баталсан. Албан ёсны нэр нь “Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц”¹² бөгөөд арьсны өнгөөр болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахыг арилгах олон талт гэрээ юм. Энэхүү гэрээ нь арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах байдал гэж юу болохыг дараах байдлаар тодорхойлсон болно. “Арьс үндсээр алагчилах гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёл болон нийгмийн амьдралын бусад салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг тэгш хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, үгүйсгэх зорилго бүхий арьс үндэс, арьсны өнгө, ураг төрөл, үндэсний буюу угсаатны гарал үүслийн үндсэн дээр ялгаварлах, онцлох, хязгаарлах буюу дээрд үзэхийг хэлнэ”¹³ гэжээ. Нөгөө талаасаа дээрх конвенц нь дэлхийн өнцөг булан бүрт ялгаварлан гадуурхах үзлийг арилгах, ялгаварлан гадуурхах байдлыг гаргуулахгүй байх тухай оролцогч улс орнуудын үүрэг, амлалтын эмхэтгэл гэж ойлгож болно.

Монгол Улсын хувьд дээрх конвенцод нэгдэн орсон бөгөөд нилээдгүй хууль тогтоомжийг нийцүүлэн гаргасан. Гэвч бодит хэрэгжилтийн асуудал дээрх анхаарах зүйлс цөөнгүй байна. Мөн ялгаварлан гадуурхалттай холбоотой олон конвенц, хууль тогтоомж өнөөдөр хэрэгжиж байгаа ч гэсэн эрх зүйн хүрээнд шинээр зохицуулах ёстой харилцаанууд үүсжээ. Сүүлийн жилүүдэд гадаадын иргэдийг илт ялгаварлан гадуурхах байдал нэмэгдэж байгаа нь хүний эрхийн ноцтой зөрчил болж байгаагаас гадна Монгол Улсын нэр хүндийг олон улсын хэмжээнд унагаах шалтгаан болж байгаа юм.

Япон Улсын хувьд дээрх асуудлыг шийдэхийн тулд Япон Улсад ирсэн гадаадын иргэдийн эсрэг шударга бусаар ялгаварлан гадуурхсан үг, зан үйлийг арилгах, түүнийг сурталчлах тухай хууль¹⁴ батлан гаргасан. Энэ хууль нь Япон Улсад сүүлийн жилүүдэд хууль ёсны дагуу оршин суугч хүмүүс эсвэл тэдний үр удмыг ялгаварлан гадуурхах, иргэний эрхийг нь хасах шударга бус ялгаварлан гадуурхалт газар авснаас үүдэн батлагджээ. Үг, үйлдлээр сэтгэл зүйн зовлон шаналал учруулж, түүнчлэн нийгэмд ноцтой хагарал гарах эрсдэл байгааг анхаарч дээрх хуулийг хэрэгжүүлэх болсон байна.

Шударга бус ялгаварлан гадуурхах үйлдлийг зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдэж байгаа Япон Улсын хүний эрхийн байгууллагуудын саналаар

12 Монгол Улс 1966.05.03-ны өдөр гарын үсэг зурж, 1969.03.31-ний өдөр соёрхон баталсан.

13 Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

14 本邦外出身者に対する不当な差別的言動の解消に向けた取組の推進に関する法律.

парламент нь Япон Улсад ирсэн гадаадын иргэдийн эсрэг шударга бусаар ялгаварлан гадуурхсан үг, зан үйлийг арилгах, түүнийг сурталчлах тухай хуулийг баталж, цаашдаа хүний эрхийн боловсрол, хүний эрхэнд хүндэтгэлтэй хандах байдлыг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх замаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгч, сургалт зохион байгуулан хүмүүс хоорондын ойлголцол, хамтын ажиллагааг идэвхжүүлэн асуудлыг шийдвэрлэхээр Япон Улсын хүний эрхийн байгууллагууд болоод холбогдох төрийн байгууллагууд анхааран ажиллаж байна.

Түүнчлэн Япон Улс хөгжлийн бэрхшээлтэй гэх үндэслэлээр ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай хууль¹⁵ баталсан нь тодорхой бүлгийн эрх зөрчигдөж байгаад анхаарч асуудалд хандсан чухал эрх зүйн баримт гэж үзэх үндэслэлтэй юм. Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль¹⁶ тогтоомж нь дээрх Япон Улсын хуулийн нэгэн адил агуулга зорилготой байдаг.

Гэхдээ Япон Улсын хөгжлийн бэрхшээлтэй гэх үндэслэлээр ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай хуульд манай улсын хууль тогтоомжийн агуулгад ороогүй зохицуулалт бий. Тодруулбал энэ хуульд “Хөгжлийн бэрхшээлтэй гэж ялгаварлан гадуурхах” нь 2 хэлбэртэй гэж үзжээ.

- a. Хөгжлийн бэрхшээлтэй гэх үндэслэлээр үйлчилгээ үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзах, хязгаарлах, болзол тогтоох үйлдэл.
- b. Хууль ёсны хувьд авах арга хэмжээнүүдийг авахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэн үзэхгүйгээр хүсэл зоригийнх нь болоод боломжит чадварт нь нийцүүлэхгүйгээр үйлчилгээг үзүүлсэн болоод үзүүлээгүй үйлдэл.

Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульдаа ялгаварлан гадуурхах үйлдлийг тодорхой байдлаар нарийвчлан зохицуулж, оруулах нь хууль зүйн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад аймаг, орон нутаг, хот суурин газрын иргэд гэсэн ялгаварлал бий болж хүмүүс нэгнээ ялгаварлан гадуурхах нь газар авч үл ойлголцол болоод хүмүүсийн хоорондын харилцаанд хүний эрхийг үл хүндэтгэх асуудлыг дэвэргэж байгаа нь тулгамдаж буй асуудлын нэг болоод байна. Япон Улсад манай улстай адил асуудал гарч эхэлсэн тул 2008 онд Бүс нутгийн ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай хууль¹⁷ баталсан байдаг. Уг хуульд Үндсэн хуулийн хүний эрхийн зохицуулалтыг баталгаажуулж, ялгаварлан гадуурхалтыг үл хүлээн зөвшөөрч, хүний эрхийг хамгаалах, хангах зорилготой баталсан байна. Энэ

15 障害を理由とする差別の解消の推進に関する法律.

16 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, (2016).

17 部落差別の解消の推進に関する法律.

хууль нь нэгдмэл засаг захиргааны бодлого, хүн амын дундах ялгаварлан гадуурхалтыг арилгах арга хэмжээг дэмжих байдлаар иргэдийнхээ үндсэн эрхээ эдлэх эрхийг нь баталгаажуулж өгч байгаа юм.

Бүс нутгийн ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай хуулийн улсын болон орон нутгийн засаг захиргааны үүрэг¹⁸ гэсэн 3 дугаар зүйлд “Бүс нутгийг болоод иргэдийг нь ялгаварлан гадуурхах явдлыг арилгах арга хэмжээ авах, орон нутгийн засаг захиргааны хэрэгжүүлж буй бүс нутгаар ялгаварлан гадуурхахыг арилгах арга хэмжээг сурталчлахад шаардлагатай мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх үүрэгтэй” гэж оруулж өгсөн нь чухал ач холбогдолтой заалт болжээ. Манай улсын хувьд уг хуультай нэгэн адил бүс нутгаар ялгаварлан гадуурхах байдлыг арилгах эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй хийх шаардлагатай гэж үзэж байна. Учир нь цөөн хүн амтай, өргөн газар нутагтай Монгол Улсын хувьд үндэсний эв нэгдэл нь хамгийн чухал тусгаар тогтнолын баталгаа юм.

Бүс нутгаар ялгаварлан гадуурхах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд анхаарч шийдвэрлэх арга замыг хайж байгааг илтгэх өөр нэг жишээ бол Бүс нутгийн ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай Японы Улсын Нара мужийн захирамж¹⁹ юм. Энэхүү захирамжаар бүс нутгийн ялгаварлан гадуурхалтыг арилгах арга хэмжээний талаар баримтлах үндсэн бодлогыг гаргах талаар тусгаж өгсөн бөгөөд ялгаварлан гадуурхалтыг арилгах талаар мужаас системтэйгээр авах арга хэмжээг чухалчилж тусгасан байна. Захирамжийн дагуу Засаг дарга бүс нутгаар ялгаварлан гадуурхахыг багасгах, халах тухай үндсэн төлөвлөгөөг батлуулах бөгөөд Нара мужийн хүний эрхийн зөвлөлтэй зөвшилцөн баримталж буй бодлогыг нь тусгах үүрэгтэй. Засаг дарга үндсэн төлөвлөгөө гаргасны дараа түүнийгээ олон нийтэд мэдээлж сурталчлах давхар үүрэг хүлээдэг.

Монгол Улсын хувьд аймаг, нийслэлд дээрхтэй адил захирамж гарган хэрэгжүүлэхдээ Хүний эрхийн Үндэсний Комиссоос өгсөн санал, зөвлөмж, бодлогыг тусгаж явах нь ялгаварлан гадуурхалтын эсрэг үр дүнтэй ажил болох боломжтой юм. Ингэснээр иргэдийн хүний эрхийн тухай ойлголтыг нэмэгдүүлээд зогсохгүй хүний эрхийн мэдрэмжтэй болоход чухал нөлөө үзүүлж чадна гэж үзэж байна.

18 部落差別の解消の推進に関する法律. 国及び地方公共団体の責務. 第三条.

19 奈良県部落差別の解消の推進に関する条例.

VI. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫГ БИЙ БОЛГОЖ БУЙ ГОЛЛОХ ШАЛТГААНУУД БОЛООД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА

Хүмүүсийн харилцаанд цахим интернэт дэх хүрээ өргөжиж, харилцаа илүү хялбар болохын зэрэгцээ бусдыг гүтгэх, хувь хүний нэр төр, хувийн нууцад халдах, ялгаварлан гадуурхах, ялгаварлан гадуурхах явдлыг сурталчлах мэдээлэл ихэсч байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд кибер дээрэм, өшөө авалтын тоо өсөж байгаа бөгөөд хүнийг ялгаварлан гадуурхсан мэдээлэл интернэтэд цацагдсаны дараа хурдан тархаж, бүрэн арилгахад амаргүй болдог тул олон хүний эрх зөрчигдөж нэр төр, алдар хүнд нь сэргээгдэхгүйгээр унах эрсдэл дагуулсаар байгаа нь энэ төрлийн ялгаварлан гадуурхалтын асуудлыг зохицуулах хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байгаа юм.

Хувь хүний нэр төр, хувийн нууцыг хүндэтгэхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, ёс суртахууны талаарх зөв ойлголтыг гүнзгийрүүлэх шаардлага, хэрэгцээ өнөө үед бий болжээ. Цахим орчинд хүмүүстэй харилцаанд орохдоо хүнтэй шууд харьцахтай адил дүрэм, ёс суртахууныг дагаж, нөгөө хүнийхээ эрх, эрх чөлөөг хүндэтгэх нь чухал юм. Хэдийгээр нэгнийхээ царайг харж чадахгүй хэдий ч гэсэн интернэтэд холбогдсон хүн бүр зүрх сэтгэлтэй амьд хүн гэдгийг санах хэрэгтэй.

Өнөөгийн цаг үед дараах асуудал ялгаварлан гадуурхах гол шалтгаан нөхцөл болж байна. Тиймээс эдгээр агуулга бүхий асуудлыг хэрхэн харилцаандаа анхаарч байхаас шалтгаалан ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ гэж ойлгох нь зүйтэй. Үүнд:

1. Хаана төрж өссөн байгаагаар нь ялгаварлан гадуурхах;
2. Амьдарч буй газар, орчин нөхцөлөөр нь ялгаварлан гадуурхах;
3. Гэр бүлийн байдал, гэр бүлийнхний олж авсан боловсролоор нь ялгаварлан гадуурхах;
4. Гэр бүлийн хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхах;
5. Үзэл бодол, итгэл үнэмшил, шашин шүтлэг, хүндэлдэг хүмүүсээр нь ялгаварлан гадуурхах;
6. Дэмжиж буй улс төрийн үзэл бодол, байр сууриар нь ялгаварлан гадуурхах;
7. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь ялгаварлан гадуурхах²⁰.

20 豊中市. 就職差別は重大な人権問題です.

1. Хаана төрж өссөн байгаагаар нь ялгаварлан гадуурхах байдлыг үүсгэх эрсдэл дагуулах асуулт нь:

- Та төрсөн цагаасаа хойш одоог хүртэл хаана амьдарч ирсэн бэ?
- Та энд ирэхээсээ өмнө хаана амьдарч байсан бэ?

2. Амьдарч буй газар, орчин нөхцөлөөр нь ялгаварлан гадуурхах шалтгааныг бий болгох эрсдэлтэй асуулт нь:

- Ямар орчинд та амьдарч байна вэ?
- Гэр тань төв замтай хэр ойр вэ?

3. Гэр бүлийн байдал, гэр бүлийн олж авсан боловсролоор нь ялгаварлан гадуурхах шалтгааныг бий болгох эрсдэлтэй асуулт нь:

- Таны аав, ээж ямар компанид ажилладаг вэ?
- Танайх гэр бүлийн ямар бизнес эрхэлдэг вэ?
- Таны гэр бүлийн орлого хэд вэ?
- Хэн таны сургалтын төлбөрийг төлдөг вэ?
- Таны эцэг, эх хоёулаа байдаг уу?
- Нас барсан үхлийн шалтгаан юу вэ?

4. Гэр бүлийн хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхах шалтгааныг бий болгох эрсдэлтэй асуулт нь:

- Танайх ямар байшинд амьдардаг вэ?
- Таны байшин эсвэл газар хувийн өмч үү, эсвэл түрээсэлсэн үү?
- Та хэчнээн үл хөдлөх хөрөнгөтэй вэ?

Яагаад эдгээр асуултыг тавих ёсгүй вэ? Хувь хүний ур чадварыг харгалзан үнэлэлт хийхийн оронд дээрх асуултаар дүгнэлт хийх байдал нийтлэг бий. Энэ нь орчин үеийн нийгмийг хуваагдмал байдалтайгаар хүний эрхийг зөрчсөн ялгаварлан гадуурхалт тархах хөрс суурь нь болж өгч байна.

Ялгаварлан гадууралт нь сурч боловсрох, хөдөлмөр эрхийг хязгаарлахаас гадна эрх тэгш боломжийг зөрчих аюул дагуулдаг. Орон сууцны орчин, амьдарч буй газрын нөхцөл байдлыг сонсох нь эргээд тухайн бүс нутгийн амьжиргааны түвшинг үнэлэх эхлэл болдог бөгөөд субъектив шүүлт урьдчилсан байдлаар бий болгодог сул талтай. Дээрх асуудал нь хувь хүний хүчин чармайлтаар шийдэгдэхгүй зөвхөн объектив байдлаар субъектив дүгнэлт хийх нөхцөл байдалд оруулж байгаа юм.

1. Үзэл бодол, итгэл үнэмшил, шашин шүтлэг, хүндэлдэг хүмүүс, улс төрийн үзэл бодол, байр сууриар нь ялгаварлан гадуурхах шалтгааныг бий болгох эрсдэлтэй асуулт нь:

- Та ямар итгэл үнэмшилтэй вэ?
- Таны гэр бүлийн шашин шүтлэг юу вэ?
- Та ямар улс төрч болоод улс төрийн намыг дэмждэг вэ?

Бодол, итгэл үнэмшил, шашин шүтлэг, тэднийг дэмждэг улс төрийн намууд, амьдралыг үзэх үзэл нь Үндсэн хуулиар баталгаажсан хувь хүний эрх, эрх чөлөөний асуудал юм. Мөн шашин шүтэх нь үзэл бодол, итгэл үнэмшилд хамаардаг²¹. Ажилд авах сонгон шалгаруулалтад ороход эдгээр асуултыг тавьсан тохиолдолд хүний үндсэн эрхийг зөрчиж байгаа тул эрс татгалзаж хариулахгүй байх эрхтэй.

2. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь ялгаварлан гадуурхах шалтгааныг бий болгох эрсдэлтэй асуулт нь:

- Гэрлэсний дараа эсвэл төрсний дараа үргэлжлүүлэн ажиллах бодолтой байна уу? (зөвхөн эмэгтэйчүүдийн хувьд)
- Манайд цөөн тооны эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд) байдаг бөгөөд энэ нь удаан хугацаанд үргэлжлүүлэн хийх боломжтой ажил биш боловч та компанид ажиллахыг хүсч байна уу?

Эмэгтэй, эрэгтэй гэсэн хүйс дээр үндэслэсэн асуулт нь Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль болоод бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг зөрчсөн хэрэг бөгөөд хүний эрхийг тэгш бусаар ялгаварлан гадуурхаж буй хэлбэр болно. Цаашлаад өөр бусад эрх, эрх чөлөөг зөрчих эхлэл дээрх асуултын агуулгад багтаж байгаа болно. Жендэрийн үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгааны эхлэл нь эдгээр асуулттай шууд холбоотой байдаг.

Хүний эрхийн асуудлыг анхаарч, үндсэн эрхийг чухалчлан ажиллаж чаддаг, хамтран асуудлыг шийдвэрлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг зохион байгуулдаг байгууллага хамт олны хүрээ хязгаарыг тэлэхэд дээрх хүний эрхийг зөрчих эрсдэл дагуулж буй асуулт нь чухал ач холбогдолтой, суурь ойлголтыг өгч чадах юм.

Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, ялгаварлан гадуурхахгүй байхтай холбоотой доорх 3 асуудлыг чухалчилж үзэх хэрэгтэй байна. Үүнд:

1. Хүнийг байгаагаар нь хүн гэж хүлээн зөвшөөрөх явдал билээ. Энэ цаашлаад хүмүүсийг хүндэтгэх, бусдын бодол санааг хүндэтгэх өөрөөр хэлбэл хүний үндсэн эрхийг хүндэтгэх явдал болно.
2. Хувь хүний ур чадварыг нь харгалзан үнэлж үздэг байх нь чухал юм.
3. Хүн бүрт адил тэгш боломжийг олгох явдал юм.

21 “光明養護学校の学童疎開”. 日本障害者リハビリテーション協会. 2017年8月20日閲覧.

VII. ДҮГНЭЛТ

Хүний эрх, эрх чөлөөг зөрчиж ялгаварлан гадуурхах, ялгаварлан гадуурхахад хүргэж байгаа асуудлыг зогсоохын тулд хүн бүр дор бүрнээ үг, үйлдлээ өөрөөсөө эхлэн хянаж байх нь чухал билээ. Ялгаварлан гадуурхсан шинжтэй үг, үйлдэл нь хүний эрхийн томоохон зөрчилд хүргэдэг.

Ялгаварлан гадуурхалт нь ямар хор хөнөөлтэй гэдгийг өнөөгийн Ковид-19 цар тахлын үед коронавируст халдвартай холбож тайлбарлах боломжтой. Коронавируст халдвартай хүмүүст ялгаварлан гадуурхалт мэдрэгдэж эхлэх үед хүмүүс нийтлэг байдлаар шинжилгээнд хамрагдахаас зайлсхийх эсвэл халдварт өртсөнөө нуухыг хичээдэг тул коронавируст халдварын тархалтыг хянахад бэрхшээлтэй болгож байна. Ямар ч хэлбэрийн ялгаварлан гадуурхалт нь хүний нийгмийн хэвийн хэмнэлийг алдагдуулаад зогсохгүй дорд үзэх явдал газар авч, улмаар улс төр, эдийн засаг, гэр бүл, нийгмийн хүрээнд гарах сөрөг нөлөөлөл даамжрах аюултай юм. Цөөн хүн амтай манай улсын хувьд эв нэгдэл алдагдаж, соёлоо хэвээр хадгалж үлдэх боломж хүртэл багасах эрсдэл ялгаварлан гадуурхалтаас үүдэн бий болдог.

Тиймээс ялгаварлан гадуурхалтыг үгүй хийхийн тулд эхний ээлжид бүх шатны боловсролын байгууллага болон мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулиудад хүний эрхийн талаар сайн хөтөлбөр боловсруулан сургалт оруулах хэрэгтэйгээс гадна ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах талаар сурталчилж таниулах шаардлагатай байна.

Нийгмээс ялгаварлан гадуурхалтыг арилгахын тулд тууштай хичээл зүтгэл, тодорхой арга хэмжээг дэс дараалалтай авах нь нэн чухлаар тавигдаж байна. Учир нь өнөөдөр ялгаварлан гадуурхалтад өртөж үндсэн эрх нь зөрчигдөн шаналж байгаа зорилтот бүлгийн иргэд, хүүхэд, эмэгтэйчүүд зэрэг олон бүлэг байна. Энэхүү илтгэлээрээ ялгаварлан гадуурхалтын эсрэг нийгмийн сэтгэл зүйн асуудлыг хөндсөн төдийгүй ялгаварлан гадуурхалт нь онолын хувьд ямар агуулга илэрхийлдэг болохыг тайлбарлахыг хичээж, хэрхэн урьдчилан сэргийлэх, түүнчлэн тодорхой харилцаанд гарч буй хүндрэлийг арилгахад эрх зүйн хүрээнд болоод хүмүүс хоорондын харилцаанд юуг хэрхэн анхаарах талаар тусгахыг энэ нийтлэлдээ зорилоо.

УИАН
СУДАЛГААНЫ САН

VIII. НОМ ЗҮЙ:

1. Гадаад эх сурвалж:

1. Amnesty International. What drives discrimination and how do we stop it?. 2020.
2. Baert, S., Norga, J., Thuy, Y., Van Hecke, M. (In press) Getting Grey Hairs in the Labour Market: An Alternative Experiment on Age Discrimination.
3. 部落差別の解消の推進に関する法律.
4. 部落差別の解消の推進に関する法律. 国及び地方公共団体の責務. 第三条.
5. 奈良県部落差別の解消の推進に関する条例.
6. 本邦外出身者に対する不当な差別的言動の解消に向けた取組の推進に関する法律.
7. 障害を理由とする差別の解消の推進に関する法律.
8. 内藤準. 会現象の規範的概念化に関する一つの考察. 33 頁.
9. 社会科学大事典18. 鹿島研究所出版会. 332頁.
10. 性差別と暴力—続・性の法律学. 角田由紀子 有斐閣選書.
11. 土居健郎、「甘え」の構造、1971年. 39頁.
12. 田南さん. 日本財団ジャーナル編集部. 恐れるべきはウイルスで人ではない。社会をむしばむ「コロナ差別」をなくすためには. 2020年.
13. 江原由美子. 女性解放という思想. 勁草書房. 1985年.
14. 江原由美子. 差別の論理. とその批判, 女性解放という思想. 1985年. 61 頁.
15. “光明養護学校の学童疎開”. 日本障害者リハビリテーション協会. 2017年8月20日閲覧.

2. Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль,(1992).
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль,(2011).
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, (2016).
4. Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, (1965).



Б.ПҮРЭВСҮРЭН

Глоб Интернэшнл төвийн хуульч,
Хууль зүйн магистр



М.ОЮУНХОРОЛ

Эрх зүйч

ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ БА ЦЕНЗУР

IMPLEMENTATION OF RIGHT TO FREEDOM OF PRESS AND CENSORSHIP

Хураангуй: Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр үндсэн эрх, эрх чөлөөний хязгаарлалт, хамгаалалтын хүрээг хэрхэн тогтоодог талаар тодорхойлсноор хэвлэн нийтлэх эрх чөлөөний онолын ойлголтыг тусад нь хөндөн авч үзлээ. Улмаар хэвлэл мэдээллийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийснээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд төрөөс тавьж буй цензур нь хамгийн том хязгаарлалт болж буйг тодорхойлов. Ингэснээр хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаатай эдлэхийн тулд хэвлэн нийтэлж буй агуулгад тавих цензурыг хориглох шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн. Түүнчлэн шүүхийн зарим шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар өнөөгийн хэрэгжилтийг үнэлэх оролдлого хийв.

Түлхүүр үг: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт, хэвлэн нийтлэх эрх чөлөөний баталгаа, хэвлэн нийтлэх эрх чөлөө ба цензур, үндсэн эрхийг хязгаарлахад тавигдах гол нөхцөл, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, хэвлэл мэдээллийн эрх зүй, мэдээллийн эрх чөлөө, цензурын төрөл, худал мэдээлэл тараах гэмт хэрэг.

Abstract: This research article discusses the concept of freedom of press separately, describing how fundamental rights, freedoms, and protections are defined. An analysis of the implementation of the law revealed that state censorship of the media was the “biggest” limitation. This led to the conclusion that censorship of published content should be prohibited in order to guarantee the right to freedom of press. Attempts were also made to assess the current implementation by analyzing court decisions.

Keywords: Freedom of expression, freedom of press, implementation of the right to freedom of press, freedom of the publish, freedom of the publish and censorship, the main conditions for restriction of fundamental rights, the law on freedom of media, media law, freedom of information, types of censorship, guarantees for free and independent media, and dissemination of false information.

I. УДИРТГАЛ

Хэвлэн нийтлэх эрх чөлөө нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд урган гардаг ойлголт бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд “...үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх ...эрх чөлөөтэй” байхаар баталгаажсан. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг 1998 онд баталснаар төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад цензур тогтоохгүй байхаар зохицуулсан¹. “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно” зэрэг 4 заалт бүхий хууль баталснаас хойшхи 23 жилийн хугацаа дахь хэрэгжилт, үүнээс цензурын асуудлыг эргэн харах шаардлага үүсэв.

Глоб Интернэшнл төвөөс 2018 онд хийсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдлын түвшин тогтоох” судалгаагаар 300 сэтгүүлч тутмын 52 хувьд редакцын зүгээс нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлтэй нь холбогдуулан цензур тогтоодог² гэж хариулсан байна. Тэгвэл цензурын хэд хэдэн төрөл байж болох бөгөөд энэхүү өгүүлэлдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлд төрөөс тавьж буй цензурыг онцлон хөндөнө. Хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаатай эдлэхийн тулд хэвлэн нийтэлж буй агуулгад тавих цензурыг хориглох зайлшгүй шаардлагатай. Цензур тогтоож буй өнөөгийн хууль тогтоомжийг судлан авч үзсэнээр хууль ёсны, зайлшгүй тохирсон, хэм хэмжээнд нийцсэн эсэхэд зохих үнэлэлт, дүгнэлт өгөв.

Энэхүү судалгаагаараа хэвлэн нийтлэх эрх чөлөөний хязгаарлалт, хамгаалалтын хүрээг хэрхэн тогтоодог талаар Үндсэн хуулийн онол,

1 <https://www.legalinfo.mn/law/details/546>

2 Глоб Интернэшнл төв, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан, УБ, 2018 он, 5 дахь тал. <https://www.gic.mn/post/r/646> [Сүүлд үзсэн огноо: 2021.03.17]

практикийн зарим асуудлыг харьцуулан судалж хэвлэн нийтлэх эрх чөлөөний Үндсэн хуулийн хамгаалалт, түүний үзэл баримтлалыг тодорхойлж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон бусад эрх, эрх чөлөөний зохистой хязгаарыг судлахыг эрмэлзэв. Ингэснээрээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө нь хоорондоо нягт холбоотой, нэгийг нь хязгаарлахад нөгөө нь хөндөгдөж байдаг учир ийнхүү нэг зүйлд багтаан Үндсэн хуулиар баталгаажуулсан гэсэн дүгнэлтэд хүрэв.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний ойлголт

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь байгалиас заяасан шинж чанараараа төрөлхийн хүний мөн чанар, оршин буйн утга учир болдог тул аль улсын иргэн, харьяат байхаас үл хамааран заавал эдлэх эрх юм. Хүний үндсэн эрхийн тухай хууль зүйн ухааны доктор, профессор Ц.Сарантуяа “Хүн төрөлхтний түүхэн сурвалжаас үүдэн дүгнэхэд иргэн хүний эрх чөлөөг дөвийлгөх төрийн эрх мэдлийг хязгаарлахад чиглэсэн тал нь нэлээд түлхүү анхаарах ёстой элемент байдаг гэдэг нь нотлогдож буй юм. Тухайлбал үзэл бодлоо өөрийн итгэл үнэмшлээр илэрхийлэх боломжийг үндсэн эрхээр баталгаажуулж байгаа бөгөөд тэр нь тухайн үед ноёрхож буй нийгмийн болон улс төрийн үзэл бодлоос ялгаатай байсан ч уг эрхийг эдлэх боломжоор хүн хангагдах ёстой юм. Үндсэн эрх нь хүнийг төрөөс хамгаалах шинжтэй эрхүүд болохын хувьд дарангуйллын төрд байх боломжгүй буюу тийм төрийн оршин тогтнох чадварыг бууруулдаг гэж үзжээ.

Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрхтэй. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй³. Үндсэн хуулийн энэхүү заалтыг өргөтгөн баталгаажуулсан 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг Монгол Улс 1974 онд соёрхон баталснаар үзэл бодолтой байх, үзэл бодлоо баримтлах, өөрчлөх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эсвэл илэрхийлэхгүй байх эрх чөлөөг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн билээ.

Үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө нь илэрхийллийн арга, хэлбэрээр дамжин илрэн гардаг. Тэгвэл илэрхийлэх гэдэг нь “юмыг илэрхий болгох, тоочих, тодорхойлох, учраа илэрхийлэх, санаагаа илэрхийлэх, нийтэд илэрхийлэх”⁴ гэсэн утгатай. Үзэл бодлоо олон арга, хэлбэрээр илэрхийлэх боломжтой юм. Яриа, бичиг, дохионы хэл, дүрс, урлагийн бүтээл гэх мэт аман бус хэлбэрүүд байдаг. Мөн ном, сонин, товхимол, зурагт хуудас, баннер, хувцас болон хуулийн дагуу гомдол

³ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалт. <https://www.legalinfo.mn/law/details/367>

⁴ Я.Цэвэл, Монгол хэлний тайлбар толь, УБ, 1966 он, 304 дэх тал.

гаргах нь илэрхийллийн арга хэрэгсэлд орно. Эдгээрт дуу, дүрс, электрон, интернэтэд суурилсан илэрхийлэл орно⁵.

Иргэд үзэл бодлоо янз бүрийн аргаар илэрхийлж ирсэн агаад илэрхийлэх арга хэлбэрт хэмжээ, хязгаар үгүй ч зөвхөн хуулийн хүрээнд уг эрх чөлөөг эдлэх ёстой. Хуулиар үндэсний аюулгүй байдал, олон нийтийн эрх ашиг, эрүүл мэнд, ёс суртахуун зэрэг бусад зайлшгүй шалтгаанаар уг эрхийг эдлэхэд тодорхой хязгаарлалт тогтоож болох боловч эл эрхийн мөн чанар, бүрэн цогц, нэгдмэл байдлыг хязгаарлан хөндөх ёсгүй гэсэн шалгуур байх учиртай.

Үг хэлэх, сонин, сэтгүүл гаргах, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх, цахим орчноор дамжуулан өөрийн байр суурийг илэрхийлэх, нийтийг хамарсан жагсаал, цуглаан зохион байгуулах, нам, олон нийтийн байгууллага үүсгэн байгуулах замаар эвлэлдэн нэгдэх, ажил хаялт зохион байгуулах, өлсгөлөн зарлах зэрэг олон аргаар үзэл бодлоо илэрхийлж болох тухай судлаач Ч.Өнөрбаяр санал дэвшүүлжээ. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүний үндсэн, салшгүй эрх болох тухай түүний зарим элементийг бүр эрт дээр үеэс таньж мэдсэн нь хүний өөрийн эрхэмсэг оршихуй, хувь хүн байх шинж чанар, утга учиртай салшгүй холбоотой аж. Нөгөө талаар “үг хэлэх, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг эрх, эрх чөлөөг хааж боож байсан дундад зууны үе, хэмжээлшгүй эрхт ёс, нам, хэсэг бүлгийн дарангуйллын эсрэг олон нийтийн хийсэн тэмцлийн үр дүн”⁶ байв.

Илэрхийлэх арга хэлбэрийг энэ мэтчилэн олон янзаар жагсаан бичиж болохоор байна.

“Үзэл бодол, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх” нь:

1. Мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, (үг хэлэх)⁷;
2. Бичгээр буюу хэвлэлээр (хэвлэн нийтлэх)⁸;
3. Уран сайхны хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх эрх⁹;
4. Түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрх¹⁰;
5. Эрж хайх (мэдээлэл хайх)¹¹;

5 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 34 дүгээр Ерөнхий тайлбар, Албан бус орчуулга, Женев хот, 2011 он, <https://www.gic.mn/post/147> [Сүүлд үзсэн огноо: 2021.03.20]

6 Ч.Өнөрбаяр, “Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага”, Түүх, Улс төр, Эрх зүй, УБ, 2010 он, 76 дахь тал.


7 <https://www.legalinfo.mn/law/details/367>

8 <https://www.legalinfo.mn/law/details/367>

9 <https://www.legalinfo.mn/law/details/1257>

10 <https://www.legalinfo.mn/law/details/367>

11 <https://www.legalinfo.mn/law/details/367>



6. Хүлээн авах (мэдээлэл хүлээн авах)¹²;
7. Түгээх эрх;
8. Тайван жагсаал, цуглаан хийх эрх;
9. Эвлэлдэн нэгдэх эрх;
10. Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх¹³;
11. Ажил хаях¹⁴;
12. Өлсгөлөн зарлах зэрэг “нэгэн багц” эрх, эрх чөлөөний бүрдэл юм.

Энэхүү улс төрийн эрх, эрх чөлөөний эх сурвалж, анхдагч суурь эрх бол үзэл бодлын эрх, эрх чөлөө юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад хөндлөнгийн оролцоогүйгээр үзэл бодлоо баримтлах эрхийг хамгаалсан. Энэ нь хязгаарлалтгүй, саадгүйгээр Засгийн газрыг хүлээн зөвшөөрөх ёстой эрх юм. Үзэл бодлын эрх чөлөө нь хүний хаана ч, ямар ч шалтгаанаар чөлөөтэй сонголтоор үзэл бодлоо өөрчлөх эрхэд ч хамаатай болно. Мөн Үзэл бодолтой байх эрх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө нь үзэл бодлоо илэрхийлэхгүй байх эрх чөлөөг зайлшгүй агуулж байдаг.

Үзэл бодлын эрх, эрх чөлөө нь дараах “бүлэг” эрх байна.

1. Итгэл үнэмшилтэй байх эрх¹⁵;
2. Үзэл бодолтой байх эрх;
3. Чөлөөтэй бодож сэтгэх эрх;
4. Үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах эрх;
5. Үзэл бодлоо өөрчлөх зэрэг эрхүүдээс бүрддэг¹⁶ байна.

Тэгвэл илэрхийллийн арга, хэлбэр нь түгээн дэлгэрүүлэх арга хэрэгсэл нь дараах байдлаар хуваагдаж болох юм. Үүнд:

- Амаар;
- Бичгээр;
- Хэвлэлийн болон уран сайхны аргаар;
- Өөрийн сонгосон бусад аргаар үзэл санаа, мэдээллийг хил хязгааргүй түгээх эрхтэй.

Илэрхийлэх эрхийн хэлбэр нь:

- Хүний хувийн, төрийн үйл хэргийн асуудлаарх тайлбар, ухуулга;

¹² <https://www.legalinfo.mn/law/details/367>

¹³ <https://www.legalinfo.mn/law/details/367>

¹⁴ <https://www.legalinfo.mn/law/details/565>

¹⁵ <https://www.legalinfo.mn/law/details/367>

¹⁶ Д.Оросоо, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх, түүнийгээ илэрхийллийн арга, хэлбэр”, УБ, 2002 он, 17 дахь тал.

- Хүний эрхийн талаарх хэлэлцүүлэг;
- Улс төрийн мэтгэлцээн;
- Номлол, шашны мэтгэлцээн;
- Сэтгүүл зүй, соёл, уран сайхны илэрхийлэл;
- Бусдад хичээл заах;
- Арилжааны зар сурталчилгаа.

Илэрхийллийг түгээн дэлгэрүүлэх арга хэрэгсэл нь:

- Яриа, бичиг, дохионы хэл;
- Дүрс, урлагийн бүтээл гэх мэт аман бус хэлбэр;
- Ном, сонин, товхимол, зурагт хуудас, баннер, хувцас;
- Хуулийн дагуу гомдол гаргах.

Эдгээрт дуу дүрс болон электрон, интернэтэд суурилсан бүх төрлийн илэрхийллийн хэлбэр хамаарна¹⁷. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын үзэл бодолтой байх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан 19 дүгээр зүйлд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хорооны 2011 оны 102 дугаар чуулганаар 34 дүгээр Ерөнхий тайлбарыг баталсан.

Энэ Ерөнхий тайлбарт үзэл бодолтой байх эрх нь “хүний өв тэгш хөгжлийн зайлшгүй нөхцөл бөгөөд эдгээр нь аль ч нийгмийн язгуур мөн чанар, аливаа чөлөөт, ардчилсан нийгмийн тулгын чулуу мөн” гэж заасан. Иймд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн илрэн гарах хамгийн том арга, хэлбэр болох хэвлэн нийтлэх эрх чөлөөний ойлголт, онолын үндсийг дэлгэрүүлэн авч үзье.

Хэвлэн нийтлэх эрх чөлөө түүний онолын үндэс, тавигдах хязгаарлалт

Нийтлэх гэдэг үгийн утгын талаар Я.Цэвэлийн тайлбар тольд “нийтэд тараах, хэвлэн тараах, нийтээр болгох, сонинд нийтлэх, хэвлэн нийтлэх” гэж тодорхойлж байжээ. Хэвлэн нийтлэх (англ. Freedom of press) эрх чөлөөний үүсэл нь 16-17 дугаар зууны үед анх Англи Улсаас гаралтай бөгөөд сүүлийн дөрвөн зуун жилийн турш хөгжиж буй эрх чөлөөний ойлголт юм. Хэвлэн нийтлэх эрх чөлөө нь хувийн ба улс төрийн шинжтэй харилцаанд хүний эдлэх эрхийн нэг бөгөөд мэдээллийн эрх чөлөөний бүрэлдэхүүн хэсэг юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн анхдугаар чуулга уулзалтын 1948 оны 59 дүгээр тогтоолоор “Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд ...Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тунхагласан бусад эрх, эрх чөлөөг хэмжих үндсэн хэмжүүр

¹⁷ Х.Наранжаргал, Д.Мөнхбүрэн, Л.Галбаатар, Т.Аюушжав, “Үзэл бодолтой байх эрх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө”, УБ, 2016 он, 8 дахь тал.

мөн” гэж үзсэн. Энэ эрх чөлөөг анхлан 1789 оны “Хүний ба иргэний эрхийн Францын тунхаглал”-аар баталгаажуулж байсан.

Мэдээллийн эрх чөлөөг ардчилсан нийгэмд ус агаар мэт хэрэгтэй гэж үздэг нь нэг талаас хүн амьдралынхаа асуудалтай холбоотой аливаа шийдвэрийг гаргахдаа мэдээлэлд үндэслэж байдагтай холбоотой юм. Хууль зүйн эрдэмтэн, доктор Г.Совд “Хэвлэлийн эрх чөлөөгүйгээр иргэний нийгэм эрх зүйт төр байж болохгүй тул үүнийг ардчиллын үндсэн асуудал гэж хэлэхэд хэтрүүлэг болохгүй”¹⁸ гэж дурдсан байдаг. Тэрээр цааш нь “иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрх бол тэдгээрээс үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, улс төрийн эрх чөлөөг хангах үндсэн арга хэрэгсэл гол баталгаа” хэмээн хэвлэн нийтлэх эрх чөлөөний ач холбогдлыг өндрөөр үнэлсэн байна.

Хэвлэн нийтлэх эрх чөлөөний асуудлыг үзэл бодлын эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө гэсэн хоёр томоохон ойлголтоор хэлбэрийн хувьд дамжин хэрэгждэг гэж үзэж болохоор байна. Мэдээллийн эрх чөлөө гэдэгт мэдээлэл олж авах, эрж хайх, боловсруулах, түгээх эрхүүд хамаардаг. Үндсэн хуульд мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг баталгаажуулсан. Харин хэвлэн нийтлэх эрх нь түгээх эрхтэй илүүтэй хамаарах ойлголт юм.

Хуучин нийгэм буюу социалист дэглэмийн үе болох 1990 оноос өмнө төр нь иргэдийг үг дуугүй захирч, өөртөө үйлчлүүлдэг нийгэмд бид амьдарч байлаа. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл угтаа зөвхөн нэг намд үйлчилж байв. Хуучин нийгэмд хүний үндсэн эрх болох үзэл бодлоо ямар ч хорио саадгүйгээр чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө хэрэгжих ямар ч боломжгүй юм. Иймээс 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх хэлбэрийн хувьд байснаас биш эрхээ эдлэх боломжтой эрх чөлөөний түвшинд байгаагүй гэж дүгнэж болно. Энэ үед иргэдийн хүссэн, хэрэгцээтэй мэдээллийг бус эрх барьж буй хүмүүсийн түгээхийг хүссэн мэдээллийг л олон нийтэд хүргэдэг байв. Энэ тухай хууль зүйн доктор, эрдэмтэн Б.Чимид хэлэхдээ “Бодит байдал дээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг аль ч социалист дэглэмтэй улсад цензургүй чөлөөтэй эдлүүлж байгаагүй юм”¹⁹ гэсэн тайлбар өгч байв. Харин ардчилсан нийгэм хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцахдаа төрөөс аливаа хэлбэрийн цензурыг хамгийн багаар тогтоож, зүй зохистой түвшинд нь эдлүүлэх ёстой юм.

Хэвлэн нийтлэх эрх чөлөөнд бусад үндсэн эрхэд тавигддаг хязгаарлалт нэгэн адил үйлчилнэ. Хязгаарлалтыг оногдуулахдаа хуулиар хийх, тохирсон хэмжээг оногдуулах, зайлшгүй шаардлагатайг нотолсон байх гэсэн гурван шаардлагыг нэгэн зэрэг хангасан байх ёстой. Өөрөөр хэлбэл

18 Г.Совд, “Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх” (харьцуулсан эрх зүй), УБ, 1999 он, 143 дахь тал.

19 Д.Гангабаатар, “Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал”, УБ, 2016 он, 38 дахь тал.

Үндсэн хуулийн дагуу хязгаарлаж болох хэдий ч “бусад хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг” хамгаалах зүй ёсны зорилгоор Үндсэн хуульд нийцсэн, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “хуульд үндэслэн” “хамгийн бага хэмжээнд, тохирсон хязгаарлалт” тогтоох зарчмыг баримтлах ёстой.

Профессор О.Мөнхсайхан “...үг эрх чөлөө нь туйлын эрх чөлөө биш боловч эдгээрийг зохицуулсан зохицуулалт ялангуяа хязгаарласан аливаа зохицуулалт нь Үндсэн хуулийн болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын гол нөхцөлийг хангасан байх ёстой”²⁰ гэжээ. Ямар үг яриа, үзэл бодол, үйлдлийг хамгаалах болон хамгаалахгүй байх талаар Үндсэн хуулийн бичвэрт шууд тусгаагүй тул онол, үзэл баримтлалд тулгуурлан эдгээрийг тодорхойлох шаардлагатай болно²¹. Харин профессор Ёорг Паул Мюллер “Хүний эрх, үндэсний аюулгүй байдал” гэх олон улсын симпозиумд тавьсан илтгэлдээ “Үндсэн эрх, үндэсний аюулгүй байдлын зорилтуудтай харшилдах тохиолдолд юуны өмнө хүний эрх, эрх чөлөө хөндөгдөнө. Төрөөс хүний эрхийг хэр зэрэг хязгаарлаж болох вэ? гэсэн асуудлыг шийдвэрлэх талаар маргаантай байгаа” хэмээн цохон тэмдэглээд үндсэн эрхийг хязгаарлаж болох дараах үндэслэлийг дэвшүүлсэн²². Үүнд:

- 1) Гагцхүү хуулийн үндсэн дээр;
- 2) Үндсэн хуулийн өөр заалтад захируулж;
- 3) Харьцангуйгаар;
- 4) Үндсэн эрхийн цөм хэсгийг хөндөхгүйгээр;
- 5) Хууль цаазат төрийн ямар нэг ерөнхий зарчмыг зөрчихгүйгээр хязгаарлаж болох тухай санал гаргасан байна.

Дээрхээс үзвэл хязгаарлалтыг оногдуулахдаа хуулиар хийх, хэмжээг оногдуулах, зайлшгүй шаардлагатайг нотолсон байх гэсэн гурван шаардлагыг нэгэн зэрэг хангасан байх ёстой байна. Эдгээр шаардлага нэгэн зэрэг хангагдсаны үндсэн дээр сая хязгаарлалт оногдуулахыг хүлээн зөвшөөрч болно.

Цензур гэх нэр томъёо нь англи хэлэнд “censorship”, орос хэлэнд “цензура” гэх үгээр хэрэглэгддэг. Хууль зүйн нэр томъёонд орж ашиглаж байгаа утга нь 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлд “...Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт (цензур) тогтоохгүй.” гэж хуульчилсан. Цензур гэх нэр томъёог “цагдан хяналт” гэж орчуулж хэрэглэх санал Б.Чимид багш 2000 онд гаргаж байжээ. Цензур нь

20 О.Мөнхсайхан, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь”, Эрх зүй сэтгүүл дугаар 38) 2), УБ, 2017 он, 2 дахь тал.

21 Д.Гангабаатар, “Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн хуулиар хамгаалах нь”, УБ, 2015 он, 5 дахь тал.

22 П.М. Ёорг, “Хүний эрх ба улс орны дотоод, гадаад аюулгүй байдлын асуудлууд (ялангуяа үндсэн эрхийг хязгаарлах асуудлууд)”, Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал-Олон улсын симпозиум, УБ, 1998 он, 75-76 дахь тал.

дотроо олон янз бөгөөд үүний нэг хэлбэр болох шууд цагдан хяналт, хориг тавих явдал юм.

Хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилтийг үнэлэхийн тулд олон улсын байгууллагуудаас Монгол Улсын эл эрх чөлөөнд өгсөн индексийг авч үзье. Тухайлбал Хил хязгааргүй сурвалжлагчид (Reports Without Borders) байгууллагаас гаргадаг Хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол Улс нь 2019 онд 180 орноос 73 дугаар байрт жагсаж байна. Энэхүү үзүүлэлт нь “хэвлэлийн эрх чөлөөний мэдэгдэхүйц асуудалтай орны” тоонд багтаж буй юм. Эрх чөлөөний ордон буюу (Freedom House) байгууллагын судалгаагаар 2019 онд “хэвлэлийн хагас эрх чөлөөтэй” орны тоонд багтсаар байгаа дүр зураг харагдана. Монгол Улсад хэвлэн нийтлэх эрх чөлөөний зөрчлүүдэд төрийн нууц мэдээллийн хүрээг хэтэрхий өргөн тогтоосон, сэтгүүлчийн нууц эх сурвалжаа хамгаалах асуудал Олон нийтийн, радио телевизийн ажилтнаас бусад сэтгүүлчдэд хуулиар олгогдоогүй, цахим хуудсыг эрх бүхий байгууллагаас үндэслэлгүйгээр хаадаг, эрүүгийн, зөрчлийн, иргэний хуулиар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийг шийтгэдэг зэргийг нэрлэж болох юм.

II. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН САЛБАРЫН НИЙТЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


2015 оны 5 дугаар сард Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөл Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцээд нийт 164 зөвлөмж өгснөөс 8 нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой байв. Үүнд “Эрүүгийн хуулийн нэр төр гутаахтай холбоотой зүйл заалтыг халах, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн иргэний журмаар шийдвэрлэх” гэсэн зөвлөмж ирүүлсэн. Дээрх зөвлөмжийг биелүүлэхээ амлаж, Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр 204 дүгээр тогтоол²³ гарсан байдаг. Энэ дагуу Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаас 2002 оны Эрүүгийн хуульд байсан Гүтгэх 110, Доромжлох 111 дүгээр заалтуудыг хассан. Дундын зохицуулалт гэж хэлж болох Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйл “Гүтгэх” заалтаар 30 сарын хугацаанд (2017.07.01-2020.01.10-ны өдрийг хүртэл) хэвлэн нийтлэх эрх чөлөө болон сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд төрөөс цензур тогтоож иргэнийг 2 сая төгрөгөөр, хуулийн этгээдийг 20 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж байсан. Энэхүү төрийн цензур нь эргээд эдийн засгийн цензурыг бий болгосон гэж үзэх үндэслэлтэй. Учир нь иргэн бусдыг гүтгэсэн гэх хангалттай баримт тогтоогдоогүй байхад 2 сая төгрөгөөр торгох шийтгэл оноож байсан явдал юм.

Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1-ний

²³ Засгийн газрын тогтоол, Ерөнхий төлөвлөгөө батлах тухай, УБ, 2016 он, <https://www.legalinfo.mn/law/details/12001?lawid=12001> Сүүлд үзсэн огноо: 2019.10.22

өдрөөс хойших хугацаанд тус заалтаар 2017 онд 28, 2018 онд 486, 2019 онд (тухайн оны 9 сарын байдлаар) 355 зөрчил бүртгэгдсэн байна.

Зураг 1. Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд зааснаар торгуулсан байдал. Хэвлэл мэдээллийн хараат бус байдал хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2019 оны 10 дугаар сард тавьсан илтгэлээс авав.



Үүнээс 2017 онд 4 сэтгүүлч, 2018 онд 17 сэтгүүлч, 1 хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 2019 оны (9 сарын байдлаар) 4 сэтгүүлч, 1 хэвлэл мэдээллийн хэрэгсэл тус бүр торгох шийтгэл хүлээжээ.

Гэвч 1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиараа дан ганц сэтгүүлч хариуцлага хүлээх биш хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээхээр заасан боловч эдийн засгийн цензурээс нь айж өнгөрсөн хугацаанд 20 сая төгрөгөөр редакц торгуулах биш 2 сая төгрөгөөр хувь сэтгүүлч торгуулж байсан нь тус хуулийн суурь зарчимтай Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалт нь нийцэхгүй байсныг харуулж байгаа юм.

Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан 13.14 дүгээр зүйл буюу “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэг нэмсэн бөгөөд энэ хууль 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдөр “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн. Үүнээс хойш 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 8 хүнийг шүүхээс шийтгэсэн байна²⁴. Яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн 15 хэрэг байгаа тухай Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудаст мэдээлжээ²⁵. Үндсэндээ шүүхээс дунджаар нэг сард нэг хүнийг “худал мэдээлэл” тараах гэмт хэрэгт шийтгэж байна.

Эдгээрээс үзвэл “худал мэдээлэл”, “олон нийтийг төөрөгдүүлэх” мэдээллийн тодорхойлолт байхгүйн улмаас эрх бүхий албан тушаалтан өөрийн үзэмжээр шийдэж, шийтгэл оногдуулах зэргээр урвуулан ашиглах эрсдэлтэй байна. Нөгөө талаас хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй холбоотой

²⁴ Шүүхийн шийдвэрийн цахим сан, <http://new.shuukh.mn/eruaanhan>. [Сүүлд үзсэн огноо: 2021.04.03]

²⁵ Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, УБ, 2020 он, <https://mojha.gov.mn/>. [Сүүлд үзсэн огноо: 2021.04.07]

хэргүүдэд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно” гэсэн заалттай зөрчилдөж төрийн цензур тогтоох эрсдэл бий болгож байна.

Санал 1. Монгол Улсын хууль тогтоомжид төрийн мэдээллийг заавал дамжуулах үүргийг ногдуулсан хэд хэдэн хуулийн заалт бий. Үүнийг дотор нь түгээхэд болон агуулгад тавих хяналт гэж 2 ангилан авч үзэж болох тухай судлаачийн хувьд санал дэвшүүлж байна.
/Хавсралт 1: Түгээхэд болон агуулгад тавих хяналт гэж 2 ангилсан байдал/

Мөн Онц байдлын тухай хуульд Засгийн газар “...олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох” эрхтэй гэж заасан нь төрөөс хэвлэн нийтлэх эрх чөлөөнд цензур тавих боломжийг олгож буй нэгээхэн жишээ юм.

Энд үүсч байгаа нэг хүндрэл нь садар самууны тухай заалт өөр өөр хуульд байгаатай холбоотой. Иймд садар самууны хүрээг олон хуульд янз бүрээр тайлбарлаж болно. Ингэснээр энэ салбарт олон стандартыг хэрэглэж байна. Хувь хүмүүс чухам юуг хориглосныг мэдэхэд хүндрэлтэй бөгөөд өөрөө өөрийгөө хянах хэт болгоомжлох хандлагыг үүсгэнэ. Нөгөөтэйгүүр садар самуун нь маш субъектив нэр томъёо бөгөөд түүнийг хаана ч тодорхойлоогүй. Энэ нь хийхэд хүндрэлтэй боловч хуульд садар самууныг хүрээг тодорхойлсон заалт тусгах шаардлагатай. Ингээгүй нөхцөлд шүүгч болгон садар самууныг янз бүрээр тайлбарлаж болно. Энэ байдлыг Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйл улам бүр хурцатгасан. Учир нь садар самууны шинжгүй эротик материалыг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн. Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт эротик материалыг төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Зөвлөлөөр хянуулсны дараа нийтэлж болох тухай заасан. Урьдчилан хянуулах журмыг олон орны эрх зүйн тогтолцоонд хориглосон байдаг²⁶ бөгөөд бусад оронд хяналтад (цензурт) их сэжигтэй ханддаг. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний өнцгөөс харахад садар самуун гэсэн субъектив шинжтэй асуудлын тухайд урьдчилан цензур тогтоох нь хүндрэлтэй. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар төрөөс ямар нэгэн хэлбэрийн цензур тавихгүй байх гэсэн хуулийн заалттай зөрчигдөхөд хүрч байна. Эцэст нь хэлэхэд эдгээр заалтыг хэрэгжүүлэх арга замын тухайд хүндрэл учирдаг. 1997 онд 55 сонин, сэтгүүлийг садар самуун сурталчилсан үндэслэлээр хаасан. 2000 онд гурвыг хаасан²⁷. Эдгээр арга хэмжээ нь хуулийг буруу хэрэглэхээс хамгаалахад хангалттай бөгөөд хэт туйлширсан хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаах арга хэмжээнд хэмжээнд хүргэхгүй

26 Америк дундын хүний эрхийн конвенцын 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, <http://www.globeinter.org.mn/> [Сүүлд үзсэн огно: 2021.04.09]

27 Ш.Үнэнбат, “Хэвлэл мэдээллийн орчны зохицуулалтын хэлбэр, арга механизмын тухайд” Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, УБ, 2001 он, 68 дахь тал.

асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Санал 2. Агуулга болон түгээхэд тавих хязгаарлалтыг нарийвчлан дахин хянан үзэж, нэр томъёог хуулиар оновчтой тодорхойлох, эсхүл үндэслэлгүйгээр тогтоосон хязгаарлалтыг хүчингүй болгох зэргээр хэвлэн нийтлэх эрх чөлөөнд учруулж буй цензурыг “зохистой хэмжээнд нь аваачих” шаардлагатай байна.

III. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй²⁸ гэж заасан. Энэ хуулийн дагуу урьдчилсан цензур тогтоох эрх мэдэл бүхий тусгай байгууллага байж болохгүй.

Мэдээ, мэдээллийн цахим хуудсыг хаах нь гагцхүү зохиогчийн эрхтэй холбоотой бус, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдаж буй цензурын шинжтэй үйлдэл юм. Энэ тухай тодорхой жишээнд тулгуурлан тайлбарлая.

“Амжилт.ком” цахим хуудас нь 2014 оны 7 дугаар сарын сарын 3-ны өдөр “Ерөнхий сайдын “Хаан жимс” амралтын газар Туул гол руу бохироо асгаж байна” гэсэн мэдээллийг байрлуулан олон нийтэд түгээсний улмаас дараагийн өдөр нь тус сайтад хандах дотоодын хандалтыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос зогсоосон. Шүүхэд гаргасан гомдлын дагуу Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 615 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 143 дугаар магадлал, Улсын дээд шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоолоор Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Дээрх тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хорооны даргыг төрөөс буюу Ерөнхий сайд томилдог бөгөөд өөрийн хувь эзэмшдэг амралтын газрынх нь эсрэг мэдээлэл цацагдсанд тухайн сайтыг хаах хүртэл арга хэмжээ авах эрх хэмжээ байгаа нь хэвлэлийн эрх чөлөө зөрчигдөх эрсдэл бий болгож байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан амжилт.ком цахим хуудасны хандалтыг хаасан үйлдэл нь үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг ноцтой хязгаарласан бөгөөд уг хязгаарлалт 3 талт шалгуурын шаардлагыг хангаагүй, зүй ёсны бус

28

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, <https://www.legalinfo.mn/law/details/546?lawid=546>

хязгаарлалт болсон тухай²⁹ дурджээ. Түүнчлэн тус хорооноос олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт тавьж, тогтоолд заасан журмын дагуу бус аргаар арга хэмжээ авсан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасан “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт (цензур) тогтоохгүй” гэсэн заалтыг зөрчиж, бодит байдалд хэвлэл мэдээллийн агуулгад цензур тогтоосон үйлдэл болсныг гурван шатны шүүхийн шийдвэрээр тогтоосон байна. Үүний цаана нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар олон нийтийн үнэн бодит мэдээлэл авах эрх, түүнд үйлчилж буй хэвлэл мэдээллийн эрх чөлөөг ноцтой зөрчсөн үйлдэл болсон юм.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсэн, хэвлэн нийтэлсний төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар хуульчилсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахад нэг алхам урагшилсан. Эрүүгийн хуулийн 14.3 дугаар зүйлд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдахыг гэмт хэрэгт шинээр тооцох болсон. Тухайлбал “Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол...” гээд хүлээх хариуцлагад торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заасан байна. Гэвч энэ хууль хэрэгжиж эхэлсэн 2 жил гаруйн хугацаанд энэ зүйл ангиар нэг ч хүн ял шийтгэл хүлээгээгүй байна³⁰. Мөн Эрүүгийн хуулийн 19.11 дүгээр зүйлд Төрийн нууц мэдээллийг хууль бусаар олж авахыг гэмт хэрэгт тооцсон нь хэвлэн нийтлэх эрх чөлөөг эдлэхэд саад учруулаад байна. Эрүүгийн хуульд анх удаа орсон тус зүйл заалтаар 2017 онд сэтгүүлч тагнуулын байгууллагад шалгагдсан тохиолдол бүртгэгдсэн³¹.

Өмнөх Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйл (2002) Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад учруулах зүйл ангиар эрүүгийн хариуцлагатай байсан бол шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдахыг гэмт хэрэгт тооцсон нь Үндсэн хуулиар баталгаажсан эрх ашгийг хамгаалснаараа өргөн хүрээг хамарсан, тусгай субъект шаардаагүй зэргээрээ давуу талтай болсон гэж судлаачийн хувьд дүгнэж болохоор байна.

29 Ж.Хүслэн, “Хэвлэн нийтлэх эрх чөлөө ба цензур”, <https://legaldata.mn/> 2018 он, 42 дахь тал.

30 А.Билгүүн, “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг эрүүгийн эрх зүйгээр хамгаалах арга, хэлбэр тулгамдсан асуудал”, УБ, 2018 он, 11 дэх тал.

31 Глоб Интернэшнл төв, “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан-2019”, УБ, 2020 он, 8 дахь тал. <https://www.gic.mn/post/r/646>. [Сүүлд үзсэн огноо: 2021.04.17]

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Худал мэдээлэл тараасныг нотолсон шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ:

А/ Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 689 дүгээр шийтгэх тогтоол

1/ Гэмт хэргийн шинжийн талаар:

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл (Худал мэдээлэл тараах)-ийн 1 дэх хэсэгт зааснаар “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” бол 450,000-аас 1,300,000 төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1-3 сар хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Энэ зохицуулалтаас харахад, дараах ойлголт гарч ирж байна. Үүнд:

- хүний “нэр төр”, “алдар хүнд”;
- хуулийн этгээдийн “ажил хэргийн нэр хүнд”;
- “илт худал мэдээлэл”;
- “олон нийтэд тараах”.

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 689 дүгээр шийтгэх тогтоолд Х.Н-ын нэр төр, алдар хүндийг тодорхойлоогүй, тухайн шүүгдэгчийн фэйсбүүкт оруулсан бичвэр нь илт худал мэдээлэл гэдгийг тодорхойлоогүй, “олон нийтэд тараах” гэдгийг “...бичвэр, зураг бүхий постыг 14 хэрэглэгч хуваалцаж /шэйрлэж/, 16 хэрэглэгч уг постод дүрс зураг дарж постыг үзсэн болох нь тогтоогджээ” гэж тайлбарласан байна.

Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй, мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, яланд ашигтайгаар шийдвэрлэнэ. Тэгэхээр шүүхээс дээрх хэргийг шийдвэрлэхдээ Х.Н-ын “нэр төр”, “алдар хүнд”, түүнд халдсан “илт худал мэдээлэл” гэх ойлголтыг заавал тайлбарлах ёстой байжээ.

2/ Нотлох баримт, нотолбол зохих байдлын талаар:

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 689 дүгээр шийтгэх тогтоолд дараах нотлох баримтыг шинжлэн судалжээ. Үүнд:

- Шүүгдэгч Х.А-гийн шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэг, мөрдөн шалгах ажиллагааны явцад яллагдагчаар өгсөн мэдүүлэг;
- Хохирогч Х.Н-ын мөрдөн шалгах ажиллагааны үед өгсөн мэдүүлэг;
- Гэрч Г.Б-ын мөрдөн шалгах ажиллагааны үед өгсөн мэдүүлэг;
- Галт Бороо нэртэй фэйсбүүк хаяганд үзлэг хийсэн тухай тэмдэглэл;
- Гар утсанд үзлэг хийсэн тухай тэмдэглэл;
- Шүүгдэгч Х.А-гийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас;
- Шүүгдэгч Х.А-гийн иргэний үнэмлэхийн лавлагаа, түүний хувийн байдлын талаарх баримтууд.

Эндээс харахад “Галт Бороо нэртэй фэйсбүүк хаяганд үзлэг хийсэн тухай тэмдэглэл”-ийг тооцохгүй бол шүүхийн шийдвэр үндсэндээ мэдүүлэгт тулгуурлажээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүх хуралдааны явцад дараах байдлыг нотолно:

- гэмт хэрэг гарсан байдал (гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал);
- гэмт хэргийг хэн үйлдсэн;
- гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;
- Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;
- гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;
- гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.

Дээрх шүүхийн шийдвэрт гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоогоогүй байна. Зөвхөн эдгээр асуудлаар “улсын яллагчийн эрүүгийн хариуцлагын талаарх санал, шүүгдэгч болон түүний өмгөөлөгчийн өмгөөллийн үг зэргийг тус тус харгалзан үзлээ” гэжээ. Харгалзан үзэх бус, нотлох ёстой зүйл юм.

Х.Н-ын зүгээс “худал мэдээлэл тараах” гэмт хэргээс сэргийлэх арга хэмжээ авсан эсэхийг шүүх тодруулаагүй байна. Х.Н-ын мэдүүлэгт “...Энэ сэдвээр хамгийн анх 2018 онд хавраас эхлэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр намайг дээрх хуулийн заалтыг санаачилж батлуулсан мэтээр

гүтгэж, доромжилсон илт худал мэдээлэл явагдаж эхэлсэн бөгөөд үүнийг эсэргүүцэж тайлбар хийх, олон нийтэд зөв ойлголт өгөх зав чөлөө тэр болгон гараад байдаггүй юм” гэж хэлснээс харахад иргэдэд үнэн, бодит мэдээлэл өгөөгүй нь тус гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөл болжээ.

Шүүгдэгч мэдүүлэгтээ “...цахим сайт болон олон нийтийн телевизээр 14 настай хүүхдийг насанд хүрсэн хүн гэж үзнэ гэсэн утгатай мэдээлэл явж байсан. Уг мэдээллийг уншихад Х.Н-ын санаачилсан хуульд тэгж тусгагдсан байна гэсэн утга бүхий мэдээлэл фэйсбүүкээр яваад байхаар нь би үнэхээр тийм хууль санаачилж батлуулсан юм байх гэж бодоод, өөрөө охин хүүхэдтэй учир Х.Н-ын санаачилсан гэх хуулийг нь эсэргүүцэж пост бичсэн юм. Би Х.Н-ыг үнэхээр тийм хууль санаачилсан эсэхийг нягтлаагүй, буруу ташаа мэдээллийг олон нийтийн сүлжээнээс харж өөрийн цахим хуудсанд байршуулж, бусдад түгээсэндээ маш их харамсаж байна. Би Х.Н-ыг 14 настай охинтой бэлгийн харьцаанд орж болно гэсэн хууль санаачлаагүй гэдгийг мэдээд өөрийн оруулсан постоо устгасан. Мөн өөрөөс нь фэйсбүүк чатаар нь уучлалт гуйсан” гэжээ.

Б/ Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 726 дугаар шийтгэх тогтоол

1/ Гэмт хэргийн шинжийн талаар:

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 726 дугаар шийтгэх тогтоолд тайлбарлаагүй, “шүүгдэгч Х.Г-гийн дээрх Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан “...үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх...” гэсэн эрхээ эдэлж, одоогийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.5 дугаар зүйлд заасан “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэсэн гэмт хэргийн төрлийг шүүмжилж, өөрийн “Х.Заяа” нэртэй хувийн цахим хуудаснаас олон нийтийн сүлжээгээр тараахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлд хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх гэж заасан үүргээ биелүүлэлгүй ... гэж бичиж, Х.Н-ыг уг гэмт хэргийн төрлийг шинээр санаачлан Эрүүгийн хуульд тусгаж хууль тогтоогчоор батлуулсан мэтээр бусдад ойлгуулан нэр төр, алдар хүндэд нь халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэжээ.

2/ Нотлох баримт, нотолбол зохих байдлын талаар:

Шүүхээс нотлох баримтыг жагсааж бичсэн байх бөгөөд аль нотлох баримтаар ямар үйл баримтыг нотолж байгааг тайлбарлаагүй байна. Тухайлбал шүүгдэгч Х.Г-гийн “Самсунг Нөүте-8” маркийн гар утсанд

...2020 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 22 цаг 6 минутад татаж авсан, 66.96 кв хэмжээтэй, 991x859 нарийвчлалтай, PB-IMG-1589033806429.jpg гэсэн нэрээр хадгалагдсан Х.Н-ын зурагтай “гаж донтнууд хууль зохиож баталсаар байх уу”, “14 настай охинтой бэлгийн харьцаанд орж болно...” гэсэн бичвэртэй 1 ширхэг зураг юуг нотолж байгаа талаар тайлбарлаагүй байна.

З/ Шүүхээс хэрэглэвэл зохих эх сурвалжийн талаар:

Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар мөн адил хамгаалдаг. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хорооны 2011 оны 7 дугаар сарын 11-29-ний өдөр хуралдаж, 102 дугаар чуулганаар хэлэлцэн баталсан. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 34 дүгээр Ерөнхий тайлбарын 42 дахь хэсэгт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэгч, сэтгүүлчдийн гагцхүү Засгийн газар, эсхүл Засгийн газрын дэмжлэгтэй улс төр, нийгэм, хуулийн тогтолцоог шүүмжилсний төлөө шийтгэл ногдуулахыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зайлшгүй хязгаарлалт гэж хэрхэвч үзэж болохгүй” тухай дурдсан. Түүнчлэн тус тайлбарын 47 дахь хэсэгт “... нийтийн албан тушаалтнуудтай холбоотой тайлбар сэтгэгдлийн хувьд шийтгэх, санамсаргүй алдаа гаргаж, хорон санаа агуулалгүйгээр хэвлэн нийтэлсэн материалыг үнэн бус, хууль бус гэж үзэхээс зайлсхийвэл зохино” тус тус заасан. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь заалтад “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасныг үндэслэн олон улсын хэм хэмжээг баримтлах ёстой байна. Улс төрийн өндөр албан тушаалтны гаргасан гомдол дээр иргэн, сэтгүүлчийг буруутган яллах талыг барих ёсгүй байсан. Улс төрийн өндөр албан тушаалтан өөрөө хүсэж энэ албыг хашдаг бөгөөд олон нийтийн шүүмжлэлд хүлээцтэй хандах үүрэгтэйгээр жирийн иргэнээс ялгаатай байдгаараа онцлогтой. Үүнээс үзвэл шүүхээс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, түүний нэмэлт 34 дүгээр тайлбарыг шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгтээ баримтлахгүй байна.

В/ Иргэн Х.Г-ийн гомдлоор хянан шийдвэрлэсэн Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 2020/ДШМ/1402 дугаар магадлал

Б.П-ийн давж заалдах шатны шүүхэд гаргасан тайлбарт: Энэхүү хэрэг нь сэтгүүл зүйн гэхээсээ илүүтэй иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд бичсэн сэтгэгдэл байсан. Иймд нягтлах шалгах үүрэг сэтгүүл зүйн салбар шиг жирийн иргэнд оногддоггүй. Мөн шүүгдэгч Х.Г нь олон нийтийн санаа бодлыг дамжуулсан төдий бөгөөд үүнийг гомдол гаргагч Х.Н мэдүүлэгтээ хүлээн зөвшөөрсөн. Шинжээчийн 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 2552 дугаар дүгнэлтэд “Коммунистууд өөрсдөө

бага насны охидуудаар зугаагаа гаргахаа бодоод нэгэнт батлагдаж гаргасан 14 настай хүүхдийг хүчиндэж болох хуулиа өөрчлөхгүй. Тэр хүчирхийлэгчдэд чинь эрүүгийн хэрэг үүсгэх боломж байхгүй. Чи 14 настай. Өнөөгийн Улсын Их Хурлын гишүүдийг сонгож гаргасан ээж, аавдаа гомд” гэсэн зурагт эвлүүлгийг үйлдсэн тухай дурдагдаагүй байдаг. Гэтэл анхан шатны шүүхээс алийг нь Х.Г бичиж сэтгэгдэл үлдээсэн алийг нь цахим орчноос татаж утсандаа авсан бэ? гэдэгт дүгнэлт хийлгүй гэм буруутайд тооцож шийтгэл оногдуулсан зэрэг алдаа гаргасан. 3 тусдаа өөр дүрс, сэтгэгдэлд нэг хүнээс үйлдсэн мэтээр хамтатгаж шийтгэвэр оногдуулсан тухай дурддаг.

Шүүхээс шийдвэрлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг ноцтой зөрчөөгүй. Нотлох баримтуудыг хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн шүүхээс үнэлж, дүгнэх боломжтой, хоорондоо зөрүүгүй, гэмт хэргийн үйл баримтыг нотолж чадсан гэж үзэн Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.09.04-ний өдрийн 726 дугаар шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн талаарх шүүхийн шийдвэр хангалтгүй, үндэслэл бүхий байж чадахгүй байна. Энэ нь шүүгчийн төдийгүй мөрдөгч, прокурор, өмгөөлөгчийн туршлага, ур чадвартай хамааралтай байна.

Худал мэдээлэл тараах гэмт хэргийн үндсэн шинж болох “илт худал мэдээлэл”-ийг хууль тогтоомжид тайлбарлаагүй, хохирогчийн зүгээс тийнхүү худал мэдээлэл тараахаас сэргийлэх, худал мэдээллийг залруулах хангалттай арга хэмжээ авсан эсэхийг харгалздаагүй, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу шийдвэрлэж болох иргэний гэм хорын асуудлыг эрүүгийн хууль тогтоомжоор шийдэж байгаа нь буруу байна.

Нийгэмд нэгэнт тогтсон ойлголтыг дамжуулсны төлөө тухайн иргэдийг буруутгаж шийтгэвэр оногдуулж байгаад анхан, давж заалдах шатны шүүхээс дүгнэлт хийгээгүй байна. Мөн хууль тогтоомж, нийгмийн систем болох Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйл Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийг шүүмжлэхдээ иргэн Х.Н-ыг холбож бичсэн иргэн бүрд шүүхээс шийтгэвэр оногдуулж буй нь буруу бөгөөд тус хэрэгт анхны шийтгэвэр Х.Н-ын талд гарснаар нэр төр, алдар хүнд нь халдсан болох нь тогтоогдох боломжтой байсан юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс 2015 онд Монгол Улсад өгсөн дараах зөвлөмж болон Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-г бүрэн хэрэгжүүлж, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиас “илт худал мэдээлэл тараах”, “олон нийтийг

төөрөгдүүлэх худал мэдээ, мэдээлэл түгээсэн” зэрэг гэмт хэрэг, зөрчлийг хасах шаардлагатай байна. Үүний тулд:

- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хүлээсэн Монгол Улсын үүрэгт бүрэн дүүрэн нийцүүлэх;
- Нэр төр гутаахыг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх;
- Интернэт орчинг оролцуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг бүх орчинд баталгаажуулах;
- Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон иргэний нийгмийн идэвхтэн, хүний эрхийн хамгаалагчид өөрсдийн үйл ажиллагаагаа олон улсын стандартад заасны дагуу аливаа шийтгэн цээрлүүлэх явдлаас ангид айдасгүйгээр чөлөөтэй эрхлэх бололцоогоор хангах;
- Олон нийтийн зүтгэлтэн, улс төрийн өндөр албан тушаалтантай холбоотой хэргийг шийдвэрлэхдээ олон улсын хэм хэмжээг баримтлах, шүүмжлэлт сэтгэлгээг хүлээн зөвшөөрөх;
- Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх, төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сурвалжилсан, шүүмжилсний улмаас мөрдөн хавчигдах, эсхүл дарамт шахалтад орохоос хамгаалах орчинг бүрдүүлэх;
- Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэргээс хасах, олон улсын хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн Иргэний хуульд заасан журмаар шийдвэрлэх;
- Эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлохтой холбоотой зүйл, заалтыг шүүмжлэлийг таслан зогсоох зорилгоор ашиглахгүй байх, сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон шүгэлдэгчийг хамгаалах зохицуулалтыг бий болгох.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Эцэст нь дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Нэг. Хэвлэн нийтлэх эрх чөлөө нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд илэрхийлэх эрх чөлөө, түүний арга, хэлбэрээрээ ялгагддаг байна. Хэвлэн нийтлэх эрх чөлөөнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт, бусад үндсэн эрхийн хязгаарлалт нэгэн адил үйлчилдэг. Хязгаарлалтыг оногдуулахдаа хуулиар хийх, тохирсон хэмжээг оногдуулах, зайлшгүй шаардлагатайг нотолсон байх гэсэн 3 шаардлагыг нэгэн зэрэг хангасан байх ёстой байна. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн дагуу хязгаарлаж болох ч “бусад хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам”-ыг хамгаалах зүй ёсны зорилгоор Үндсэн хуульд нийцсэн, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “хуульд үндэслэн” “хамгийн бага хэмжээнд, тохирсон хязгаарлалт” тогтоох зарчмыг баримтлахаар байна.

Хоёр. 2002 оны Эрүүгийн хуулиар Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулсан хэргийг гэмт хэрэгт тооцож байсан бол шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдахыг гэмт хэрэгт тооцох болсноор тусгай субъект шаардаагүй, Үндсэн хуулийн үндсэн эрхийг хамгаалсан зэргээрээ давуу талтай болжээ. Мөн хүнийг үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх нь хэвлэн нийтлэх эрхийн нэг томоохон баталгаа болж байна. Энэ үндсэн дээр дараах цөөн хэдэн саналыг дэвшүүлж байна.

- Агуулга болон түгээхэд тавих хязгаарлалтыг нарийвчлан дахин хянан үзэж, нэр томъёог хуулиар оновчтой тодорхойлох эсхүл хүчингүй болгох замаар шийдвэрлэх хэрэгтэй гэсэн саналыг энэхүү өгүүллээрээ дэвшүүлж байна.
- Хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилтийн хязгаарлалтыг дотор нь агуулгын болон түгээхтэй холбогдсон хязгаарлалт гэж авч үзсэнээр зохисгүй хязгаарлалтыг холбогдох хуулиудаас хасах, хүчингүй болгох нь төрөөс ямар нэгэн хэлбэрийн цензурыг бий болгохгүй байх зарчимтай нийцсэнээрээ хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах хамгийн үр нөлөө бүхий шийдэл гэж үзэж байна.

	№	Холбогдох хууль	Холбогдох заалт	Заалтын ерөнхий агуулга
Түгээхэд тавих хязгаарлалт	1.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль	15.2	Урьдчилан сэргийлэх мэдээг радио, телевиз болон мэдээллийн бусад хэрэгслээр түүнийг хүлээн авснаас хойш 15 минутын дотор тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлнэ.
	2.	Дайны байдлын тухай хууль	5.4, 6.3	Хэвлэл мэдээллийнхэн дайн эхэлсэн буюу дууссан тухай зарлах ёстой.
	3.	Гамшгаас хамгаалах тухай хууль	10.5	Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна.
	4.	Цагдаагийн албаны тухай хууль	59.1.2	Шуурхай мэдээлэл нийтэд түгээх шаардлага гарсан тохиолдолд өмчийн харьяалал харгалзахгүйгээр хэвлэл, мэдээлэл, холбооны хэрэгсэл ашиглах
	5.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль	8.1.5	Залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах
	6.	Хог хаягдлын тухай хууль	42.2.3	Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хог хаягдлын талаарх үндэсний уламжлал, зан заншил, тэргүүн туршлага, хууль тогтоомжийг сурталчлах
	7.	Зөрчлийн тухай хууль	5.13.3	Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээ, мэдээллийг үнэ төлбөргүйгээр, саадгүйгээр мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

	№	Холбогдох хууль	Холбогдох заалт	Заалтын ерөнхий агуулга
Агуулгад тавих хязгаарлалт	1.	Садар самуунтай тэмцэх тухай хууль	3.1.1	“Садар самууныг сурталчлах” гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг;
	2.	Эрүүгийн хууль	16.8	Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол;
	3.	Эрүүгийн хууль	16.9	Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол;
	4.	Соёлын тухай хууль	19.3	Дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, соёлд хор хохирол учруулах соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглоно;
	5.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	32.6	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, түүний ул мөрийг нуун далдлах арга, хэрэгслийг нарийвчлан дүрсэлсэн, гэмт хэрэг, зөрчлийг ашиг, орлогоо нэмэгдүүлэх хэрэгсэл болгон харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдэл төрүүлж болох агуулгатай аливаа мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхийг хориглоно;

	№	Холбогдох хууль	Холбогдох заалт	Заалтын ерөнхий агуулга
Агуулгад тавих хязгаарлалт	6.	Садар самуунтай тэмцэх тухай хууль	5.1	Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно;
	7.	Зөрчлийн тухай хууль	5.13.1	Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Х.Н-ын гомдлоор шүүхээс 2 хүнийг “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт буруутгаж, ял ногдуулсан байна.

№	Шүүхийн шийдвэрийн нэр	Шийдвэрлэсэн шүүх, шийдвэрийн огноо, дугаар	Хэргийн агуулга
1.	О овогт Х.А-д холбогдох эрүүгийн хэрэг	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 689 дүгээр шийтгэх тогтоол	Шүүгдэгч Х.А нь 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн нутаг дэвсгэрээс өөрийн “Гал Бороо” нэртэй фэйсбүүк цахим хуудсаас олон нийтийн сүлжээгээр Х.Н-ыг “Н. чи 14 настай охиныг яаг яасын!!! МАНАН чинь чамайг ингэж дасгалжуулаа юу...”, “Коммунистууд өөрсдөө бага насны охидоор зугаагаа гаргахаа бодоод нэгэнт баталж гаргасан 14 настай хүүхдийг хүчиндэж болох хуулиа өөрчлөхгүй”, “Тэр хүчирхийлэгчдэд нь чинь эрүүгийн хэрэг үүсгэх боломж байхгүй. Чи 14 настай. Өнөөгийн Улсын Их Хурлын гишүүдийг сонгож гаргасан ээж, аавдаа гомд” гэж нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай” гэж үзэж иргэн Х.А-г 450,000 төгрөгөөр торгох ял ногдуулсан.
2.	Х.Г-д холбогдох эрүүгийн хэрэг	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 726 дугаар шийтгэх тогтоол	Х.Г нь 2020 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Улаанбаатар хотын нутаг дэвсгэрээс өөрийн Х.Заяа нэртэй фэйсбүүк цахим хуудаснаас олон нийтийн сүлжээгээр “Х.Н-ын гаргасан хууль 14 настай охин хүчиндвэл 450.000 төгрөгөөр торгуулаад л болоо, охины чинь хохь болно. Ийм новшийн юмнуудыг төрд дахин бүү арга. Коммунистууд өөрсдөө бага насны охидоор зугаагаа гаргахаа бодоод нэгэнт баталж гаргасан 14 настай хүүхдийг хүчиндэж болох хуулиа өөрчлөхгүй. Тэр хүчирхийлэгчдэд чинь эрүүгийн хэрэг үүсгэх боломж байхгүй. Чи 14 настай. Өнөөгийн Улсын Их Хурлын гишүүдийг сонгож гаргасан ээж, аавдаа гомд” гэж нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэм буруутай” гэж үзэж иргэн Х.Г-г 500,000 төгрөгийн торгох ял ногдуулсан.

V. НОМ ЗҮЙ:

1. Монгол эх сурвалж:

1. А.Билгүүн, “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг эрүүгийн эрх зүйгээр хамгаалах арга, хэлбэр тулгамдсан асуудал”, УБ, 2018 он.
2. Глоб Интернэшнл төв, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан-2018, УБ, 2018 он.
3. Х.Наранжаргал, Д.Мөнхбүрэн, Л.Галбаатар, Т.Аюушжав, “Үзэл бодолтой байх эрх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө”, УБ, 2016 он.
4. Г.Совд, “Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх” (харьцуулсан эрх зүй), УБ, 1999 он.
5. Д.Гангабаатар, “Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал”, УБ, 2016 он.
6. Д.Оросоо, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх, түүнийгээ илэрхийллийн арга, хэлбэр”, УБ, 2002 он.
7. Д.Гангабаатар, “Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн хуулиар хамгаалах нь”, УБ, 2015 он.
8. О.Мөнхсайхан, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь”, Эрх зүй сэтгүүл, №2 (38), 2017 он.
9. Ч.Өнөрбаяр, “Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага” Түүх, Улс төр, Эрх зүй, УБ, 2010 он.
10. Ш.Үнэнбат, “Хэвлэл мэдээллийн орчны зохицуулалтын хэлбэр, арга механизмын тухайд” Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, УБ, 2001 он.
11. Я.Цэвэл, Монгол хэлний тайлбар толь, УБ, 1966 он.

2. Гадаад эх сурвалж:

1. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, (1946).
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, (1966).
3. Америк Улсуудын хүний эрхийн конвенц, (1978).
4. П.М. Ёорг, “Хүний эрх ба улс орны дотоод, гадаад аюулгүй байдлын асуудлууд (ялангуяа үндсэн эрхийг хязгаарлах асуудлууд)”, Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал-Олон улсын симпозиум, УБ, (1998).

3. Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Хөдөлмөрийн тухай хууль, (1999).
3. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, (2005).
4. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, (1998).

4. Бусад:

1. Засгийн газрын тогтоол, Ерөнхий төлөвлөгөө батлах тухай, УБ, 2016 он, <https://www.legalinfo.mn/law/details/12001?lawid=12001> [Сүүлд үзсэн огноо: 2019.10.22]
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 34 дүгээр Ерөнхий тайлбар, Албан бус орчуулга, Женев хот, 2011 он, <https://www.gic.mn/post/147> [Сүүлд үзсэн огноо: 2021.03.20]
3. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020.02.13, №07 /1109/ <http://parliament.mn/n/wzmy> [Сүүлд үзсэн огноо: 2021.01.21]
4. Шүүхийн шийдвэрийн цахим сан, <http://new.shuukh.mn/eruanhan> [Сүүлд үзсэн огноо: 2021.04.03]
5. Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, УБ, 2020 он, <https://mojha.gov.mn/>. [Сүүлд үзсэн огноо: 2021.04.07]

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



М.ХАТАНЗОРИГ

Шихихутуг их сургуулийн багш,
хуульч, докторант

ХУВЬ ХҮНИЙ ДАНГААРШИХ ЭРХИЙН ТАЛААРХ
АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ГОЛЛОХ ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ЗАРИМ ҮР ДАГАВАР
№1: КАТЗЫН МАРГААН

UNITED STATES SUPREME COURT LANDMARK
DECISION RELATED TO PRIVACY, AND ITS
IMPACT №1: KATZ CASE

Хураангуй: Технологийн үсрэнгүй хөгжлөөс шууд хамааралтай дижитал эринд хувийн орон зай, мэдээллийн халдашгүй байх эрх улам чухал болж буй. Зөвхөн хувь хүний субъектив эрхийн хувьд бус, нийгэм олон нийтийн хувьд ч ач холбогдолтой төдийгүй энэхүү эрхийн хамгаалалт нь үндэсний аюулгүй байдал¹, эрх чөлөөний талаар үүсэн бүрэлдэж буй шинэ парагдигмын хувьд чухал аспект болно. Уг өгүүллийн эхний хэсэгт хувийн орон зай, мэдээллийн халдашгүй байдлыг (privacy) нэр томъёоллын хувьд Монгол хэлнээ “дангааршил” хэмээн орчуулах талаар товч санал дэвшүүлж, хоёрдугаар хэсэгт сэдвийн талаарх Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүхийн голлох шийдвэрүүдийн нэг Катзын хэргийг тоймлон үзэж, орчуулсан. Сэмвүэл Д.Варрен, Льюс Брендэйс нарын 1890 оны “Дангаарших эрх” өгүүллээс хойш өнөөг хүртэл дангааршлыг тодорхойлох олон оролдлого

1

М.Хатанзориг, “Хувийн мэдээллийн ашиглалт, хамгаалалт үндэсний аюулгүй байдлын уламжлалт бус сорилт болох нь: Эрх зүйн шинэчлэлээр шийдвэрлэх арга зам”, УБ, 2021 он.

онолын түвшинд хийгдэж байна. Катзын кейс эл эрхийн талаарх хууль зүйн практикт нэвтрүүлэн шийдвэрлэсэн, тайлбарласан анхны хэргүүдийн нэг болох төдийгүй шүүгч II Жонн Маршалл Харланы тайлбар, санал нь хожим “Катзын сорил” хэмээн нэрлэгдэх болсон хууль хэрэглээний аргыг үндэслэсэн байна. Өгүүллийн гуравдугаар хэсэгт уг сорилын талаар авч үзлээ.

Түлхүүр үг: Дангааршил, хувийн халдашгүй байдал, катзын сорил, Катз, хилийн зааг зөрчих, дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт.

Abstract: Privacy is one of the most important rights in this digital era. Not only for individual, but for the public; and protection of this right has great consideration in national security, even in new paradigm of freedom. In the first section of this article, I suggested terminological translation of “privacy” in Mongolian-“Дангааршил”. In the second section I translated and reviewed one of the US Supreme Court landmark decisions related to privacy (Katz v. United States 389 U.S. 347 (1967)). After Samuel D. Warren and Louis Brandeis’s article (Right to privacy. Harvard Law Review 193 (1890)), which often cited as the first explicit finding of this topic, there have been a lot of attempts to clearly and precisely define the “right to privacy”. Katz case is one of the first legal practices that was exercised at Supreme Court and its Justice John Marshall Harlan II’s concurring opinion has become even more well-known than the majority opinion. It describes a two-part test which has come to be known as the “Katz Test”, which I explored in the third section of this article.

Keywords: Privacy, right to privacy, katz test, katz, doctrine of tiespassing, the fourth amendment.

I. ХУВИЙН ОРОН ЗАЙ, МЭДЭЭЛЭЛ ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХИЙН НЭР ТОМЪЁОЛЛЫН АСУУДАЛ: ДАНГААРШИХ ЭРХ

Англи хэлний “privacy” буюу дангаар байх, бусдаас хүртэхүйн болон мэдэхүйн хувьд тусгаар байх ойлголтыг монгол хэлэнд шууд нэг үгээр оноож орчуулахад бэрх болжээ. Учир нь Privacy гэсэн ганц үг нь нийгмийн хөгжлийн явцад ганцаараа байх, хувийн орон зай нь аливаа хүртэхүйн халдлагаас хамгаалагдах, ямарваа шийдвэр гаргахдаа бусдын нөлөөллөөс ангид байх, хувийн мэдээллээ хянах, удирдах, дижитал хэлбэртэй мэдээллээ бусдад шилжүүлэхээс татгалзах зэрэг олон талын ойлголтыг хамарсан цогц ухагдахуун болжээ. Энэ үг нь философийн болон хууль зүйн ойлголт болохынхоо хувьд мэргэжлийн нарийн төвөгтэй утгыг агуулдаг. Англи хэлийг төрийн албан ёсны хэлээр тунхагласан улс орнуудын хувьд ч уг ойлголтыг утгын хувьд оновчтой тодорхойлох, агуулгын хүрээг нь зөв тогтоох талаар маргаантай байгааг судлаачид тэмдэглэж буй². Privacy гэх ухагдахуун хууль зүйн болон ёс зүйн ойлголт болохынхоо хувьд цаашид

2

Adam Moore, Daniel J. Solove, Roscoe Pound, Paul A. Freund, Alan Westin, Anita Allen, Ruth Gavinson гэх мэт.

хувьсан өөрчлөгдөх, агуулга нь хумигдах буюу улам өргөжих магадлалтай байна.

Олон улсын туршлагаас үзэхэд хувийн орон зай, мэдээллийг хамгаалахын тулд позитив эрх зүйн хүрээнд хамгаалагдах боломжтой аспектиудыг тодорхойлон зохицуулж байгаа боловч тэрхүү норматив тодорхойлолт нь уг агуулгыг бүрэн хамарч чаддаггүй. Нөгөөтэйгүүр (1) “right to privacy” жам ёсны эрх хэмээн хүлээн зөвшөөрч тайлбарлахын тулд, (2) эрх зүйн зохицуулалтаас гадна хувийн мэдээллээ хамгаалах, хянах талаар иргэдийн боловсролыг сайтар хөгжүүлэх ёстой учраас үүнийг норматив эрх зүйн тодорхойлолтоор явцууруулан орчуулж, ойлгох нь тохиромжгүй.

Хүний эрх, аюулгүй байдлын ач холбогдлын үндэслэлээр хүмүүсийн хувийн орон зай, мэдээллийн халдашгүй байдлын талаарх мэдрэмжийг хөгжүүлэх, эл ойлголтын үнэ цэнийг ухамсарлан хүндэтгэдэг нийгмийн нийтлэг төлөвшлийг бий болгохын тулд философийн талаас нь энэхүү ухагдахууныг тогтмол сийрүүлж эргэн харах, сорьж байх шаардлагатай. Тиймээс нийгэм, ёс зүйн ойлголт болохынх нь хувьд “privacy” одоо байгаа норматив эрх зүйн тодорхойлолтоор шууд ойлгож болохгүй юм.

Хууль зүйн практикт “хувийн мэдээлэл халдашгүй байх эрх, хувийн мэдээллийн халдашгүй байх эрх, хувийн халдашгүй байдлын эрх” зэрэг нэршлийг хэрэглэж байгаа боловч агуулгаа бүрэн эсвэл оновчтой хамарч чадахгүй байна. “Privacy” нь зөвхөн “data” буюу дижитал өгөгдөл, “information” буюу мэдээлэл зэрэг ойлголтоор хэмжигдэхгүй бөгөөд бусдаас ангид хувийн орон зайтай орших тухай ухагдахууныг мөн өөртөө багтаадаг. Түүнчлэн Үндсэн хуульд заасан “Security of person” буюу “халдашгүй байх эрх, хууль бус мөрдлөг, баривчилгаанаас ангид байх”-аас агуулгын хувьд ялгаатай. Монгол Улсын хууль зүйн салбарт “халдашгүй байх эрх” гэсэн нэр томъёоны цаана, дээр дурдсан бие махбод, орон байрны халдашгүй байдлыг ойлгож заншсан учраас уг нэршлийг ашиглах нь прагматик талаасаа мөн тохиромжгүй байна.

Хэдийгээр “privacy” агуулгын хувьд хувийн орон зай, мэдээллийн халдашгүй байдлыг ойлгож байгаа боловч түүнийг тайлбарлах онол, хандлагаас шалтгаалаад тодорхой контекстэд дангаар байх эрх, шийдвэр гаргахдаа бусдын нөлөөллөөс ангид байх эрх зэрэг ялгаатай бөгөөд бие даасан утгуудыг илэрхийлдэг. Манай үндэсний эрх зүйн тогтолцоонд одоогийн байдлаар хувийн нууц, хувийн өгөгдлийг хамгаалах агуулгаар хуульчлагдсан боловч эрхийн хувьд илүү өргөн агуулгатай учраас өөр нэршлээр оноож орчуулах шаардлага гарцаагүй тулгарч байна. Тэр тусмаа аюулгүй байдал, хүний эрхийн хүрээнд ач холбогдол нь улам өндөрсөж, нэр томъёоны хувьд цаашдаа салбар бүхэнд олонтаа хэрэглэгдэх ухагдахуун болж байгаа учраас (1) байнга олон үгээр (дор хаяж 3-аас дээш үг ашиглаж) ярих буюу бичих, (2) хам утгаас шалтгаалаад тохиолдол

бүрт өөр өөр үгсээр (хувийн мэдээллийн халдашгүй байдал, хувийн орон зайн халдашгүй байдал, амьны эрх, хувийн халдашгүй байх эрх гэх мэт) нэрлээд байж болохгүй юм.

Монгол хэлэнд “мэдээллийн халдашгүй байдал”-аас гадна “амьны эрх”, “хувийн эрх” гэх мэт “right to privacy” төсөөтэй үгс бий. Гэвч хууль зүйн мэргэжлийн ойлголт болохынхоо хувьд тэдгээр нь өмнө нь хэрэглэж хэвшсэн өөр өөр утгуудыг илэрхийлж, нэгэнт “эзэнтэй” болсон байна. Гэвч тэдгээрээс илүү тохиромжтой нэршил нь “дангаарших эрх” юм. Хэдийгээр шинэ тутам дурдагдах болсон “дангааршил” гэх ойлголтыг олон улсын харилцааны утгаар нийтийн хэрэглээнд нэвтрээд удаагүй “даяаршил” хэмээх хөрш үгтэй нь эсрэгцүүлэн ашиглах нь түгээмэл боловч зөвхөн тусгаар улс орнууд, соёл-уламжлалын сэдвийн агуулгаар хязгаарлан ойлгохгүй.

Хувь хүн, байгууллага, тусгаар улс гээд нэг биш олон байдаг ямар ч зүйлсэд бусдаасаа тусдаа, дангаар байх ойлголт яригдах боломжтой. Монгол хэлний тайлбар тольд “дангаарчлал”-ыг “Нийт даяараас ангид өөрийн шинжээ хадгалан хөгжүүлэх нь” гэж, “дангаарчлах”-ыг “Дан өөрийн онцлогоор хөгжүүлэх” гэж тайлбарласан байна. Уг үгээр олон улсын харилцааны сэдвийн хүрээнд аливаа улс орон өөрийн онцлогоо хадгалан хөгжихийг ойлгох ба хууль зүйн бичвэрт, эрх болохынхоо хувьд дангаар орших, дангаар байдлаа мэдээллийн болон хүртэхүйн хувьд хадгалах, хамгаалах агуулгаар ойлгож болох юм. Тиймээс уг орчуулга, өгүүлэлд “privacy” агуулгыг “дангааршил” гэсэн үгээр оноолоо.

II. КАТЗЫН МАРГААН

KATZ V. UNITED STATES 389 U.S. 347 (1967)³

Америкийн Нэгдсэн Улсын Лос Анжелес хотын иргэн Чарлз Катзтай холбоотой тус улсын Дээд шүүхийн уг кейс нь Үндсэн хууль дахь хүртэхүйн дангааршлын агуулгыг өргөтгөн тайлбарлаж хууль зүйн практикт хэрэглэсэн чухал ач холбогдолтой. Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт буюу Хүний эрхийн биллд цагдаа, эрх бүхий гүйцэтгэх албан хаагч нь зохих албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр хэн нэгнийг нэгжих, баривчлах, эд хөрөнгийг нь хураах зэрэг ажиллагаа явуулж болохгүй талаар тусгагдсан. Гэвч Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийн хүрээг тодорхойлохдоо хүн, орон байр, захидал харилцаа зэрэг физик объектын хүрээгээр хязгаарлаж байсан бол уг хэрэгт “тухайн хүн өөрөө хувийн буюу дангааршлын орон зайд нь хамааралтай хэмээн үзсэн” зүйлийг уг хамгаалалтад хамааруулан маргааныг шийдвэрлэжээ. Мөн уг хэргээр Катзын сорил буюу аливаа нөхцөл байдлыг дангааршилд

3

1967 оны 12 дугаар сарын 18-ны өдөр шийдэгдсэн.

хамааруулах эсэхийг тогтооход хэрэглэх хоёр шаардлагыг боловсруулсан юм. Энэхүү шийдвэрээс өмнө тагнах, чагнах төхөөрөмж нь Үндсэн хуулийн зохицуулалтад хамаарах эсэх нь тодорхойгүй байсан боловч уг хэргээр тэдгээрийг хамааруулан үзэж, цаашдаа гүйцэтгэх эрх мэдэл бүхий байгууллагын алба хаагч уг төхөөрөмжийг хэрэглэхдээ зохих зөвшөөрөл авах ёстой хэмээх номлол тогтжээ.

Хураангуй:

Нэхэмжлэгч Чарлз Катз нь муж хооронд спортын бооцооны мэдээллийг телефон утсаар дамжуулан 18 U.S.C. § 1084-г зөрчиж яллагдсан. Холбооны мөрдөх товчооны тусгай ажилтнууд нэхэмжлэгчийн утсаар ярьсан бүхээгийн гадна чагнах төхөөрөмж байрлуулан яриаг нь чагнаснаа нотлох баримт болгон шүүхэд танилцуулсан байна. Дээд шатны шүүхүүд Холбооны мөрдөх товчоо “ялсны байсан бүхээгийн дотор нэвтэрч ороогүй” тул дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлтийг зөрчөөгүй буюу түүний дангаарших эрхэд халдаагүй хэмээн үзээд ялыг хэвээр үлдээжээ⁴. Нэхэмжлэгч Дээд шүүхэд хандан дараах 2 асуултыг тавьсан байна. Үүнд:

- Нэхэмжлэгчийн утсаар ярьсан, Холбооны мөрдөх товчооны чагнах төхөөрөмж суурилуулан нотлох баримт цуглуулж авсан нийтийн утасны бүхээг нь Үндсэн хуулиар хамгаалагдсан хувийн орон зайд хамаарах эсэх;
- Үндсэн хуулиар хамгаалагдсан хувийн орон зай, дангаарших эрхэд халдсан гэж үзэхийн тулд тухайн орон зайд заавал бодитоор нэвтэрч орсон байх шаардлагатай эсэх⁵.

Дээд шүүхийн гишүүн Стюард дээрх асуултыг нэхэмжлэлийн шаардлага хэмээн хэлэлцүүлгийн агуулгыг явцууруулахаас татгалзаж, уг хэрэг дэх дангаарших эрхийн асуудлыг илүү өргөн хүрээнд хянан хэлэлцэхийг санал болгож байжээ. Тэрээр дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлтийг дангаарших эрхийн тухай суурь зохицуулалт тогтоосон буюу түүний агуулгыг бүрэн илэрхийлсэн гэж үзэж болохгүйн сацуу уг зохицуулалт дахь Үндсэн хуулийн хамгаалалтыг “тухайлсан орон байр, физик орон зай”-аар тодорхойлон ойлгохгүй хэмээн тайлбарласан байна. Түүнчлэн дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт нь дангаарших эрхийн талаар тодорхой хамгаалалт тогтоосон боловч тухайлсан тохиолдолд илүү өргөн агуулга илэрхийлэх, эсхүл түүнтэй огт хамааралгүй байдлаар ч ойлгогдож болох ба дангаарших эрхийн Үндсэн хуулийн хамгаалалт зөвхөн уг зохицуулалтаар хязгаарлагдахгүй бөгөөд тухайлбал нэгдүгээр нэмэлт, өөрчлөлтөөр мөн уг эрхийг хамгаалсан хэмээн үзжээ.

⁴ *Katz v. United States*, 389 U.S. 347, (1967) syllabus.

⁵ Мөн тэнд, 3, 4 дүгээр догол мөр.

Шүүгч Стювардын илтгэлээс тодотгон хураангуйлбал:

“Нэхэмжлэгч, хариуцагчийн маргаж байгаа утасны бүхээг нь Үндсэн хуулиар “хамгаалсан газар” мөн үү, биш үү гэх зөрчилдөөн нь маргах ёстой гол асуудал биш. Дангаарших эрхийн хамгаалалт нь дангааршиж буй хүн буюу субъектэд тулгуурладаг бөгөөд тухайлсан газар, орон байрны асуудлыг чухалчлаагүй. Хүн хүсвэл өөрийн гэр, ажлын байр зэргийг зориудаар бусдад нээлттэй байлгах боломжтой бөгөөд энэ тохиолдолд тэр газар нь дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлтийн зохицуулалтад хамаарахгүй⁶ төдийгүй харин өөрөө дангаарших орон зай хэмээн нууцлахыг хүссэн аливаа газар нь бусад этгээд нэвтрэх боломжтой байсан ч түүний дангааршилд хамаарч, Үндсэн хуулиар хамгаалагдах ёстой⁷ юм.

Засгийн газар нэхэмжлэгчийн утасны бүхээг нь шилээр хийгдсэн тул гаднаасаа олон нийтэд ил харагдаж байсан гэж буй боловч нэхэмжлэгч нь утасны бүхээгт орсноороо бусдад харагдахаас татгалзсан бус хувийн яриагаа бусдаас нууцлахыг хүссэн байна. Албан ажлын өрөө⁸, найзынхаа гэр⁹, такси¹⁰ зэрэгтэй адилхан утасны бүхээгт орсноор бусдад харагдах боловч сонсогдохгүй болдог учраас яриагаа нууцалсан тухайн газар нь Үндсэн хуулийн хамгаалалтад хамаарна. Үндсэн хуулийг явцууруулан тайлбарласнаар тэрхүү “нийтийн утас”-ны бүхээг нь түүнийг ашиглан ярьж буй хүний “хувийн яриаг дамжуулах” үндсэн зорилго, гол шинжээ алдах юм.

Зарим хэргийн хувьд хувийн орон зайд бодитоор нэвтрэн орсон байх нь дангаарших эрхийн зөрчлийн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог нь үнэн боловч¹¹ энэ нь нэгжлэг хийх, эд хөрөнгө хураах зэрэгт хамааралтай¹². Түүнчлэн шүүгч Стювард, Катз гэмт хэрэг үйлдэж байсан учраас Холбооны мөрдөх товчооны нотлох баримт цуглуулах ажиллагаанд “чухал шаардлага” байсан нь үнэн боловч чагнах төхөөрөмж байрлуулах зөвшөөрөл аваагүй байсныг цохон тэмдэглэжээ.

Шийдвэр

Шүүгчдийн 7-1-ийн харьцаатайгаар шүүх Катзын талд шийдвэр гаргаж, Холбооны Мөрдөх Товчоо чагнах төхөөрөмж ашигласан нь нэхэмжлэгчийн дангаарших эрхийг зөрчсөн гэж үзээд тийнхүү цуглуулсан нотлох баримтыг хүчингүйд тооцсон байна. Ингэхдээ:

- 6 Энэ хэсэгт дараах хэргүүдийг эш татсан: *Lewis v. United States*, 385 U.S. 206, 210, 87 S.Ct.424, 427, 17 L.Ed.2d 312; *United States v. Lee*, 274 U.S. 559, 563, 47 S.Ct.746, 748, 71 L.Ed. 1202.
- 7 Энэ хэсэгт дараах хэргүүдийн эш татсан: *Rios v. United States*, 364 U.S. 253, 80 S.Ct. 1431, 4 L.Ed.2d 1688; *Ex parte Jackson*, 96 U.S. 727, 733, 24 L.Ed. 877.
- 8 Энэ хэсэгт дараах хэргийг эш татсан: *Silverthorne Lumber Co. v. United States*, 251 U. S. 385.
- 9 Энэ хэсэгт дараах хэргийг эш татсан: *Jones v. United States*, 362 U. S. 257.
- 10 Энэ хэсэгт дараах хэргийг эш татсан: *Rios v United States*, 364 U. S. 253.
- 11 Энэ хэсэг дараах хэргүүдийг эш татсан: *Olmstead v. United States*, 277 U. S. 438, 277 U. S. 457, 277 U. S. 464, 277 U. S. 466, *Goldman v. United States*, 316 U. S. 129, 316 U. S. 134-136.
- 12 *Katz v. United States*, 389 U.S. 347 (1967).

- Дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт дэх дангаарших эрхийн хамгаалалт нь зөвхөн материаллаг эд хөрөнгийг хураахад үйлчлээд зогсохгүй, аман хэлбэрийн яриаг тагнах, чагнахад мөн хамаарна¹³.
- Дээр дурдсан хамгаалалт нь ямар нэг газар, орон зайг бус хүнийг өөрийг нь хамгаалдаг учраас аливаа зөрчлийг зөрчил мөн гэж үзэхийн тулд хүний хувийн орон зайд бодитоор нэвтрэн орсон байх шаардлагагүй¹⁴ гэжээ.

Эсрэг санал

Шүүгч Хьюго Блэк ганцаараа эсрэг саналтай байсан ба дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт нь гагцхүү материаллаг эд хөрөнгийг хураан авах үед үйлчилдэг бөгөөд чагнах төхөөрөмж нь бусдын яриаг нууцаар сонсохтой адил агуулгатай ба хэрэв чагнах төхөөрөмжийн талаар тодорхой зохицуулалт хийхийг хүссэн бол Хүний эрхийн билл зохиогчид зохимжтой үгсийг сонгож ашиглах байсан гэжээ.

Дангаарших эрх ба хилийн зааг зөрчих

Катзын хэргийг шийдвэрлэхийн тулд шүүх нэгжлэг ба эд хөрөнгө хураахтай холбоотой буюу дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлтийн хэрэглээний түүхийг товч сөхөөд Олмстэдийн хэрэгт¹⁵ тулгуурласан “хил зааг зөрчлийн номлол”¹⁶ хүчтэй байр суурь эзэлж байсныг дурджээ. Уг номлолоор дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт нь аливаа газар, орон байранд “нэвтрэн орох”-той холбоотой хамгаалалт, зохицуулалт тогтоосон гэж тайлбарладаг бөгөөд Олмстэдийн хэргээр тагнах, чагнах төхөөрөмж ашиглан дуу хоолой, яриаг байшингийн гаднаас хурааж авсан нь дангаарших эрхийн зөрчил биш гэж үзжээ¹⁷.

Шүүхийн шийдвэрт:

“Бид Олмстэдийн болон бусад төсөөтэй хэргүүдийг шийдвэрлэхэд тулгуур болж асан хил заагийн зөрчлийн номлолыг цаашид баримтлах ёсгүй хэмээн үзэж байна. Нийтийн утасны бүхээг ашигласан нэхэмжлэгчийн дангаарших эрхийг Засгийн газар электрон төхөөрөмж ашиглан яриаг


13 Энэ хэсэгт дараах хэргийг эш татсан: *Silverman v. United States*, 365 U. S. 505, 365 U. S. 511. P. 389 U. S. 353.

14 Энэ хэсэгт *Olmstead v. United States*, 277 U.S. 438 (1928) хэргийг цохон дурдаж, уг хэрэг дэх “хилийн зааг зөрчих” тухай номлол ач холбогдлоо алдсан талаар тайлбарлажээ.

15 *Olmstead v. United States*, 277 U.S. 438 (1928).

16 *Trespass doctrine* буюу хилийн заагийн номлолыг Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүх 1928 онд шийдвэрлэсэн Олмстэдийн хэргээс үүдэлтэй гэж үздэг. Уг номлолын агуулга нь хувийн орон зайн халдашгүй байдал нь гагцхүү тодорхой физик орон зайд гэм буруутай этгээд биечлэн нэвтэрсэн тохиолдолд зөрчигддөг гэх үзэл юм. Катзын маргаан хүртэл хувийн орон зайн халдашгүй байдлын зөрчлийг ийм агуулгаар тодорхойлж ирсэн бол эл маргаанаар технологийн хөгжил нь биечлэн нэвтрэлгүй хүний дурдсан эрхийг зөрчих боломжтой хэмээн тайлбарласан.

17 Мөн тэнд.



нь бичиж авах байдлаар зөрчсөн бөгөөд уг эрх нь дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлтийн “нэгжлэг, эд хөрөнгө хураах”-тай холбоотой хэсгийн агуулгад хамаарна” гэжээ¹⁸.

Олмстэдийн хэргээр электрон төхөөрөмж ашиглан гаднаас чагнах нь хувийн орон зайд халдсан гэж үзэхгүй ба учир нь тэрхүү төхөөрөмжийг орон байрны дотор байрлуулалгүй гаднаас ашигласан буюу материаллаг хувийн орон зайд нэвтрээгүй хэмээн дүгнэсэн нь хэд хэдэн хэрэгт жишиг болон хэрэглэгдсэн ба гаднаас чагнах нь дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлтийн “нэгжлэг” хэсэгт хамаарахгүй гэж үзсэн ч Катзын хэргээр хувийн орон зайн хүрээ хязгаар, агуулгыг шинээр тодорхойлж дангаарших эрхийг өмнөх практикаас илүү өргөтгөн тайлбарлажээ.

III. КАТЗЫН СОРИЛ: ДАНГААРШЛЫН ҮНДЭСЛЭЛ БҮХИЙ ТӨСӨӨЛӨЛ

Нийтлэг эрх зүйн тогтолцоон дахь уян хатан байдлын зарчмын дагуу хувийн орон зай, дангаарших эрхийн объектыг хуулиар нэрлэн зохицуулахаас ерөнхийдөө татгалздаг. Иргэнлэг эрх зүйн тогтолцоонд¹⁹ цахим орчин дахь хувийн өгөгдлийг тодорхойлох замаар цахим орчинд хувь хүнийг хамгаалах оролдлогууд хийгдэж байна. Дангаарших эрхийн агуулгыг тодорхойлох арга зүйн талаар олон улсад янз бүрийн судалгаа, туршилтууд хийгдэж буйн нэг нь Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүхэд Катзын маргааныг шийдвэрлэхэд баримталсан сорил юм.

Шүүгч II Жонн Маршалл Харланы уг хэрэгт дэвшүүлсэн сорил нь Катзын сорил хэмээн нэрлэгдэж хожим өөр хэрэгт ч хэрэглэгджээ. Харлан шүүгчдийн олонхийн шийдвэртэй санал нэг байгаагаар илэрхийлэхийн сацуу шүүгч Стювардын “Дангаарших эрхийн хамгаалалт нь ямар нэг газар бус, дангааршиж буй хүн буюу субъектэд тулгуурладаг... Хүн хүсвэл өөрийн гэр, ажлын байр зэргийг зориудаар бусдад нээлттэй байлгах боломжтой бөгөөд энэ тохиолдолд тэр газар нь дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлтийн зохицуулалтад хамаарахгүй” гэснийг дэлгэрүүлэн тодруулж тусдаа санал бичжээ. Тэрээр “Хүн субъектив болон объектив байдлаар хувийн орон зайтай, ганцаараа байх үндэслэл бүхий хүлээлт, төсөөлөлтэй байсан л бол дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлтөөр дангаарших эрх нь хамгаалагдана” хэмээгээд үндэслэлээ дараах байдлаар хураангуйлжээ.

“Шүүхийн шийдвэрт тусгагдсан дангааршлын тайлбар буюу зохицуулалт нь хоёр төрлийн шаардлагыг хангасан байх ёстой гэж ойлгогдож байна. Нэгдүгээрт хүн өөрөө хувийн орон зайтай байх бодитой хүлээлттэй байсан (субъектив); хоёрдугаарт тэрхүү хүлээлт нь нийтээр хүлээн зөвшөөрсөн зан

18 Katz, 389 U.S. at 353; LaFave, Wayne R. (2012). *Search and Seizure: A Treatise on the Fourth Amendment* (5th ed.). St. Paul: Thomson/West § 2.1(b), pp. 578–79.

19 Civil law system.

суртахууны хэм хэмжээнд нийцсэн, үндэслэл бүхий байх ёстой. Тухайлбал орон гэр бол хүний хувийн орон зайд гарцаагүй хамаарах боловч бусдын “хараанд ил” эд хөрөнгө, үйл ажиллагаа зэрэг нь тэдгээрийг “бусдаас далд байлгах зорилго агуулаагүй” тул дангааршлын объектэд хамаарахгүй. Нөгөөтэйгүүр олон нийтийн дэргэд хэлэлцсэн яриа, харилцаа нь хувийн шинжтэй биш учраас үндэслэл бүхий гэж үзэхгүй (Hester v. United States, 265 U.S. 57 (1924)).

Мөн “нийтийн утасны бүхээгт орж хаалгыг хаан төлбөр төлж холбоо ашиглаж эхэлснээр” тухайн бүхээг нь тэр хүний хувийн орон зай болон хувирч буй. Гол санаа нь тухайн бүхээг бусад үед олон нийтэд нээлттэй байдаг нь бус, яг хэрэглэгдэж буй тухайн үедээ бусдаас тусдаа байх, дангаарших орон зай болж байгаад оршино”.

Хуулиар хувийн эсхүл нийтийн орон зайд хамаарах газар, объект бүрийг тухайлан нэрлэхэд бэрхшээлтэй тул түүнийг ялгах тодорхой арга зүйг тогтоох нэг оролдлого нь Катзын сорил юм. Уг сорил нь аливаа объектыг дангаарших эрхэд хамаарах эсэхийг шийдвэрлэх зорилгоор ашиглагддаг. Тухайлбал тодорхой газар (өрөө, бүхээг, машин, талбай гэх мэт) хувийн орон зай мөн эсэх, тодорхой мэдээлэл (явсан газрын мэдээлэл, интернэт хандалтын түүх гэх мэт) нь хувийн нууцад тооцогдох эсэх, тодорхой харилцаа (олон нийтийн газар дахь харилцан яриа, цахим шуудан, утсаар ярилцсан яриа гэх мэт) хувийн харилцаа мөн эсэх гэх мэт. Гэвч энэхүү сорил нь хүний дангаарших эрхийн агуулгыг тодорхойлохгүй бөгөөд гагцхүү маргаан үүссэн тухайн нөхцөл нь хувийн орон зайд хамаарах уу, үгүй юү гэдгийг таслан шийдвэрлэх ач холбогдолтой.

Дангаарших эрхийн цогц онолын дагуу хүний дангааршил нь олон талын нөхцөл бүрдсэн тохиолдолд хангагддаг бөгөөд бүгд хоорондоо нягт уялдаж нэг нэгнээ нөхцөлдүүлдэг боловч зөрчигдсэн тохиолдолд позитив эрх зүйн хүрээнд тус тусад нь салгаж хянан шийдвэрлэдэг. Тухайлбал хувийн орон зайд халдах, хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй авах, эсхүл захидал харилцааны нууцыг задлах зөрчлийг эрх зүйн харилцааны хувьд тус тусад нь шийдвэрлэх бөгөөд эдгээрээс ердөө нэг нь л зөрчигдсэн тохиолдолд хүний дангаарших эрх хумигдаж позитив эрх зүйн хувьд зөрчигдөөгүй бусад төрлийн дангааршил бүрэн хэрэгжих боломжгүй болно. Жишээлбэл гэртээ юу хийж байгаа талаараа найздаа илгээсэн цахим зурвасыг нууцаар уншсан нь тухайн хүний гэрт орж хувийн орон зайд нь халдаагүй боловч харилцааны буюу мэдээллийн нууцад нь халдсанаар “хувийн орон зайгаар хамгаалагдаж буй” эрхийг нь давхар зөрчинө.

Позитив эрх зүйд зөрчилд хамаарах эрх зүйн харилцааг тусгаарлаж шийдвэрлэдэг учраас Катзын сорилоор зөвхөн тухайн зөрчигдсэн байж болзошгүй дангааршлын асуудлыг авч үздэг. Тиймээс уг сорил нь дангаарших эрхийн агуулгыг бүрэн хамрахгүйн дээр хүний дангааршил

хангагдаж байгаа эсэхийг бүхэлд нь тогтоох зорилгогүй юм. Хүн гэртээ байхдаа, интернэт ашиглахдаа, нийтийн хоолны газар хооллохдоо, утсаар ярихдаа, ажлын өрөөндөө байхдаа тус бүр хувийн орон зай, дангааршлын өөр өөр хүлээлт, төсөөлөлтэй байдаг. Иймд тодорхой төрлийн маргаан дахь дангаарших эрхийн асуудал нь ерөнхий эрхийнхээ хувьд харьцангуй явцуу шинжтэй байдаг учраас Катзын сорилоор зөвхөн тодорхой нөхцөл дэх, тодорхой төрлийн дангааршлыг л хянан шүүдэг.

Катзын сорилын цөм нь “хувийн орон зайн үндэслэл бүхий төсөөлөл” бөгөөд аливаа орон зайг дангаарших буюу бусдаас тусгаар орших боломжтой хэмээн бодсон хувь хүний хүлээлт юм. Учир нь сорилын философи үндэслэл нь “хуулиар тогтоосон дангаарших эрхийн хамгаалалт нь ямар нэгэн материаллаг эд хөрөнгө, газар бус тухайн эрхийг эдлэх хүнд тулгуурладаг” гэх тайлбар мөн. Өөрөөр хэлбэл дангаарших эрхийн талаарх хуулийн үзэл баримтлал нь эд хөрөнгө, газрыг бус хүнийг хамгаалдаг гэсэн үг. Тиймээс хүн өөрөө тодорхой газрыг хувийн орон зай гэж бодсон, төсөөлсөн нь нийгмийн нийтлэг үнэлэмжээр зөвтгөгдвөл тухайн газар нь Үндсэн хуулийн хамгаалалтад хамаарна. Гэвч нөгөө талаар, энэ өнцгөөс дангаарших эрх хамгийн их хамаатай орон гэр ч бас зарим тохиолдолд хувийн орон зайд тооцогдохгүй байх боломжтой.

Хүн өөрөө орон гэрээ бусдад нээлттэй байдлаар ашигласан буюу бусдаас аливаа хэлбэрээр тусгаарлагдах оролдлого хийгээгүй эсхүл зориудаар бусдыг урьсан тохиолдолд дангаарших эрх хязгаарлагдана. Тухайлбал тагтан дээрээ утсаар ярих, хөшгөө нээлттэйгээр цонхныхоо дэргэд тодорхой үйлдэл хийх, эсвэл үдэшлэг уулзалтын зориулалтаар бусдыг урьж оруулах зэрэг тохиолдолд тухайн нөхцөлөөр дамжин бусдын олж авсан мэдээлэл нь хүний дангаарших эрхийг зөрчихгүй. Тиймээс дангаарших эрхийн хамгаалалт нь зөвхөн Үндсэн хуулийн хүрээнд бус өмчийн эрх зүй зэрэг бусад субъектив эрхийг зохицуулсан хэм хэмжээнд тулгуурлах ёстой гэсэн үзэл санаа бас бий.

Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүхийн зарим хэрэг дээр²⁰ өмчийн эрх зүйн зохицуулалт нь хувийн орон зайн объектив төсөөллийг тодорхойлох чухал үндэслэл болно гэж үзсэн. Өөрөөр хэлбэл хувийн орон зайн талаарх субъектив төсөөллийг нийгмийн үнэлэмжээр зөвтгөхөд тэрхүү орон зай нь өмчийн эрх зүйн дагуу тухайн хүний өмчлөлийн зүйл, эсхүл хууль ёсны буюу шударга эзэмшлийн зүйл байх нь чухал үндэслэл болох юм. Энэ нь хувийн орон зайн талаарх субъектив хүлээлт, төсөөлөл нь “үндэслэл бүхий” байсан эсэхийг тодорхойлох объектив арга зүйн нэгдмэл ойлголтод хүрээгүй²¹ байгаатай холбоотой.

20 *Rakas v. Illinois*, 439 U.S. 128 (1978).

21 Америкийн Нэгдсэн Улсын шатны шүүхүүд “үндэслэл бүхий” гэдгийг өөр өөрөөр шийдвэрлэж байгаа бэрхшээлийн талаар судлаачид түгээмэл дурддаг. Тухайлбал Jason C. Miller. (2012) *Do Not Disturb: Fourth Amendment Expectations of Privacy in Hotel Rooms*. *Seton Hall Circuit Review*: Vol. 7 : Iss. 2 , Article 1; Orin S. Kerr (2007), “Four Models of Fourth Amendment Protection”, *Stanford Law Review*, 60 (2): 504–05.

Хамрах хүрээ:

Хэдий уг сорил нь анх хүртэхүйн дангааршил буюу хувийн материаллаг орон зайн талаарх маргааныг шийдвэрлэхэд ашиглагдсан боловч технологийн хөгжлийн явцад хувийн орон зайн талаарх ойлголт өргөжин дижитал орчинд ч хувь хүн дангаарших эрхтэй байхыг хүлээн зөвшөөрснөөр мэдээллийн болон харилцааны дангааршилд ч хамаарах болсон байна. Катзын хэргээр нийтийн утасны бүхээг хувийн орон зайд хамаарах эсэхийг шийдвэрлэсэн бол түүнээс хойш хүний цахим шуудан, яриа, байршил тогтоогч төхөөрөмж ашиглан бичигдсэн мэдээлэл, гар утас болон компьютерын хэрэглээ, хувийн болон түрээсийн машин, интернэт хандалт зэрэгт ч хувийн орон зайн төсөөлөл байх тул маргаан гарсан үед аль ч орчинд дангаарших эрх зөрчигдсэн эсэхийг тогтоох шаардлага тулгарсаар буй.

Бүрэлдэхүүн:

Катзын сорилын дагуу хувийн орон зай, дангаарших эрхийн талаар хоёр төрлийн төсөөлөл байдаг бөгөөд тэрхүү хоёр төсөөлөл нь хоорондоо нийцсэн буюу давхцсан тохиолдолд дангаарших эрх хууль ёсоор хэрэгжиж буй гэж үздэг. Тэдгээр нь: (1) хэн нэгэн этгээдийн аливаа объектыг хувийн орон зай, нууцад хамаарах буюу дангаарших эрхийн объект мөн гэж бодсон хүлээлт, бодомж (субъектив төсөөлөл), (2) тухайн объектыг мөн этгээдийн эрхэд хамаарна гэж хүлээн зөвшөөрсөн нийгмийн нийтлэг үзэл, төсөөлөл (объектив үнэлэмж) юм.

Субъектив төсөөлөл: Тухайн хүн аливаа харилцаа, мэдээллийг өөрийн хувийн нууц гэж бодсон; тодорхой газар, орон зайг дангаарших боломжтой буюу бусдаас далд, тусгаар байх боломжтой, хувийн орон зай мөн хэмээн итгэсэн, тийнхүү үнэлсэн байхыг ойлгоно. Катзын хэрэгт нэхэмжлэгч нийтийн утасны бүхээгт орж утсаар ярихдаа өөрийнх нь яриаг хэн нэгэн сонсохгүй хэмээн итгэсэн учраас тухайн утасны бүхээгийг хувийн орон зай гэж үзэх субъектив хүлээлтийн шаардлага хангагдсан гэж шүүх үзсэн байна²². Дангаарших субъектив төсөөлөл байсан гэж үзэхэд тухайн этгээдийн өөрийн оролдлого, үйл ажиллагаа тухайн төсөөлөлд тулгуурласан байх нь чухал үзүүлэлт болно. Хэрэв тухайн хүн яриа, эд хөрөнгө гэх мэт аливаа зүйлээ дангааршлын объект болгож бусдаас далдлах оролдлого хийгээгүй бол эсвэл бусдаас далд гэж өөрөө итгэх нөхцөл үүсгээгүй бол субъектив төсөөлөл байсан гэж үзэхгүй.

Объектив буюу хууль ёсны үнэлэмж: Тухайн нөхцөл, газрыг хуулиар буюу нийгмийн нийтлэг төсөөллөөр хувийн орон зай мөн гэж үзэхийг ойлгоно. Үүнд нэг талаас норматив эрх зүйн хэм хэмжээ үйлчлэх бол нөгөө талаас нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээг харгалзах ёстой.

22 *Katz v. United States*, 389 U.S. 347.

Өмнө дурдсанчлан газар бүрийг нэрлэн зохицуулах боломжгүй учраас олон нийтийн эсхүл хувийн орон зайн нэн тодорхой хэсгүүд нь позитив эрх зүйд шууд тусгалаа олдог ба бусад объектой холбоотой маргаанд нийгмийн бусад буюу ёс суртахуун, зан суртахууны хэм хэмжээг хэрэглэх шаардлага тулгардаг. Тухайлбал олон нийтийн задгай талбай дахь аливаа объект, орон зайд “хувийн орон зайн төсөөлөл” үндэслэлгүй байна²³ хэмээх номлол зарим улс оронд²⁴ үйлчилж байгаа бол бусад объект дангаарших эрхэд хамаарах эсэх талаар шинэ шинэ маргаанууд үүссээр байна.

Тиймээс хэрэг болгонд дангааршлын төрөл, хэлбэрээс шалтгаалаад объектив үнэлэмжийг хуульд заагаагүй бол шүүх өөр өөр шийдвэр гаргах боломжтой. Тухайлбал (1) суултуур тус бүр нь битүү тоосгон хана, зузаан хаалгаар тусгаарлагдсан (дуу тусгаарлалт өндөр) нийтийн ариун цэврийн өрөө эсвэл (2) суултуур нь дээр доороо зайтай нимгэн модон ханаар тусгаарлагдсан (дуу тусгаарлалт бага) нийтийн ариун цэврийн өрөөнд утасны яриа чагнасан эсэхэд объектив үнэлэмж нь өөр байна. Аль аль өрөөнд утсаар яригч этгээд дангааршлын талаарх субъектив төсөөлөлтэй байсан ч нэгдүгээр өрөөний талаар объектив үнэлэмж, хоёрдугаар өрөөнийхтэй харьцуулахад хавьгүй өндөр байх юм.

Ялангуяа гэмт хэргийн нотлох баримт цуглуулахын тулд үндэслэл бүхий объектив үнэлэмжтэй газарт заавал зөвшөөрөлтэйгөөр нэгжлэг хийх ёстой бол нийтэд ил тод газраас эд мөрийн баримт цуглуулахад тийнхүү зөвшөөрөл авах шаардлагагүй. Тухайлбал Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүх 1988 онд цагдаа гадна хогийн саванд ил харагдаж байгаа объектыг баримтжуулж авахад зөвшөөрөл шаардлагагүй, учир нь тухайн нөхцөлд хэн нэгний хувийн орон зайд халдаж магадгүй үндэслэл бүхий объектив үнэлэмж байхгүй гэж үзжээ²⁵.

Объектив үнэлэмжийг тодорхойлох шүүхийн ажиллагаанд мөрдөн шалгах ажиллагааны журам, өмчийн эрх зүйн зохицуулалт, Үндсэн хуулийн бусад хэсгийн үзэл баримтлал гээд олон төрлийн хүчин зүйлс нөлөөлдөг. Катзын сорилоор дангаарших эрхэд хамаарах хувийн орон зай мөн хэмээн үзсэн газруудад хүний орон гэр, байрлаж буй зочид буудлын өрөө зэргээс гадна нийтийн үйлчилгээний буюу олон нийтийн бусад газар дахь хувийн орон зайд зориулсан хэсгүүд, тухайлбал Катзын хэрэгт авагдсан утасны бүхээг, хоолны газрын тусгай өрөө, такси ч²⁶ хамаарна. Зарим судлаач хорих байрны хувьд хоригдолд зориулсан хэсэг ч мөн үүнд хамаарна гэж үзсэн байна²⁷.

23 Bergman, Paul; Berman-Barrett, Sara J. (2007). *The Criminal Law Handbook: Know Your Rights, Survive the System*. NOLO. pp. 38, 62.

24 Open field doctrine -U.S.

25 California v. Greenwood, 486 U.S. 35 (1988).

26 Rios v. United States, 364 U.S. 253 (1960).

27 Bergman, Paul; Berman-Barrett, Sara J. (2007). *The Criminal Law Handbook: Know Your Rights, Survive the System*. NOLO. pp. 38, 62.

IV. НОМ ЗҮЙ

1. Монгол эх сурвалж:

1. М.Хатанзориг, “Хувийн мэдээллийн ашиглалт, хамгаалалт үндэсний аюулгүй байдлын уламжлалт бус сорилт болох нь: Эрх зүйн шинэчлэлээр шийдвэрлэх арга зам”, эрдэм шинжилгээний өгүүлэл, УБ, 2021 он.

2. Гадаад эх сурвалж:

1. Samuel D. Warren, Louis Brandeis. Right to privacy. Harvard Law Review 193 (1890).
2. LaFave, Wayne R. (2012). Search and Seizure: A Treatise on the Fourth Amendment (5th ed.).
3. Jason C. Miller. (2012) Do Not Disturb: Fourth Amendment Expectations of Privacy in Hotel Rooms. Seton Hall Circuit Review: Vol. 7.
4. Orin S. Kerr (2007), “Four Models of Fourth Amendment Protection”, Stanford Law Review, 60.
5. Bergman, Paul; Berman-Barrett, Sara J. (2007). The Criminal Law Handbook: Know Your Rights, Survive the System. NOLO.

3. Бусад: (Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүхийн зарим шийдвэр)

1. Katz v. United States, 389 U.S. 347.
2. Lewis v. United States, 385 U.S. 206.
3. United States v. Lee, 274 U.S. 559.
4. Rios v. United States, 364 U.S. 253.
5. Silverthorne Lumber Co. v. United States, 251 U. S. 385.
6. Jones v. United States, 362 U. S. 257.
7. Rios v United States, 364 U. S. 253.
8. California v. Greenwood, 486 U.S. 35.
9. Olmstead v. United States, 277 U. S. 438.
10. Goldman v. United States, 316 U. S. 129.
11. Silverman v. United States, 365 U. S. 505.
12. Rakas v. Illinois, 439 U.S. 128.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН



БҮХ НИЙТЭД БОЛОВСРОЛ ОЛГОХ, БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ УЛС ОРНУУДЫН ХҮЛЭЭХ ХҮНИЙ ЭРХИЙН ҮҮРГИЙН ТАЛААРХ СУУРЬ ЗАРЧМУУД (АБИЖАНЫ ЗАРЧМУУД)¹

THE GUIDING PRINCIPLES ON THE HUMAN RIGHTS OBLIGATIONS OF STATES TO PROVIDE PUBLIC EDUCATION AND TO REGULATE THE PRIVATE SECTOR'S INVOLVEMENT IN EDUCATION (ABIDJAN PRINCIPLES)

Арван тулгуур зарчим

Бүх нийтэд боловсрол олгох, боловсролын салбар дахь хувийн хэвшлийн оролцоог зохицуулах тухай улсын хүлээх хүний эрхийн үүргийн талаарх суурь зарчмууд нь 97 суурь зарчмаас бүрдэнэ. Энэхүү суурь зарчмуудын зэрэгцээ тулгуур шинжтэй 10 зарчмаас Абижаны зарчмын ерөнхий тойм, үзэл санааг харах боломжтой. Тус 10 зарчмыг Абижаны зарчмын бүрэлдэхүүн хэмээн харж, суурь зарчмуудтай нэгэн бүхэл хэмээн үзвэл зохино.

Нэгдүгээр тулгуур зарчим. Улс орнууд нь өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрийн сурч боловсрох эрхийг эрх тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийн хамт хүндэтгэж, хамгаалж, хангах ёстой.

Хоёрдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрд хүрч болох хамгийн дээд түвшний чанартайгаар үнэ төлбөргүй нийтийн боловсролыг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай боломжит бүх нөөцөө дээд зэргээр зориулан олгох ёстой.

Гуравдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь эцэг, эх эсвэл хууль ёсны асран хамгаалагчийн өөрийн хүүхдэд улсын боловсролын байгууллагаас өөр боловсролын байгууллага сонгох, мөн хувь хүн, этгээдийн зүгээс хүний эрхийн олон улсын эрх зүйн хүрээнд улс орнуудын хүлээсэн үүргийн дагуу тогтоосон стандартыг мөрдөж ажиллахыг шаарддаг хувийн боловсролын байгууллага байгуулах, удирдах эрх чөлөөг хүндэтгэх ёстой.

Дөрөвдүгээр тулгуур зарчим. Улс орнууд нь боловсролын салбарт хувийн хэвшлийн этгээд оролцож байгаа тохиолдолд сурч боловсрох эрхийн биелэлтийг хангах зорилгоор үр дүнтэй зохицуулалтыг батлах, мөрдөх зэрэг бүхий л зайлшгүй арга хэмжээг авах ёстой.

¹ Дэлхийн өнцөг булан бүрээс мэргэшсэн шинжээчдийн ажлын хэсэг 2018 онд ажиллаж, тус зарчмыг 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Зааны Ясан Эрэг Улсын Абижан хотноо баталсан юм. www.AbidjanPrinciples.org #AbidjanPrinciples линкээс дэлгэрэнгүйг үзнэ үү.

Тавдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь чанартай, үнэ төлбөргүй, бүх нийтэд зориулсан боловсролыг санхүүжүүлэх, хангахаа эн тэргүүнд эрэмбэлэх ёстой. Гагцхүү хүний эрхийн хэм хэмжээ, жишигтэй нийцэж байгаа тохиолдолд аливаа заавал биелүүлэх, журамласан, үйл ажиллагааны шаардлагыг хангасан үед л хууль ёсны хувийн шинжтэй хичээл заадаг боловсролын байгууллагыг шууд болон татвараас хөнгөлөх, газар ашиглуулах, олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа зэрэг шууд бус төрөл бүрийн хэлбэрээр санхүүжүүлж болно.

Зургадугаар тулгуур зарчим. Олон улсын туслалцаа, хамтын ажиллагааг үнэ төлбөргүй, чанартай, улсын буюу бүх нийтэд зориулсан боловсролын тогтолцоогоо бэхжүүлэхэд зориулах бөгөөд хүний эрхэд халдсан хувийн боловсролын байгууллагыг шууд болон шууд бусаар дэмжихийг таслан зогсоох ёстой.

Долдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах өөрийн үүргээ, тэр дундаа боловсролын салбар дахь хувийн хэвшлийн оролцоог зохицуулах үүргээ ч хариуцлагатай биелүүлэхэд чиглэсэн зохистой механизмыг бүрдүүлэх ёстой.

Наймдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь сурч боловсрох эрхийг хэрхэн эдлүүлж, мөн хүний эрхийн зарчимд нийцүүлэн бүхий л бодлогоо боловсруулж, бодитой хэрэгжүүлж байгааг баталгаажуулах үүднээс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагыг тогтмол хянаж үнэлэх ёстой.

Есдүгээр тулгуур зарчим. Улс орнууд нь сурч боловсрох эрх зөрчигдсөн, боловсролын салбар дахь хувийн хэвшлийн этгээдийн зүгээс ямарваа нэгэн хүний эрхийн зөрчил гаргасан тохиолдолд үр дүнтэй байдлаар эрхийг сэргээж, учирсан хохирлыг барагдуулах боломжийг бүрдүүлэх ёстой.

Аравдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь шаардлагатай хууль зүйн болон төсвийн шинэчлэл эхлүүлэх, хийх зэргээр бүхий л арга хэмжээг авч, эдгээр суурь зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлэх үйл явцыг баталгаажуулах ёстой.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮХ НИЙТЭД БОЛОВСРОЛ ОЛГОХ, БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ УЛС ОРНУУДЫН ХҮЛЭЭХ ХҮНИЙ ЭРХИЙН ҮҮРГИЙН ТАЛААРХ СУУРЬ ЗАРЧМУУД

(Эхийг англи, францаар боловсруулсан болно.)

Оршил

Сурч боловсрох эрх нь хүний эрх төдийгүй хүнийг мэдэлжүүлж, боломж, нөхцөлийг улам тэлж, хувирган өөрчилдөг эрх билээ. Тус эрхийн хүрээнд боловсрол олж авах эрх, боловсрол дахь эрх, боловсролоор олж авах эрхийг хөнддөг. Боловсрол хувь хүний бие махбод, сэтгэц, оюун санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд, мөн хүний эрхийг хүндэтгэхийн хамт эцэг, эх, гэр бүл, нийгмийн бүлгүүдийн зүгээс нийгмийн болон соёлын үнэт зүйлсээ дамжуулах, дадуулахад тулгын чулуу мэт үүрэг гүйцэтгэдэг. Үүний зэрэгцээ боловсролоор дамжуулан нийтийн сайн сайхныг бүрэлдүүлж, эрүүл, нээлттэй, ил тод, хүлээцтэй, шударга, үл ялгаварласан тэгш хамруулсан нийгмийг цогцлоох, хадгалах, тус нийгэм нь эргээд хүний эрхийг эдлүүлэх таатай орчин болж хувирахад хувь нэмэр оруулдаг. Ялангуяа боловсрол нь уугуул, охид, эмэгтэйчүүд, цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл ядуу хүмүүс гэх мэт эмзэг, эрх мэдэлгүй удаан хугацаанд гадуурхагдсан, боломжоос ангид нийгмийн бүлгүүдэд амин чухал хэрэгцээтэй гэж болно.

Хүний эрхийн олон улсын эрх зүйгээр улс орнуудыг чанартай байдлаар бүх нийтэд боловсрол олгохыг шаардахын хамт хувийн хэвшлийн этгээд боловсролын боломжит хувилбар санал болгох боломжийг олгодог. Улс орнуудаас сурч боловсрох эрхийг дордуулахгүйгээр боловсролын салбарт хувийн хэвшил хэрхэн оролцох ёстойг нарийвчлан чанд зохицуулахыг шаарддаг онцлогтой. Хувийн хэвшил боловсрол олгохдоо боловсролын стандартыг хангахын зэрэгцээ боловсрол олгогч этгээд гэсэн төрийн үүргийг өөртөө наах, авах, нэг бол тэгш бус, эсвэл шударга бус явдлыг гааруулахгүй байж, эн тэргүүнд үр шим хүртэгч этгээд нь хувийн хэвшлийн боловсрол олгож байгаа этгээд байна гэдгийг цаг ямагт анхаарвал зохино. Төрийн зүгээс улсын хэмжээнд нийтийн боловсролын тогтолцоог бэхжүүлэх, тэгш бус байдлыг улам өдөөхүйц байдлаар тогтолцоог задлахын эсрэг ажиллах ёстой.

Гэсэн хэдий ч улс орнууд чанартай боловсролыг бүх нийтэд олгох, хувийн хэвшлийн этгээдийн зохицуулахад бэрхшээлтэй тулгарч, заримдаа олон улсын санхүүгийн байгууллагын шахалтын улмаас боловсролын салбар

дахь хувийн хэвшлийн оролцоо тэлэх хандлагатай байна.

Боловсролын салбарт оролцож буй хувийн хэвшлийн этгээд бүр харилцан адилгүй. Хувиараа боловсрол олгогч нь итгэл үнэмшилд суурилсан, шашны үнэт зүйлстэй, орон нутгийн жижиг сургуулиас эхлэн улам идэвхтэй оролцож буй үндэстэн дамнасан компаниуд гэх мэт томоохон тоглогчид бий. Түүнчлэн нэмэлт үйлчилгээ, шалгалт, сургалтын хөтөлбөр, боловсрол санхүүжүүлэх үйлчилгээ санал болгодог хувийн хэвшлийн этгээд ч байдаг. Зарим этгээд чанартай, нийтийн боловсрол олгоход төрийг дэмжиж, сурч боловсрох эрхийг эдлүүлэхэд эерэг нөлөөтэй ажилладаг. Бусдын тухайд гол төлөв арилжааны шинжтэй этгээдийн хувьд боловсролыг зах зээлийн бараа бүтээгдэхүүн гэж хардаг, түүгээрээ сурч боловсрох эрхийг эдлүүлэхэд саад болдог ажээ.

Дээр дурдсан бэрхшээлийг даван туулахын тулд хүний эрхийн байгууллага, шүүхээс бодит амьдралд тулгарч буй хүндрэл, саадтай орчин нөхцөлд сурч боловсрох эрхийг хэрхэн биелүүлэх талаар тодорхойлж, тайлбарлаж шийдвэр гаргасан байна. Уг суурь зарчмуудаар дамжуулан хүний эрхийн олон улсын гэрээний агуулгатай нийцүүлэн улс орнууд холбогдох этгээд нөхцөл байдлыг хэрхэн өөртөө нааштай байдлаар залах, ажиллахад туслахыг зорьсон юм. Нэг талаас хууль эрх зүйн хүрээгээ боловсруулахдаа заавал тусган харах байр суурь болохын хамт хүний эрхийн эрх зүйн дагуу сурч боловсрох эрхийг баталгаажуулахын тулд улс орнуудын хүлээж буй үүргийг дахин онцолж байна. Нөгөө талаас тэгш байдал, хүний эрхэм чанар, нийгмийн шударга ёсыг баталгаажуулдаг чанартай боловсролын тогтолцоог хөхиүлэн дэмжиж байна. Энэхүү баримт бичгийг ямар нэгэн байдлаар боловсрол дахь хувийн хэвшлийн оролцоог сайшаасан, эсвэл боловсрол дахь зүй ёсны эрх чөлөөг нухчин дарсан гэж харахгүй байх нь зүйтэй.

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

а. Хүрээ, тодорхойлолт, хэрэглээ, тайлбар:

Хүрээ

1. Энэхүү суурь зарчмууд нь боловсрол дахь хувийн хэвшлийн этгээдийн оролцоог зохицуулахдаа мөрдөх хүний эрхийн хэм хэмжээ, жишгийг агуулсан болно.

Тодорхойлолт

2. Бүх нийтэд боловсрол олгох тогтолцоо нь улсаасаа хамаарч өөр байна. Тус баримт бичгийн тухайд бүх нийтэд боловсрол олгох байгууллага гэдэгт:

UIN.MN
СҮЛЭЛГЭЭНИЙ ГАН

- а. Улсын буюу нийтийн боловсролын байгууллага гэж төрөөс хүлээн зөвшөөрсөн;
- б. Төр эсвэл хүн амын зүй ёсны төлөөллийн зүгээс нийтэд үйлчлэх зорилгоор үр дүнтэй хянаж, удирддаг;
- в. Суралцагчдын сурч боловсрох эрхийг доройтуулахуйц ямарваа нэгэн арилжааны эсвэл шулах, мөлжих ашиг сонирхол агуулсан үйлчилгээ үзүүлдэггүй байхыг ойлгоно.

3. Боловсролын байгууллага нь эдгээр нэгдсэн шинжийг агуулаагүй тохиолдолд “хувийн” гэж тус баримт бичигт тодорхойлно. Үүнд:

- а. Боловсролын үйлчилгээ шууд үзүүлж байгаа хичээл заадаг боловсролын байгууллага, боловсролын үйлчилгээ үзүүлэхдээ хичээл заахгүйгээр боловсролын үүрэг гүйцэтгэдэг хувийн байгууллага;
- б. Арилжааны болон арилжааны бус этгээд.

Хэрэглээ, тайлбар

4. Энэхүү суурь зарчмуудыг улс орнуудын өөрийн нутаг дэвсгэрт төдийгүй нутаг дэвсгэрийн гадна иргэний, соёлын, эдийн засгийн, улс төрийн, нийгмийн зэрэг хүний бүх эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэгтэй уялдуулан хэрэглэж, тайлбарлана.

5. Сурч боловсрох эрхийг хүндэтгэх төрийн үүргийг биелүүлэх нь хүний бусад эрхийг эдлүүлэх үүрэг, мөн олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, олон улсын дүрвэгсдийн эрх зүй, олон улсын эрүүгийн эрх зүй гэх мэтчилэн олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхтэй цогц байдлаар уялдах ёстой.

6. Энэхүү суурь зарчмуудыг олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, жишгээр хүлээн зөвшөөрсөн эрхүүд эсвэл олон улсын хүний эрхийн хэм хэмжээтэй нийцсэн дотоодын хууль тогтоомж, түүгээр баталгаажуулсан эрхийг хязгаарлах, хорих, бусад байдлаар дордуулах зорилгоор тайлбарлах, эсвэл ашиглах ёсгүй.

7. Олон улсын болон Үндсэн хууль, үндэсний хууль тогтоомж, хэм хэмжээ, нэг бол хүний эрхийн олон улсын хэм хэмжээтэй уялдуулсан жишгийг дотроо агуулсан хүний эрхийн хэм хэмжээ, жишгийн дагуу улс орнууд, олон улсын байгууллага, үндэстэн дамнасан корпораци, бизнесийн бусад байгууллага зэрэг хувийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагыг хязгаарлах, хорих, бусад байдлаар дордуулах зорилгоор суурь зарчмуудын аль нэгэн заалтыг тайлбарлах ёсгүй.

б. Сурч боловсрох эрхийн мөн чанар, хүрээ:

8. Аливаа хэлбэрийн боловсрол нь олон улсын хүний эрхийн хэм

хэмжээгээр баталгаажуулсан боловсролын зорилго, зорилт руу чиглэх ёстой. Үүнд боловсрол хүний хувийн зан чанарыг бүхэлд нь бүрэн хөгжүүлэх, эрхэм чанараа ухамсарлахад чиглэж, хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх хамаарна. Мөн хувь хүн нийгэмдээ идэвхтэй оролцох, хүлээцтэй байх, хамтдаа амьдрах, биеэ дааж өөрийн болон хамтын амьдралын төлөвлөгөөгөө гаргах, хэрэгжүүлэх чадавхтай, шүүн тунгаадаг болоход боловсрол чиглүүлнэ.

9. Сурч боловсрох эрх нь төрсөн цагаас эхлэн амьдралын туршид үргэлжилнэ. Хүн бүр сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсрол, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт, насанд хүрэгчдийн боловсрол, албан болон албан бус боловсрол гэх мэт төрөл бүрийн хэлбэрээр түвшин бүрд хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, цаг үетэйгээ зохицсон насан туршийн боловсрол эзэмших эрхтэй. Үүнд хүний эрхийн олон улсын хэм хэмжээний дагуу төрийн хүлээх үүрэгт тусгайлан зааж, заавал эдлүүлэхийг шаарддаг үнэ төлбөргүй сурч боловсрох эрх ч багтана.

II. БОЛОМЖИТ БҮХ НӨӨЦӨӨ БҮРЭН ДАЙЧЛАХ ЗАМААР СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХ, ХАМГААЛАХ, ХАНГАХ ҮҮРЭГ

Нэгдүгээр тулгуур зарчим. Улс орнууд нь өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрийн сурч боловсрох эрхийг эрх тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийн хамт хүндэтгэж, хамгаалж, хангах ёстой.

А. Сурч боловсрох эрхийг эдлүүлэх үүрэг


10. Улс орнууд нь өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрийн сурч боловсрох эрхийг эрх тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийн хамт хүндэтгэж, хамгаалж, хангах ёстой.

11. Улс орнууд нь боловсролд хувийн хэвшлийн этгээд оролцсон зэрэг аливаа нөхцөлд сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах өөрийн үүргээ хадгална.

12. Онц байдал, зэвсэгт мөргөлдөөний үед ч сурч боловсрох эрхийг баталгаатай эдлүүлнэ.

13. Улс орнууд нь төр, хувийн хэвшлийн гэсэн боловсролын бүх байгууллагын зүгээс хүн бүрийг тэгш хамруулсан, наад зах нь шаардлага хангасан чанартай байхыг баталгаажуулах ёстой.

14. Аливаа хэлбэрийн бүх түвшний боловсрол нь чанартай боловсролыг



бүрэн илэрхийлэхүйц дараах харилцан холбоо бүхий, зайлшгүй байх шинжийг агуулна. Үүнд:

а. Хүрэлцээтэй байх.

- i. Хангалттай тооны үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллага, ашиглахуйц хөтөлбөртэй байх;
- ii. Шаардлагатай ур чадвар, мэргэшил бүхий, сургалтад суусан, дотооддоо өрсөлдөхүйц цалин хөлстэй багшлах болон бусад ажилтан хангалттай тоогоор байх;
- ii. Шаардлага хангасан сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх материал, арга зүй, туршлагатай байх;
- iv. Зохистой ариун цэврийн байгууламжтай байх;
- v. Аюулгүй ундны устай байх;
- vi. Аюулгүй, шаардлага хангасан, байнга засаж торддог дэд бүтэцтэй байх;
- vii. Аюулгүй, хамгаалагдсан суралцах орчинтой байх;
- viii. Боломжтой тохиолдолд номын сан, компьютерын, мэдээллийн технологитой байх;
- ix. Ажилтан бүр зохистой ажлын байр, хөдөлмөрлөх нөхцөл, нийгмийн хамгаалалтай байх.

б. Хүртээмжтэй байх. Боловсролын байгууллага, хөтөлбөр нь тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа хүн нэг бүрд ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүй хүртээмжтэй байна. Хүртээмж гэдэгт материаллаг, эдийн засгийн, мэдээллийн хүртээмж багтана.

в. Хүлээн зөвшөөрөгдсөн байх. Үүнд ялангуяа боловсролын хэлбэр, сургалтын хөтөлбөр, багшлах арга зэрэг бүрэлдэхүүн нь суралцагчид, боломжит нөхцөлд эцэг, эх, асран хамгаалагчид хүлээн зөвшөөрөхүйц байж, олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр баталгаажуулсан зорилго, зорилтыг чиглэвэл зохино. Сургалтын хөтөлбөр нь хэвшмэл ойлголтоос ангид гэх мэт хүний эрхтэй нийцсэн байна.

г. Цаг үетэйгээ зохицсон байх. Боловсрол нь тэр дундаа өөрчлөгдөж буй нийгэм, бүлгийн хэрэгцээг даган өөрчлөхүйц уян хатан байж, ялгаатай нийгэм, соёлын үндэс бүхий бүлгийн суралцагчдын хэрэгцээнд нийцүүлсэн байна.

15. Улс орнууд нь үнэ төлбөргүй, чанартай боловсролыг баталгаажуулан өөрийн боломжит нөөцийг бүрэн дайчлах замаар хуваарилах, үүнтэй зэрэгцэн боловсрол тасралтгүй сайжрах ёстой. Хамгийн боломжит нөөцийг хөгжлийн зорилгод заасан дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь зэрэг дотоодын эсвэл олон улсын боловсролыг санхүүжүүлэх санаачилгад заасан

түвшнээс бууруулж болохгүй.

16. Боломжит нөөц гэдэгт төр захиран зарцуулах эсвэл дайчлах боломжтой бүхий л нөөцийг ойлгоно. Үүнд:

- а. Худалдааны, шаталсан татвар, дотоодын бусад орлого бий болгох механизмууд зэрэг гол төлөв дотоодын эх үүсвэр; төсвийн орлогын суурийг тэлэх; төсвийн зардлыг дахин хуваарилах; хориотой санхүүгийн урсгал, авлига, татвараас зайлсхийх, татвараа нуун дарагдуулах явдлыг устгах; татварын болон гадаад валютын нөөц ашиглах; зээлж авч эсвэл авсан зээлийн өрөө дахин хуваах замаар удирдах; зээл авах макро эдийн засгийн хүрээг боловсруулах, батлах;
- б. Олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа.

17. Улс орнууд нь сурч боловсрох эрхийг эдлүүлэх үүргийг хүлээхдээ дараах нөхцөлийг эн тэргүүнд анхаарна. Үүнд:

- а. Үнэ төлбөргүй, чанартай, нийтийн сургуулийн өмнөх боловсролын нөхцөл;
- б. Үнэ төлбөргүй, чанартай, нийтийн суурь, бүрэн боловсролыг хүн бүрд олгох нөхцөл;
- в. Сурч боловсрох хэрэгцээтэй хүүхэд, залуус, ялангуяа өөрийн амьдран буй нийгэмдээ болон хөдөлмөрийн зах зээлд бүрэн дүүрэн, идэвхтэй оролцох хангалттай түвшний чадвар, туршлагагүй хүмүүсийн боловсрол эзэмших боломж;
- г. Ялгаварлан гадуурхалтыг бүрэн устгах, боловсрол дахь чанарын баталгаа, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүн зэрэг үндэслэлээр хэн ч боловсрол эзэмшихгүй гадна үлдэхээс сэргийлж, боломжит хэрэглэгдэхүүнээр баталгааг хангасан байдал;
- д. Заавал эзэмших боловсролын хугацаа багадаа есөн жил байх шаардлага;
- е. Боловсрол дахь хувийн хэвшлийн этгээдийн оролцооны талаарх үр дүнтэй зохицуулалтыг батлах, мөрдөх ажиллагаа;
- ё. Бүх түвшинд үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсрол олгох асуудлыг багтаасан боловсролын талаарх үндэсний стратегиа нарийвчлан батлах, хэрэгжүүлэх ажиллагаа.

18. Улс орнууд наад зах нь гэрээний дагуу хүлээсэн гол үүргээ биелүүлэх ёстой. Тухайн улсын зүгээс боломжит нөөцгүйн улмаас сурч боловсрох эрхийг эдлүүлэх гол үүргээ биелүүлж чадаагүйг нягтлан үздэг байхын тулд нийтэд илээр зарцуулж болох бүх нөөцөө өөрийн гол үүргээ биелүүлэхдээ зарцуулахаар бүх талаар хичээж зүтгэх ёстой.

19. Улс орнууд нь нийтийн алба хэмээн боловсролыг баталгаажуулах

ёстой ба хичээл заадаг хувийн боловсролын байгууллагад ч гэсэн нийтийн албаны үүргийг ногдуулна.

20. Улс орнууд нь боловсролын үйлчилгээ, удирдлагадаа хүний эрхэм чанар, оролцоо, тэгш байдал, үл ялгаварлал, тэгш хамрах явдал, ил тод байдал, эгэх хариуцлагын зарчмыг мөрдөх ёстой.

21. Улс орнууд нь бүх түвшинд, бүх насныханд сурч боловсрох эрхийг эдлүүлэхийн тулд боловсролын талаарх үндэсний нарийвчилсан стратегиа боловсруулах, батлах ёстой. Үүнийг шууд биелүүлэх үүрэг хүлээнэ. Боловсролын талаарх үндэсний стратеги нь:

- а. Хамгийн багадаа шалгуур үзүүлэлт, хүрэх зорилт, хэмжүүртэй байх; хүрэхийн тулд санал болгож буй арга зам, зорилтдоо хүрэх цаг хугацааг нарийвчлах; хэрэгжүүлэх гол этгээдийг тодорхойлох; зардлыг тусгаж, төсөвлөсөн байна. Зорилт, хэмжүүр нь өөрийн боломжит нөөцийг бүрэн зарцуулах төрийн үүрэг; гол үүрэг; хүний эрхийн талаарх бусад үүрэгтэй уялдсан байхын хамт олон улсын амлалттай ядаж л нийцсэн байх ёстой;
- б. Ил тод, оролцоог хангасан байдлаар хүүхэд, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, нийгмийн бүлэг, багшлах болон багшилдаггүй ажилтан, боловсролын үйлдвэрчний эвлэл, иргэний нийгмийн бусад байгууллага зэрэг бүх сонирхогч талын бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоонд тулгуурлан боловсруулна;
- в. Нийгэм дэх эмзэг, удаан хугацаанд эрх мэдэлгүй ялгаварлан гадуурхагдсан, боломжоос ангид бүлгийн сурч боловсрох эрхээ эдэлж буй түвшинд үнэлэх, чиглэхэд тусгайлан анхаарал хандуулна;
- г. Жендэрийн мэдрэмжтэй, охид эмэгтэйчүүдийн хэрэгцээнд хариу хандсан, хүн бүрийг хувирган өөрчлөх шинжтэй байна;
- д. Энгийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг тэгш хамруулах зэрэг гадуурхах, тусгаарлахыг эцэслэх, хүн бүрд тэгш хамруулах боловсрол олгох явдлыг баталгаажуулах зорилгоор ямарваа тогтолцооны шинэчлэлийн үйл явцын нэг хэсэг гэж ямар арга хэмжээг харахаа цаг хугацаа, хэмжүүр, шалгуур үзүүлэлтийн хамт нарийвчилна.

Олон улсын байгууллага

22. Олон улсын байгууллагын гишүүний хувиар улс орнууд өөрийн хүний эрхийн талаар хүлээдэг үүрэгтэй холбогдуулан хийж буй үйл ажиллагаагаа хариуцна. Төр олон улсын санхүүгийн байгууллага, дэлхийн сан зэрэг олон улсын байгууллагад ордог эсвэл өөрийн чадамжаа шилжүүлдэг бол тухайн улсын олон улсын хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгтэй нийцүүлж холбогдох байгууллагууд ажиллахыг баталгаажуулахад чиглэсэн бүхий л шаардлагатай арга хэмжээг авах ёстой. Тодруулбал:

- а. Олон улсын байгууллага нь энэхүү зарчимд нийцүүлэн сурч боловсрох эрхийг эдлүүлэлгүй үгүйсгэх эсвэл саад учруулахгүй байгааг баталгаажуулахын тулд түүний бодлого, эс үйлдэхүй, бусад үйлдэл зэргийг цаг ямагт хянан шинжлэх;
- б. Энэхүү зарчимд тусгасан төдийгүй хүний эрхийн бусад хариуцлагаа биелүүлэх хүлээн авагч улсын чадамжийг үгүйсгэх, эсвэл саад учруулахуиц бодлого тулгах, нэг бол санал өгөхийг зогсоох, шаардлагатай тохиолдолд үүнээс зайлсхийхийн тулд шаардлагатай бүх арга хэмжээг авах;
- в. Тухайн байгууллага дотор үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролын тогтолцоо хөгжүүлэх үүрэг хариуцлага зэрэг энэхүү зарчимд тусгасан хариуцлагыг оролцуулан сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах улс орнуудын хариуцлагатай уялдсан бодлогыг хөхиүлэн дэмжих.

Б. Боловсрол дахь тэгш байдал, үл ялгаварлал


Тэгш байх эрх

23. Улс орнууд сурч боловсрох эрхийг эдлүүлэхдээ тэгш байх эрхийг дараах хэмжигдэхүүнд баталгаатай эдлүүлэх ёстой. Үүнд:

- а. Нийгэм-эдийн засгийн сул талд чиглэсэн шударгаар нөхөн сэргээх хэмжигдэхүүн;
- б. Стигма, хэвшмэл ойлголт, ухвар мөчид төсөөлөл, хүчирхийлэлтэй тэмцэх, хүний эрхэм чанар болон ялгаварлан гадуурхалтын харилцан адилгүй шалтгаанд хамаарах дамнасан нөлөөт байдлыг хүлээн зөвшөөрөх хэмжигдэхүүн;
- г. Ялгааг хүний эрхэм чанарын асуудал хэмээн тодорхойлж, тогтолцоог өөрчлөх нөхцөл бүрдүүлдэг хувирган өөрчлөх хэмжигдэхүүн.

Ялгаварлан гадуурхахгүй байх эрх

24. Улс орнууд сурч боловсрох эрхийг эдлүүлэхдээ нас, төрсөн байдал, каст, өнгө, удам, хөгжлийн бэрхшээл, баримт бичиг, угсаа, иргэний, гэр бүлийн, карьерын байдал, жендэрийн илэрхийлэл, эрүүл мэндийн байдал, эсвэл удамшил, нэг бол бусад өвчнөөр хажиглах, хэл, шилжин суурьшсан байдал, үндэсний эсвэл нийгмийн гарал, иргэний харьяалал, улс төрийн болон бусад байр суурь, эцэг, эх болсон, жирэмсэн, өмч, арьс үндэс, шашин, бэлгийн чиг баримжаа, нийгэм-эдийн засгийн сул тал, харьяалалгүй байх, эсвэл бусад байдал зэрэг ямарваа нэгэн шинжээр ялгаварлан гадуурхахыг арилгах ёстой. Аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох үүрэг гэдэгт шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах, дарамтлах, тохирох хэрэглэгдэхүүнийг үгүйсгэх, мөн хавсарсан,



дамнасан нөлөөт, гагцхүү өөрт нь хамаарах шинжээр, нэг бол цочир ялгаварлан гадуурхах хүртэл багтана.

Улс орнуудын үүрэг

25. Улс орнууд өөрийн хууль тогтоомж, бодлого, туршлагадаа боловсролоор шууд эсвэл шууд бусаар ялгаварлан гадуурахгүй байхыг баталгаажуулах ёстой. Мөн сурч боловсрох эрхэд хамаарах тэгш байх, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийг зөрчсөн бүхий л тохиолдолд улс орнуудын үйлдлээс үүдэлтэй нөхцөл байдал эсэхээс үл хамааран анхаарч ажиллавал зохино. Үүнд доорх нөхцөл ч багтана:

- а. Ядуу эсвэл орон нутагт амьдарч байгаа хүмүүс зэрэг нийгэм дэх зарим бүлэгт харилцан адилгүй боловсрох боломж эсвэл үр дүнг тогтолцоо тэгш бусаар олгох;
- б. Ямарваа нэгэн нөхцөлөөр, тэр дундаа нийгэм-эдийн засгийн сул талд тулгуурлан ялгаварлан гадуурхаж, боловсролын тогтолцоонд тусгаарлах.

26. Улс орнууд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг арилгах, сэргийлэх, нөөц хуваарилах замаар түүхэн шинжтэй ялгаварлан гадуурхсан, тэгш бус байдал, тогтолцооны шинжтэй, урт удаан үргэлжилсэн сул талыг засах, сурч боловсрох эрхийг эдлүүлэхэд тэгш байдлыг хангахад чиглэсэн эерэг алхам хийх ёстой. Тухайн арга хэмжээ нь үндэслэлтэй, объектив, тохирсон байхын зэрэгцээ:

- а. Ялгаварлан гадуурхсан туршлагыг таних, түүнээс сэргийлэх;
- б. Боловсролын үүрэг гүйцэтгэдэг байгууллага зэрэг гуравдагч этгээдийн зүгээс хувь хүнийг ялгаварлан гадуурхахаас хамгаалах;
- в. Ямарваа нэгэн шинжид тулгуурласан ялгаварлан гадуурхалтгүйгээр чанартай, тэгш хамруулсан боловсролыг тэгш хүртэх боломжийг хүн бүрд баталгаажуулах;
- г. Ялгаварлан гадуурхахаас сэргийлэх, тэгш байдлыг баталгаажуулахаар нийтийн, хувийн байгууллагыг оролцуулан өөрийн боловсролын тогтолцоогоо зохион байгуулах.

27. Боловсрол дахь ялгаварлан гадуурхалт нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд үүнийг улс орнууд аль болох хамгийн хурднаар арилгахын тулд боловсрол болон бусад хамаарах салбарт үр дүнтэй бүх арга хэмжээг даруй авах ёстой. Тус үүргийг төрийн зүгээс шууд ялгаварлан гадуурхаж үйлдсэн эсэхээс үл хамааран гүйцэтгэнэ.

Тохирох хэрэглэгдэхүүн

28. Улс орнууд сургалтын хөтөлбөр, суралцах орчин, анги доторх харилцаа холбоо, заах аргазүйн материал, үнэлгээ зэргийг хамруулан нэг эсвэл олон шинжээр ялгаварлан гадуурхахуйц хувь хүний харилцан адилгүй чадамжид зориулан боловсрол дахь тохирох хэрэглэгдэхүүнийг баталгаажуулах ёстой. Тохирох хэрэглэгдэхүүнийг баталгаажуулж чадаагүйн улмаас ялгаварлан гадуурхалт үүсдэг бөгөөд тохирох хэрэглэгдэхүүнээр хангах үүргээ даруй биелүүлвэл зохино.

Хоёрдугаар тулгуур зарчим. Улс орнууд нь өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрд хүрч болох хамгийн дээд түвшний чанартайгаар үнэ төлбөргүй нийтийн боловсролыг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай боломжит бүх нөөцөө дээд зэргээр зориулан олгох ёстой.

В. Үнэ төлбөргүй, чанартай, нийтээрээ сурч боловсрох эрх

29. Улс орнууд үнэ төлбөргүй, чанартай, нийтээрээ сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах ёстой. Мөн өөрийн харьяалалдаа байгаа хүн бүрд хүрч болох хамгийн дээд түвшний чанартайгаар үнэ төлбөргүй нийтийн боловсролыг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай боломжит бүх нөөцөө дээд зэргээр зориулан олгох ёстой. Хувийн боловсролын байгууллагыг оролцуулах нь энэ үүрэгт ямар нэгэн байдлаар нөлөөлөх буюу үгүйсгэхгүй.

30. Нийтийн боловсрол дахь стандарт нь хүрч болох хамгийн дээд түвшний чанарыг баталгаажуулах, хүний эрхийг хамгаалахуйц шинжтэй, Дөрөвдүгээр зарчимд жагсаасан хичээл заадаг хувийн боловсролын байгууллага ч ашиглах стандарт байна. Улс орнууд боломжит бүх нөөцөө бүрэн дайчлах замаар сурч боловсрох эрхийг дэвшилттэйгээр биелүүлэх өөрийн үүрэг хариуцлагад нийцүүлэн тасралтгүйгээр нийтийн боловсрол дахь стандартыг дээшлүүлнэ.

31. Улс орнууд нийтийн боловсролд тэгш хамруулдаг байх ёстой. Цөөнх, уугуул хүмүүс зэрэг нийгмийн харилцан адилгүй бүлгийн соёлын, хэлний, бусад ялгарах шинжийг аль болох өргөнөөр нийтийн боловсролд багтааж, боловсролын зорилго, олон улсын хүний эрхийн хэм хэмжээний бусад стандарттай зөрчилдөхгүй байвал зохино. Нийтийн боловсрол нь боловсролд олон ургалч байдлыг бүрдүүлэх боломжийг хангах, соёлын хувьд тохиромжтой байх, суралцагч өөрийн хувийн онцлог шинж, соёлын илэрхийллээ хөгжүүлэх, өөрийн харьяалагдаж буй хүй олон, бусад бүлэг, нийгмийн соёлын үнэт зүйлс, туршлагыг ойлгох, сурах боломжтой байх ёстой. Сургалтын хөтөлбөр дэх мэдээлэл эсвэл мэдлэг нь объектив, шүүн тунгаасан, олон ургалч шинжтэй байна.

32. Улс орнууд нь нийтийн боловсролыг эгэх хариуцлагатай, оролцоот, тэгш хамруулсан, ил тод байлгах ёстой. Ялангуяа улс орнууд хүүхэд, бусад суралцагч, эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамт олон, багшлах болон багшилдаггүй ажилтан, боловсролын эвлэл, иргэний нийгмийн бусад байгууллага зэрэг бүх оролцогч талыг оролцуулан засагладаг боловсролын тогтолцоог бий болгох ёстой.

33. Улс орнууд ямарваа нэгэн ялгаварлан гадуурхалт, эсвэл тусгаарлалтгүйгээр хүн бүрийн нийтийн боловсролтой байх адил тэгш эрхийг баталгаажуулахын тулд чанартай нийтийн боловсрол эзэмших хүртээмжийг тодорхойлогч асуудалд чиглэсэн үр дүнтэй бүх арга хэмжээг авах ёстой. Үүнд хөдөлмөрлөх, нийгмийн хамгаалалтай байх, хүнс, орон сууцаар хангагдах, эрүүл мэндээ хамгаалуулах, ус, ариун цэврийн байгууламжтай байх эрх зэрэг эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад чиглэсэн үр дүнтэй бүх арга хэмжээг авах хүртэл багтана. Эдгээр арга хэмжээ нь орон сууцны бодлого; дэд бүтэц төлөвлөлт; зохистой хоол хүнстэй байх боломж; нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэх хөтөлбөр; гэрлэх насны доод хязгаарыг 18 насанд тооцсон хууль тогтоомж; хүүхдийн хөдөлмөрөөс сэргийлсэн бодлого; хэвшмэл ойлголт, ухвар мөчид төсөөлөлд хүргэдэг нийгэм, соёлын загварыг өөрчлөх арга хэмжээ; хүний бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн хүрч болох хамгийн дээд түвшинд хүргэх арга хэмжээ зэргийг улам хүнээ тэгш хамруулсан болгох боломжтой.

Д. Нийтийн боловсролыг санхүүжүүлэх нь

34. Боловсролд боломжит бүх нөөцөө дээд зэргээр зориулахдаа улс орнууд сурч боловсрох эрхийг үр дүнтэй, мөн чадах хэрээр түргэн шуурхай биелүүлэхдээ зохистой санхүүгийн болон бусад нөөцийг хуваарилах замаар чанарын дээд түвшинд үнэ төлбөргүй, нийтийн боловсрол олгохоо чухалчлах ёстой. Улс орнууд өөрийн боловсролын төсвөө ямар нэгэн байдлаар бусад хэсэгт дахин хуваарилах, эсвэл зарцуулахдаа үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролыг олгоход саад болохгүй байх ёстой.

35. Улс орнууд дотоодын төсвийн хууль тогтоомж, эсвэл бодлогодоо тохирох байдлаар нийтийн боловсролд хүний эрхэд нийцсэн боловсролын санхүүжилтийг оруулах ёстой. Улс орнуудын боловсролын үндэсний стратегиуд нь хүрч болох дээд түвшний чанартайгаар үнэ төлбөргүй, нийтийн боловсролыг олгох өөрийн үүргээ үйл ажиллагаандаа доорх замаар тусгах ёстой. Үүнд:

- а. Нийтийн боловсрол дахь зорилт, хэмжүүр, заасан хугацааны доторх ахиц дэвшлээ нягтлах шалгуур үзүүлэлт зэргийг оролцуулан хангалттай тусгайлсан, тодорхой байх;

- б. Эерэг үйл ажиллагаа зэргийг багтаан чанартай, нийтийн боловсролыг хүн бүрд олгоход тулгарч байгаа хаалт, саад тотгор;
- в. Нийтийн боловсролыг сайжруулахаар тодорхойлсон тэргүүлэх чиглэлээ бүрэн зардлыг тооцох, санхүүжүүлэх.

36. Хүрч болох дээд түвшний чанартайгаар үнэ төлбөргүй, нийтийн боловсролоор хангах өөрийн үүргээ ахиц дэвшилттэйгээр биелүүлэх явцдаа улс орнууд хэн ч төлбөр төлөх боломжгүйн улмаас ямар нэгэн нийтийн боловсролын байгууллагаас гадуурхагдаагүй байхыг баталгаажуулах шаардлагатай алхам хийж, суралцагч, түүний гэр бүлийн байдлын улмаас үүсэх эрсдлээс сэргийлэх үр дүнтэй бүх арга хэмжээг авна.

37. Хязгаарлагдмал нөөцтэй тохиолдолд улс орнууд чанартай, нийтийн боловсролыг үргэлжлүүлэн олгохдоо эн тэргүүнд анхаарах ёстой.

Олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа

38. Боловсролын төлөөх олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа нь хүлээн авагч улсын зүгээс өөрийн хүлээсэн үндсэн үүргээ биелүүлэхийг дэмжихийг чухалчлах ёстой. Ялангуяа үүгээр хүн бүрийн тэр дундаа эмзэг, боломжгүй, гадуурхагдсан бүлгээ онцолж, үнэ төлбөргүй, чанартай, нийтийн сургуулийн өмнөх, бага, дунд боловсролыг чухалчлах, бусад түвшний нийтийн боловсролын байгууллагуудын талаас үнэ төлбөргүй, чанартай боловсролыг үр дүнтэй, чадах хэрээр түргэн шуурхай олгох ёстой.

Нийтийн байгууллагад хувийн нөөцийг олгох нөхцөл

39. Нийтийн боловсролын байгууллага нь сурч боловсрох эрхийг хамруулан хүний эрхийг биелүүлэхэд доорх байдлаар сөргөөр нөлөөлөхгүй нөхцөлд өгсөн нийтийн боловсролыг дэмжих тэтгэлэг зэрэг хувийн нөөцийг хүлээж авч болно. Үүнд:

- а. Байгууллагын засаглал эсвэл боловсролын тогтолцоонд нөлөөлөх;
- б. Сургалтын хөтөлбөр эсвэл заах арга зүйн материалын агуулга, арга зүй, туршлагад нөлөөлөх;
- в. Ялгаварлан гадуурхалтгүйгээр хичээл заадаг боловсролын байгууллагад бүртгүүлэх эрхэд хөндлөнгөөс нөлөөлөх;
- г. Хичээл заадаг боловсролын байгууллагын байранд зар сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагаа, материалтай байх, эсвэл хүүхдэд чиглэсэн байдлаар үйл ажиллагаа, материалыг түгээх зэргээр нийтийн боловсролыг арилжааны шинжтэй болгохоор чиглэх;
- д. Санхүүжүүлэгч, ивээн тэтгэгч төрийн албан тушаалтнаас ямар нэгэн санхүүгийн эсвэл өөр үр ашиг хүртэх, эсвэл ашиг сонирхлын зөрчил үүсгэх.

40. Нийтийн боловсролын байгууллагад зориулсан хамт олны сайн дурын хувь нэмрийг ч дээрх нөхцөл байдалд нийцүүлнэ.

41. Нийтийн боловсролыг дэмжих хувийн санхүүжилт эсвэл тэтгэлэг нь:

- а. Ил тодоор зарцуулах ба бүх зардлыг нийтэд дэлгэх;
- б. Боловсролын тогтолцоог бүхэлд нь бэхжүүлэх ба боловсролын байгууллагуудын хооронд тэгш бус байдлыг үүсгэх ямар нэгэн зүйлгүй байна.

Е. Засаглал

42. Улс орнууд үнэт төлбөргүй, чанартай, нийтийн боловсролтой байх эрхийг биелүүлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй үр нөлөөгүй засаглал, ил тод бус байдал, эгэх хариуцлагагүй байдал, эсвэл авлигад анхаарч, бүх арга хэмжээг даруй авах үүрэг хүлээдэг.

Ё. Үл ухрах

43. Улс боломжит нөөц дутсан учир үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролыг хүн бүрд олгож чадаагүй нөхцөл байдлаа харахын тулд:

- а. Эн тэргүүнд дээрх үүргээ биелүүлэхдээ өөрийн удирдлага дахь бүх нөөцийг хэрэглэсэн бүх оролдлогоо нийтэд ил харуулах;
- б. Байгаа болон байх боломжит бүх нөөцөө тодруулан, чадавхын зөрүүгээ тасралтгүй нийтэд ил дахин үнэлэх;
- в. Хамгийн боломжит богино хугацаанд чадавхын зөрүүд хэрхэн анхаарах, өөрийн үүрэгтэй уялдуулан үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролыг олгох зэргийг үндэсний боловсролын стратегидаа тусгай зорилтын хамт нарийвчилсан он цагийн дарааллыг оруулах ёстой.

44. Хүсэл тэмүүлэлгүй байх нь чадавхгүй байхаас ялгаатай бөгөөд тухайн улсын үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролыг олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүйг зөвтгөх үндэслэл болохгүй.

45. Нийтийн боловсрол эзэмших эрхээ эдлэхтэй холбоотой ухарсан арга хэмжээ авах нь ямар ч тохиолдолд хүлээн зөвшөөрөх ёсгүй гэсэн хүчтэй төсөөлөл бий. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд ухарсан арга хэмжээ авсан байвал улс олон хүний эрхийн хэм хэмжээ, жишигт нийцүүлэн ямарваа нэгэн арга хэмжээг авсан гэдгээ нотолвол зохино. Арга хэмжээнд:

- а. Мөн чанар, үйлчлэлийн хувьд түр зуурын, санхүүгийн хязгаарлагдмал нөхцөл байдал үүсгэсэн хямрал арилах хүртэл хугацааг хязгаарлана;
- б. Ямарваа нэгэн бодлогын хувилбар батлах, арга хэмжээ авч чадахгүй бол эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэхэд улам сөргөөр нөлөөлөх учир бусад боломжит хувилбар нэг бүрийг

цогцоор хянан нягтлах боломж олгосон, нөхцөл байдалд заавал шаардлагатай, тохирсон байна;

- в. Үндэслэлтэй байна;
- г. Шууд болон шууд бусаар үл ялгаварлана;
- д. Үнэ төлбөргүй, чанартай, нийтийн боловсролтой байх эрх зэрэг эмзэг, боломжгүй, гадуурхагдсан хувь хүн, бүлгийн эрхийг тусгайлан анхаарч, ялгавартай нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж ажиллана;
- е. Нийтийн боловсрол эзэмших эрхийн наад захын цөм агуулга, нөлөөнд өртсөн эдийн засаг, нийгэм, соёлын бусад эрхийг тодорхойлж, цаг ямагт цөм агуулгыг хамгаалж ажиллана;
- ё. Санал болгосон арга хэмжээ, хувилбараа нягтлан үзэхдээ хүүхэд, бусад суралцагч зэрэг нөлөөнд өртсөн бүлгийн бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоог хангана;
- ж. Үндэсний түвшинд утга учиртай байдлаар дүрэм журмаа хянан үзэх этгээд байвал зохино.

46. Олон улсын хэмжээнд тусалж, хамтран ажиллаж байгаа улс орнууд нийтийн боловсрол эзэмших эрхтэй холбоотой зөвшөөршгүй ухарсан арга хэмжээ авах, дэмжих, шаардах ёсгүй.

III. ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД СУРЧ, БОЛОВСРОХ ЭРХИЙГ ХҮНДЛЭХ, ХАМГААЛАХ, БҮРДҮҮЛЭХ ҮҮРЭГ

Нийтлэг зарчим 3. Төр нь эцэг, эх, эсвэл хууль ёсны асран хамгаалагчид хүүхдүүддээ төрийн өмчийн боловсролын байгууллагаас бусад боловсролын байгууллагыг сонгох эрх чөлөөг мөн байгууллагуудын хувийн боловсролын байгууллагыг байгуулах, удирдах эрх чөлөөг хүндэтгэх ёстой. Эдгээр боловсролын байгууллагууд нь олон улсын хүний эрхийн хуулиар хүлээсэн үүргийн дагуу төрөөс тогтоосон стандартад нийцсэн байна.

47. Төр нь эцэг, эх, эсвэл хууль ёсны асран хамгаалагчид хүүхэддээ төрийн өмчийн боловсролын байгууллагаас бусад боловсролын байгууллагыг сонгох эрх чөлөөг мөн байгууллагуудын хувийн боловсролын байгууллагыг байгуулах, удирдах эрх чөлөөг хүндэтгэх ёстой. Энэ явцад боловсролын байгууллагууд нь олон улсын хүний эрхийн хуулиар хүлээсэн үүргийн дагуу төрөөс тогтоосон стандартад нийцсэн байна.

48. Эдгээр эрх чөлөөг зөвхөн хуулийн дагуу хязгаарлах бөгөөд зөвхөн ардчилсан нийгэм дэх ерөнхий сайн сайхан байдлыг дэмжих, бусад аливаа хүний эрхийг хэрэгжүүлэх зорилгоор хязгаарлана. Эдгээр хязгаарлалт нь дараах зүйлийг хангаж байвал зөвтгөгдөнө:

- а. хувийн өмчит боловсролын байгууллагууд төрийн өмчит боловсролыг шахан гаргах эсвэл орлохгүй, харин соёлын олон ургальч байдлыг харгалзан хүн бүрийг сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нэмэлт/нөхөх хэлбэр;
- б. хүүхдийн бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хүндэтгэж мөн эцэг, эх сонголтыг хийхдээ хүүхдийн нас, төлөвшил, тэдний ашиг сонирхолд нийцүүлэхээс гадна хүүхдийн бодолд нь зохих жинг өгнө;
- в. эдгээр эрх чөлөөг хэрэгжүүлэх нь сурч боловсрох эрхэд системчилсэн сөрөг үр дагавар үүсгэхгүй. Үүнд:
 - i. тусгаарлан сургах боловсролын тогтолцоо гэх мэт нийгмийн зарим бүлгүүдийн боловсролын боломж, үр дүнгийн зөрүү рүү хөтлөх буюу хадгалах, үүнээс үүдэн нийгмийн тэгш байдал, ялгаварлан гадуурхагдахгүй байх зарчмыг үгүйсгэдэг эсвэл хөнддөг;
 - ii. төрийн үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсрол эзэмших эрхийг хэрэгжүүлэх чадавхид сөргөөр нөлөөлөх буюу урьдчилан харах боломжтой сөрөг нөлөөний эрсдлийг бий болгох;
 - iii. боловсролыг арилжаалах замаар олон улсын хүний эрхийн хуулиар баталгаажуулсан боловсролын аливаа зорилгыг сулруулах;
 - iv. ил тод байдал, хууль дээдлэх, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх, боловсролын салбарт бүрэн, үр дүнтэй оролцоход сөргөөр нөлөөлөх;
 - v. бусад аливаа хүний эрх, ялангуяа боловсролын байгууллагад ажиллагсдын эрх ашгийг хүчингүй болгох, эсхүл ашиглах эрхийг нь доройтуулах.

49. Хувийн секторын оролцогчид сурч, боловсрох эрх, боловсролын бусад хүний эрхийг хүндэтгэх үүрэгтэй. Үүнд:

- а. сурч, боловсрох эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг өөрсдийн үйл ажиллагаагаар үүсгэхээс мөн хувь нэмэр оруулахаас зайлсхийх, ийм нөлөөлөл гарсан тохиолдолд шийдвэрлэх, засах;
- б. боловсролын үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх сөрөг нөлөөллийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээтэйгээ шууд холбоотой бол тэдгээр нөлөөлөлд шууд нөлөөлөөгүй байсан ч урьдчилан сэргийлэх, бууруулахыг эрмэлзэх.

50. Боловсролыг хувийн хэвшлээр хангах нь үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын хүртээмжгүй байдлын үр дагавар юм бол төр үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын бүх нийтийн хүртээмжийг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай боловсруулж хөгжүүлэхийн тулд

бүх үр дүнтэй арга хэмжээг авах ёстой. Ингэхдээ тэд хувийн сургалтын байгууллагуудаас төрөөс тогтоосон хамгийн бага стандартыг хангаж байхыг шаардаж, мөрдүүлэх, эсхүл зохих журмын дагуу эдгээр стандартаас доогуур байгаа хувийн сургалтын байгууллагуудыг хаах ёстой.

Нийтлэг зарчим 4. Төр боловсрол эзэмшихэд хувийн сектор оролцож байгаа газарт сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг хангахын тулд үр дүнтэй зохицуулалтын арга хэмжээ зэрэг бүх боломжит арга хэмжээг авах ёстой.

51. Төр боловсрол эзэмшихэд хувийн сектор оролцож байгаа газарт сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг хангахын тулд үр дүнтэй зохицуулалтын арга хэмжээ зэрэг бүх боломжит арга хэмжээг авах ёстой. Үүнд хувийн оролцогчид ямар нэгэн төрийн оролцоо, хяналтгүйгээр үйл ажиллагаагаа явуулдаг, албан бус болон хууль бусаар үйл ажиллагаа явуулдаг нөхцөл байдал орно.

52. Төр сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулсныг баталгаажуулахын тулд боловсрол эзэмшүүлж буй хувийн оролцогчдод төрийн үйлчилгээний үүрэг хүлээлгэх ёстой. Үүнд:

- a. байгууллагын түвшинд бүх хувийн сургалтын байгууллагуудад олгогддог боловсрол нь хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, сурч боловсрох эрхтэй холбоотой стандартуудтай нийцэж байх; болон
- b. системийн түвшинд хувийн боловсролын байгууллагууд сурч боловсрох эрхээ эдлэхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх.

53. Улс орон хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, стандартад нийцсэн хувийн боловсролын байгууллагуудын үр дүнтэй зохицуулалтыг бий болгох ёстой. Ийм зохицуулалт нь доорх Удирдах зарчим 54-57-д заасны дагуу тогтоосон хамгийн бага/минимум стандартыг дагаж мөрдөхийг баталгаажуулах бөгөөд үүн дотроос дараах зүйлийг баталгаажуулах ёстой. Үүнд:

- a. ямар ч хувийн боловсролын байгууллага, хувийн хэвшлийн боловсролын байгууллагуудын зохион байгуулалттай бүлэг нь боловсролын системд зүй бусаар нөлөөлөх, тэр дундаа шаардлагатай тохиолдолд хувийн сургалтын байгууллагуудын тоог хязгаарлах эсвэл хувийн сургалтын байгууллагыг сонгох, байгуулах эрх чөлөөнд нөлөөлөх хэмжээнд хувь эзлэхгүй байх;
- b. Боловсролд оролцож буй хувийн оролцогчдод нөлөөлөх байр суурьтай төрийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил байхгүй байх;
- v. хувийн боловсролын байгууллагуудын маркетинг, сурталчилгаа эсвэл бусад практик үйл ажиллагаа нь төөрөгдөл үүсгэхгүй байх.

Хувийн сургалтын боловсролын байгууллагуудад хамааралтай хамгийн бага/минимум стандарт

54. Сурч боловсрох эрхийг хамгаалах зохицуулалтын ажлын хүрээнд Төр хувийн сургалтын байгууллагуудад хамааралтай хамгийн бага стандартыг тодорхойлж, мөрдүүлэх ёстой. Эдгээр стандартыг хүүхдүүд, бусад суралцагчид, эцэг, эхчүүд эсвэл хууль ёсны асран хамгаалагчид, олон нийт, багшлах болон багш биш ажилтнууд, боловсролын үйлдвэрчний эвлэлүүд, иргэний нийгмийн бусад байгууллагууд, хувийн сургалтын байгууллагууд зэрэг бүх оролцогч талуудыг хамарсан тэдний оролцоотойгоор боловсруулж батлах ёстой. Эдгээр стандартыг сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэгтэй харшлах зорилгоор ашиглаж болохгүй.

55. Хамгийн бага стандарт нь дараах хэмжээсийг хангасан байх ёстой. Үүнд:

- а. хувийн сургалтын байгууллагын засаглал. Үүнд:
 - i. бүртгэл, лиценз олгох үйл явц, тэдгээрийг буцаан татах нөхцөл;
 - ii. санхүүгийн болон үйл ажиллагааны эсвэл чанарын мэдээлэл зэрэг улсад тайлагнах шаардлага;
 - iii. хүүхдүүд болон бусад суралцагчид, эцэг, эх эсвэл хууль ёсны асран хамгаалагч, хүй олон, багшлах болон багш биш ажилтнууд, боловсролын үйлдвэрчний эвлэл, бусад иргэний нийгмийн байгууллагуудын бүрэн, үр дүнтэй оролцоо;
 - iv. боловсролын нөөцийн менежмент;
 - v. шаардлагатай тохиолдолд төлбөрийн хэмжээ болон бусад шууд ба шууд бус зардал, ялангуяа хэт их өртэй болох эрсдэлд анхаарлаа хандуулах, мөн төрөөс боловсролын хүртээмжтэй байдлыг хангах талаар төрөөс хүлээх үүрэг;
 - vi. дотоодын болон шаардлагатай тохиолдолд олон улсын захиргаа, санхүүгийн бүтцийг багтаасан хувийн сургалтын боловсролын байгууллагуудын тухай ил тод байдал, мэдээлэл авах; суралцагчдад учирч болзошгүй бүх сургалтын хөтөлбөр ба бусад төлбөр; боловсролын нөөцийн ашиглалт; хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүй, дадлага; элсэлтийн нөхцөл; байгууллагын эрх зүйн байдал, гарал үүсэл; болон байгууллагуудын бусад бодлого; болон
 - vii. суралцагчдын гэрчилгээжүүлэх нөхцөл, ил тод байдал.
- б. эрдэм шинжилгээний болон сурган хүмүүжүүлэх эрх чөлөөг хүндэтгэх;
- в. суралцагчдын эвлэлдэн нэгдэх, үг хэлэх эрх чөлөөг хамгаалах;

- г. сурч боловсрох эрхийг эдлэхдээ ялгаварлан гадуурхах бүх хэлбэрээс суралцагчдыг хамгаалах, элсэлт, суралцах нөхцөл шууд болон дам байдлаар ялгаварлан гадуурхахгүй байхыг баталгаажуулах замаар бүх суралцагчдын тэгш байдал, хүртээмжтэй боловсролыг баталгаажуулах; мөн тэдний эмзэг, гадуурхагдсан, эмзэг бүлгийн хүмүүсийн тэгш байдал, ялгаварлан гадуурхах эрхэд үзүүлэх нөлөөнд онцгой анхаарал хандуулах. Ийм хамгаалалт нь жирэмсэн охид, залуу эхчүүд, гэрлэсэн 18-аас доош насны охидод сургуульдаа үлдэх эсвэл саадгүй буцаж сургуульд хамруулах, шинээр элсэхийг баталгаажуулах ёстой;
- д. ажилтнуудын мэргэжлийн минимум ур чадвар; сургалт; хөдөлмөрийн эрх, үүнд хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн гэрээний нөхцөл, цалин хөлс, эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр хийх эрх чөлөө; боловсролын сургалтын байгууллагын удирдагч, багш, бусад ажилтны статус нь дор хаяж хүний эрхийн холбогдох хууль, стандартад нийцсэн байх ёстой; хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, стандарт, ялангуяа бодол, ухамсар, шашины эрх, цөөнх, уугуул иргэдийн эрх, соёлын эрх, эрдэм шинжилгээний болон сурган хүмүүжүүлэх эрх чөлөөг зохих ёсоор харгалзан сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүй, дадалд тусган харгалзан үзсэн байх.
- Боловсролын хэлбэр, мөн чанар нь хүлээн зөвшөөрөгдөхүйц, дасан зохицох чадвартай, Удирдах зарчим 8-д заасан боловсролын зорилгод нийцсэн байх ёстой. Төр ялангуяа хүүхдэд сургалтын хөтөлбөрийн хүрээнд сурах, оролцох үүнд ерөнхий соёл, бие бялдар, урлагийн үйл ажиллагааны зэрэгцээ хүүхдийн амрах, чөлөөт цагаа өнгөрөөх, тоглох, идэвхтэй амралтад холбогдолтой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүндэтгэж тэднийг бий болгох зохих цаг хугацаа, мэргэжлийн ур чадварыг хуваарилсан байх ёстой;
- е. суралцагчдыг түдгэлзүүлэх, хөөх явцад хатуу хязгаарлалт тогтоох, зохих журмыг хангасан эсэхийг баталгаажуулж, ийм түдгэлзүүлэх, хөөх явц нь тайлбарлаж болохуйц пропорциональ байх;
- ё. сахилга бат ба бие махбодийн шийтгэлийг хориглох;
- ж. төлбөрийг төлөөгүй эсвэл саатсантай холбогдуулан суралцагчдын эрхийг хамгаалах;
- з. сурах орон зайн хэмжээ, засвар үйлчилгээ, ариун цэврийн болон гал тогооны өрөөний тоноглол, тавилга, тоног төхөөрөмж, гамшиг эрсдэлийн удирдлага мөн түүнчлэн сурах бичиг, сургалтын болон сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг хүчин зүйлийг харгалзан охид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зэрэг бүх суралцагчдад тохирсон аюулгүй сургалтын орчин, дэд бүтцийн стандарт;

- и. хүртээмжтэй холбоотой наад захын шаардлага, үүнд боломжийн байрны баталгааны үүргийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нэвтрэх, байгууллагууд аливаа суралцагчаас шууд болон шууд бусаар нэмэлт төлбөр авахгүй байхыг баталгаажуулах;
- й. суралцагчдын бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдал, түүний дотор нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх стандартыг хангах; эрүүл мэнд, эрүүл ахуй; суралцагчдыг хүчирхийлэл, бэлгийн дарамтаас хамгаалах;
- к. суралцагчид болон тэдний гэр бүлийнхнийг заналхийлэх, ичээх, дээрэлхэхээс хамгаалах, ялангуяа тухайн байгууллагын хүлээгдэж буй академик/эрдэм шинжилгээний стандартад нийцэхгүй байж болох болон тухайн байгууллагад асуудал үүсгэж болзошгүй хүмүүсийг хамгаалах;
- л. суралцагчид, ялангуяа хүүхдийг элссэн байгууллагынх нь хэт их сурталчилгаанаас хамгаалах;
- м. нууцлал ба мэдээллийн хамгаалалт, ялангуяа хувийн мэдээллийн талаар хууль, ёс зүйн хэм хэмжээг хүндэтгэх дээдлэх. Төр, хувийн, түүний дотор биометрийн өгөгдлийг зөвшөөрөлгүйгээр цуглуулах, хадгалах, эсвэл шууд зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдтэй хуваалцах, боловсролоос бусад зорилгоор, үүнд арилжаа, цагаачлал, аюулгүй байдлын зорилгоор ашиглахгүй байхыг баталгаажуулах ёстой;
- н. чанартай боловсролыг хангах үүднээс багш/суралцагчийн хүлээн зөвшөөрөгдөх хамгийн дээд харьцаа;
- о. хүний эрхийг хамгаалахад шаардлагатай бусад стандарт.

56. Төр боловсрол эзэмших эрхийг дэвшилтэйгээр хэрэгжүүлэх үүргийнхээ дагуу хувийн сургалтын байгууллагуудад тавигдах хамгийн бага/минимум стандартад заасан шаардлагыг үе шаттайгаар дээшлүүлэх ёстой.

57. Хамгийн бага/минимум стандарт нь төр эргэлт буцалтгүй зарчмуудтай байхтай холбоотой үүрэг хүлээнэ.

Сургалтын бус болон боловсролын бус хувийн тоглогчид

58. Төр суралцах байрны үйлчилгээ эрхлэгчид, боловсролын зээл олгож буй санхүүгийн байгууллагууд, нийтийн байгууллагуудад орон зай олгох газар өмчлөгчид гэх мэт сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд нөлөөлж болох сургалтын бус болон боловсролын бус хувийн оролцогчдыг зохицуулах ёстой. Тэдний үйл ажиллагаа нь сурч боловсрох эрхийг хүчингүй болгох, доройтуулахад хүргэхгүй байхыг баталгаажуулах.

59. Төрийн болон хувийн сургалтын байгууллагуудад арилжааны сурталчилгаа, маркетинг хориглож, сургалтын хөтөлбөр, сурган

хүмүүжүүлэх арга зүй, практик үйл ажиллагаанд арилжааны ашиг сонирхол нөлөөлөхгүй байхыг баталгаажуулах ёстой.

Хэрэгжүүлэлт

60. Хувийн боловсролын байгууллагууд холбогдох стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд төр үүнийг хамгийн богино хугацаанд хэрэгжүүлэхийг шаардах ёстой. Төр зохих зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх хэрэгсэл, менежментийн тусламж үзүүлэх гэх мэт арга хэмжээ авах замаар эсхүл үл нийцэл үргэлжлэх тохиолдолд шийтгэлийг ноогдуулах замаар дагаж мөрдөхийг дэмжих ёстой. Ийм арга хэмжээ авсны дараа хувийн боловсролын байгууллагууд стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөх боломжгүй эсвэл хүсэхгүй байгаа тохиолдолд төр зохих журмын дагуу эдгээр байгууллагыг дараах журмаар хаах ёстой. Үүнд:

- а. боловсролын байгууллагуудад эдгээр стандартыг дагаж мөрдөх хангалттай мэдэгдэл, боломжийг олгосон;
- б. нөлөөлөлд өртсөн бүх суралцагчдын сурч боловсрох эрхийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжийг баталгаажуулсан байхад анхаарах.

Газар нутгийн гадна хэрэглээ

61. Төр зохицуулах боломжтой нөхцөлд боловсролд оролцдог хувийн оролцогчид үйл ажиллагаа явуулж буй газар бүртээ сурч боловсрох эрхийг хүчингүй болгохгүй эсвэл сулруулахгүй байх тал дээр бүх л үр дүнтэй арга хэмжээг авах ёстой. Энэ арга хэмжээнд захиргааны, хууль эрх зүйн, мөрдөн байцаах, шүүх, бусад аливаа арга хэмжээг багтааж болно.

62. Сурч боловсрох эрхийг хамгаалах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм болон олон улсын ерөнхий хууль тогтоомжийн дагуу боловсролд оролцож буй хувийн оролцогчдод нөлөөлөх байр суурьтай улс орнууд ийм зохицуулалтын эрхгүй ч гэсэн тухайлбал төрийн худалдан авах ажиллагааны систем эсвэл олон улсын дипломат ажиллагаагаар дамжуулан ийм нөлөөг хэрэгжүүлэх ёстой.

63. Сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай тохиолдолд олон улсын туслалцаа, боловсролын хамтын ажиллагаа нь хүлээн авагч улс орнуудын хүний эрхийн үүргийн дагуу боловсролд оролцож буй хувийн оролцогчдын зохицуулалтыг бэхжүүлэхэд чиглэгдэх ёстой.

IV. САНХҮҮЖИЛТ

Нийтлэг зарчим 5. Төр үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын санхүүжилт, хангамжийг нэн тэргүүнд тавих ёстой бөгөөд зөвхөн шууд болон шууд бус хэлбэрээр, үүнд татварын хөнгөлөлт, газрын хөнгөлөлт, олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа, бусад хэлбэрээр эрх бүхий хувийн сургалтын байгууллагуудыг санхүүжүүлэх боломжтой. Тэдгээр нь хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, стандартыг дагаж мөрдөж, доор тодорхойлсон бүх бодит, процедурын болон үйл ажиллагааны шаардлагыг чандлан мөрдөж байх ёстой.

64. Сурч боловсрох эрх нь төрөөс хувийн сургалтын байгууллагыг санхүүжүүлэх үүрэг хүлээлгэхгүй. Төр үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын санхүүжилт, хангамжийг нэн тэргүүнд тавих ёстой бөгөөд зөвхөн шууд болон шууд бус хэлбэрээр, үүнд татварын хөнгөлөлт, газрын хөнгөлөлт, олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа, бусад хэлбэрээр эрх бүхий хувийн сургалтын байгууллагуудыг санхүүжүүлэх боломжтой. Тэдгээр нь хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, стандартыг дагаж мөрдөж, доор тодорхойлсон бүх бодит, процедурын болон үйл ажиллагааны шаардлагыг чандлан мөрдөж байх ёстой.

Бодит шаардлага

65. Эрх бүхий хувийн сургалтын байгууллагад төрөөс олгож болзошгүй аливаа санхүүжилт дараах бүх шаардлагыг хангасан байна. Үүнд:

- a. энэ нь цаг хугацааны хязгаарлалттай арга хэмжээ бөгөөд тухайн улс тухайн нөхцөл байдалд сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг урагшлуулах цорын ганц үр дүнтэй хувилбар болохыг олон нийтэд харуулсан байх:
 - i. төр нь үнэ төлбөргүй, чанартай сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх өөр ямар нэгэн сонголт байхгүйг олон нийтэд харуулсан тохиолдолд боловсрол эзэмших богино хугацааны хүртээмжийг хувь хүмүүс хангах;
 - ii. соёлын олон талт байдлыг хүндэтгэхийг дэмжиж, хүртээмжтэй боловсрол эзэмших эрхийн дагуу соёлын эрхийн хэрэгжилтийг хангах;
 - iii. өмнө нь бие даан үйл ажиллагаа явуулж байсан хувийн сургалтын байгууллагуудын нийтийн боловсролын тогтолцоонд шилжих интеграцийг дэмжих;
 - iv. төр нь олон нийтийн боловсролын байгууллагуудад хурдан хугацаанд хэрэгжих боломжгүй гэдгийг олон нийтэд харуулсан сурган хүмүүжүүлэх, агуулгын олон ургальч чиг хандлагын эрэлт хэрэгцээнд эсвэл туршиж үзэх шаардлагад хариу барих.

- б. Сурч боловсрох эрхээ дээд зэргээр хэрэгжүүлэх үүргээ биелүүлэх үүргийн дагуу хүртээмжтэй, чанартай олон нийтийн үнэ төлбөргүй боловсролын тогтолцоог хамгийн дээд түвшинд хамгийн үр дүнтэй бөгөөд хурдан хамгийн боломжит нөөцөөр хөгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх, хойшлуулахыг урьдчилан харах боломжтой эрсдэлийг бий болгодоггүй байх;
- в. энэ нь хүлээн зөвшөөрөх боломжгүй ухраах арга хэмжээ ялангуяа олон нийтийн боловсролын систем дэх стандартыг бууруулахтай холбоотой олон нийтийн нөөцийг сарниулаагүй байх;
- г. энэ нь боловсролын тогтолцоог арилжааны шинж чанартай болгоход хувь нэмэр оруулаагүй байх;
- д. санхүүжүүлсэн хувийн сургалтын байгууллага нь боловсролын системд зүй бусаар нөлөөлөх, эсвэл боловсролын тогтолцооны үлэмж хэсгийг эзэлж, сурч боловсрох эрхийг алдагдуулах урьдчилан таамаглан харж болохоор эрсдлийг үүсгэдэггүй байх;
- е. ялгаварлан гадуурхахгүй байх, эрх тэгш байдал, ялгаварлан тусгаарлахгүй байхтай холбоотой үүрэгт онцгой анхаарал хандуулж, боловсрол эзэмших эрхэнд бусад системчилсэн нөлөөллийн урьдчилан харж болохоор эрсдлийг бий болгоогүй байх.

Процедурын шаардлага

66.Төсвийн санхүүжилтийг эрх бүхий хувийн сургалтын байгууллагад хуваарилахад дараах журмын бүх шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- а. санхүүжилтийг авч үзэхээс өмнө ийм санхүүжилтийг зохицуулах зохих үйл явц, журам, дүрэм гэх мэт тогтолцоо хүрээ бий болгох, үүнд доор байгаа b-c d хүртэлх зохицуулалтыг багтаасан байна;
- б. санхүүжилтийг тодорхойлохоос өмнө:
 - i. бүх оролцогч талууд, үүнд хүүхдүүд болон бусад суралцагчид, эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчид, багшлах болон багш биш ажилтнууд, боловсролын холбоод, иргэний нийгмийн бусад байгууллагуудын бүрэн, үр дүнтэй утга учиртай оролцоог чухалчилсан оролцоотой, хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай зөвлөлдөх үйл явцтай байх;
 - ii. төрийн ийм санхүүжилт нь материаллаг, процедурын болон бусад бүх шаардлагыг хангаж байгааг олон нийтэд ил тод харуулсан байх;
 - iii. төр хувийн хэвшлийн боловсролын сургалтын байгууллагын холбогдох стандартыг хангах чадварыг тасралтгүй хянах, зохицуулах чадавх, хүсэл эрмэлзлэлээ үнэлж, олон нийтэд харуулах;
- в. санхүүжилт хуваарилах үйл явц нь ил тод, ялгаварлан гадуурхахгүй байх;

- г. санхүүжилтийг бодит байдал дээр эргүүлэн өөрчлөх эсвэл хувийн сургалтын боловсролын байгууллагуудын үүргийг төрд шилжүүлэх боломжтой байхаар тохируулсан байх.

Үйл ажиллагааны шаардлага

67. Хэрэв шаардлага хангасан хувийн сургалтын боловсролын байгууллага нь төрийн санхүүжилт авсан бол тухайн байгууллагад мөрдөгдөж буй стандарт, журам нь дор хаяж төрийн боловсролын байгууллагад ногдуулсан боловсролын, хөдөлмөрийн болон бусад холбогдох стандартыг тусгасан, түүний дотор хөдөлмөрийн нөхцөл, ажил эрхлэлт, хөдөлмөрлөх эрх, эвлэлдэн нэгдэх эрхийг үр дүнтэй хамгаалсан байх ёстой.

68. Төрөөс хувийн сургалтын байгууллагыг санхүүжүүлэх үндэслэл болсон боловсролын үйлчилгээ үзүүлэх аливаа асуудлыг хүргэх, удирдах чадваргүй байдлыг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай арилгахын тулд бүх үр дүнтэй арга хэмжээг авах ёстой. Ингэхдээ улс орнууд сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхийн тулд тогтмол санхүүжилтийг бэхжүүлж, улсын чадавхийг харгалзан дахин үнэлж байх ёстой. Үүнд анх байгуулагдсан цагаасаа эхлэн энэхүү санхүүжилтийг зөвтгөсөн төрийн чадваргүй байдлыг арилгах үед санхүүжилтийг үе шаттайгаар зогсоох төлөвлөгөө багтсан байх ёстой.

69. Эрх бүхий хувийн сургалтын байгууллагын төрийн аливаа санхүүжилт нь хүний эрхэнд үзүүлэх нөлөөллийн өмнөх, явцын, дараах үнэлгээний дүн шинжилгээнд хамрагдах ёстой бөгөөд эдгээрийг олон нийтэд мэдээлж, санхүүжилтийн сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг байнга дахин үнэлэх ёстой бөгөөд шаардлагатай бол санхүүжилтийг өөрчлөх, зогсоох. Үнэлгээ нь байгууллага тус бүрийн болон системийн үр нөлөөг богино болон урт хугацаанд хэмжих ёстой бөгөөд үүнд хүүхэд, бусад суралцагчид, эцэг, эх эсвэл хууль ёсны асран хамгаалагч, олон нийт, багшлах болон багш биш ажилтнууд, боловсролын холбоод, иргэний нийгмийн бусад байгууллагуудыг оролцуулах ёстой.

70. Төр санхүүжилтийг үргэлжлүүлэн хангах нөхцөлөөр шаардагдах стандартыг биелүүлэх шаардлагыг оруулах, стандартын шаардлагыг хангаагүй тохиолдолд төр хохиролгүйгээр санхүүжилтээс гарахыг бүх гэрээнд зөвшөөрч, гэхдээ сурч боловсрох эрхийг үргэлжлүүлэн эдлэхийг баталгаажуулах ёстой. Санхүүжилтийн үр нөлөө нь сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тэр дундаа олон нийтийн боловсролын тогтолцооны хөгжлийг үлэмж хэмжээнд үгүйсгэх эсвэл сулруулахад чиглэсэн байвал төрийн аливаа санхүүжилтийг буцааж татах ёстой.

71. Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ, зохицуулалт болон төрд тавигдах бусад шаардлагын зардлыг санхүүжилтийн зохицуулалтын зардлын үнэлгээний нэг

хэсэг гэж үзэн, төрөөс бүх боломжит нөөцийг дээд зэргээр ашиглаж хамгийн дээд түвшний боловсрол эзэмшүүлэх үүргийг зохих ёсоор нь харгалзан үзнэ.

72. Төрийн санхүүжилт авсан бүх хувийн сургалтын байгууллагууд боловсролын системийг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулах боломжтой бүх материалыг хууль тогтоомжоор тогтоосон боломжийн хугацаанд холбогдох төрийн байгууллагуудад өгөхийг баталгаажуулах ёстой. Үүнд анги танхимд ашигладаг технологи, удирдлагын систем хоёулаа багтана. Энэ нь хувийн нууцыг хамгаалах, ялангуяа суралцагч, багш нарын хувийн эрхийг хамгаалах, хүндэтгэх хүрээнд хийгдэх. Энэ нь тэдний зохиосон шинжлэх ухаан, бичгийн, урлагийн аливаа бүтээлийн үр дүнд бий болсон ёс суртахууны болон материаллаг ашиг сонирхлыг хамгаалах хүн бүрийн ашиг хүртэх эрхийг хүндэтгэх үүднээс хийгдэх ёстой.


Эрхгүй байгууллага

73. Төр дараах хувийн сургалтын боловсролын байгууллагыг шууд болон шууд бус хэлбэрээр санхүүжүүлэх, дэмжих ёсгүй. Үүнд :

- a. тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийг зөрчсөн, түүний дотор сонгон шалгаруулсан байдлаар ашигласан; эсвэл суралцагчдыг нийгэм, эдийн засгийн сул тал, суралцагч, гэр бүл, хамт олон, хүйс, хөгжлийн бэрхшээл, бусад хориглосон үндэслэлээр шууд болон дам байдлаар хөөх, ангилах;
- б. арилжааны шинжтэй бөгөөд хувийн ашиг сонирхлоо хэт их хөөдөг;
- в. боловсролын хүртээмжийг ихээхэн доройтуулсан төлбөр хураамж авдаг;
- г. хувийн боловсролын сургалтын байгууллагад хамаарах хамгийн бага стандарт, эсвэл хүний эрхийн бусад холбогдох хууль тогтоомж, стандартад нийцээгүй, эсвэл чанарын шаардлага хангахгүй байх;
- д. дотоодын болон олон улсын санхүүгийн бүх үүргээ биелүүлдэггүй;
- е. боловсрол эзэмших эрхийг эдлэхэд системчилсэн сөрөг нөлөөлөлд хувь нэмэр оруулах эсвэл хүний эрхийг бусад хэлбэрээр хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлдөг.

Сургалтын бус боловсролын хувийн байгууллагууд

74. Аливаа хувийн сургалтын бус боловсролын байгууллагуудтай гэрээ байгуулах нь сурч боловсрох эрхээ эдлэхэд сөргөөр нөлөөлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд худалдан авалтыг зохицуулах журам, холбогдох бусад журмыг хүндэтгэх ёстой.



Нийтлэг зарчим 6. Олон улсын туслалцаа, хамтын ажиллагааны тохиолдолд холбогдох эрх эзэмшигчидтэй зөвлөлдөж, хүлээн авагч улстай хамтран үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын тогтолцоог бэхжүүлж, хувийн боловсролын байгууллагуудыг хүний эрхэд харшлах шууд болон шууд бус хэлбэрээр дэмжихээс татгалзах ёстой.

75. Олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа нь дэмжлэг үзүүлсэн тохиолдолд холбогдох эрх эзэмшигчидтэй зөвлөлдөж, хүлээн авагч улстай хамтран үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын тогтолцоог бэхжүүлэх ёстой. Хүний эрхийг дээдлэх, хамгаалах, биелүүлэхийн тулд хөгжлийн төслийн үе шат бүрт бүхий л хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Үүний тулд хөндлөнгийн, хараат бус байдлаар үнэлэх үйл явцыг зохион байгуулах ёстой.

76. Боловсролын чиглэлээр олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа явуулж буй улс орнууд болон холбогдох олон улсын байгууллагууд хувийн боловсролын байгууллагуудыг хүний эрхэд харшлах шууд болон шууд бус хэлбэрээр дэмжихээс татгалзах ёстой.

77. Хувийн оролцогчид боловсрол эзэмших эрхийг хүчингүй болгох, эсвэл доройтуулах үйлдлээс татгалзах үүрэгтэй. Боловсролд туслалцаа үзүүлж буй хүмүүс нь үзүүлж буй дэмжлэг нь холбогдох хүний эрхийн хууль тогтоомж, стандарт, түүний дотор хүүхэд хамгааллын бодлоготой нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах үүрэгтэй. Төр хувийн оролцогчдоос өөрсдийн харьяаллын хүрээнд үзүүлж буй боловсролын туслалцаа нь хүний эрхийн хэрэгжилтийг хүчингүй болгох эсвэл сулруулах нөхцөлийг бүрдүүлэхийн эсрэг тэдгээрийг зохицуулах ёстой.

78. Хэрэв төр, олон улсын байгууллагууд эсвэл бусад оролцогчид олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа эсвэл бусад хэлбэрээр тусламж үзүүлэх замаар өмнө нь хүлээн авагч улсыг тухайн улсын хүний эрхийн үүрэгт үл нийцэх үйлдэл хийх, үүнд төлбөртэй болгох эсвэл төлбөрийг нэмэх эсвэл нийтийн үнэгүй боловсролын санхүүжилтгүй болгох зэргээр зөвшөөрөгдөөгүй алхмуудыг хийхийг уриалсан, хувь нэмэр оруулсан эсвэл албадсан бол энэ байдлыг хамгийн богино хугацаанд арилгахыг эрмэлзэх ёстой.

79. Хэрэв хүлээн авагч оронд хувийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх нь сурч боловсрох эрхээ эдлэхэд сөрөг нөлөө үзүүлж байгаа бол тухайн хүлээн авагч улсад олон улсын туслалцаа, хамтын ажиллагаа үзүүлж буй улс орнууд нөхцөл байдлыг засах бүх үр дүнтэй арга хэмжээг авах ёстой. Үүнд хүлээн авагч улсад үнэ төлбөргүй, чанартай, олон нийтийн боловсролын хүртээмжийг аль болох үр дүнтэй, түргэн шуурхай боловсруулж хөгжүүлэх, сэргээн босгох арга хэмжээг багтааж болох бөгөөд тухайн улсад хүний эрхийн хууль, стандартын дагуу боловсролын салбарт

хувийн оролцоотой холбоотой стандарт, журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Энэ нь хүлээн авагч улсын дотооддоо боловсрол эзэмших эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүргийг хөндөхгүй.

V. ЭГЭХ ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТ, ЗАЛРУУЛАХ АРГА ЗАМ

Нийтлэг зарчим 7. Төр сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх, үүнд хувийн секторын оролцогчдыг боловсролд хамруулахтай холбогдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь хариуцлага хүлээлгэх хангалттай механизмыг бүрдүүлэх ёстой.

80. Төр сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх, үүнд хувийн секторын оролцогчдыг боловсролд хамруулахтай холбогдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь хариуцлага хүлээлгэх хангалттай механизмыг бүрдүүлэх ёстой. Хариуцлагыг дараах байдлаар хангах ёстой. Үүнд:

- а. үндэсний, бүс нутгийн эсвэл дэлхийн түвшинд эрүүгийн, иргэний, захиргааны хариуцлага хүлээлгэх, албадан гүйцэтгэх ажиллагааг багтаасан шүүхийн арга хэрэгсэл;
- б. парламентын хяналт, Парисын зарчмын дагуу үйл ажиллагаа явуулж буй Хүний эрхийн үндэсний байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд эсвэл бусад дотоодын, хүний эрхэд нийцсэн хагас-шүүхийн механизм зэрэг хагас-шүүхийн болон шүүхийн бус хянах арга хэрэгсэл.

Нийтлэг зарчим 8. Төр улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудын сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, энэ эрхтэй холбоотой төрийн бүхий л бодлого, үйл ажиллагаа хүний эрхийн зарчимд нийцэж байгааг баталгаажуулах ёстой.

81. Төр сурч боловсрох эрх, үүнд оролцоо, ил тод байдал, мэдээлэл олж авах, хүртээмжтэй байдал, ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг хүний эрхийн зарчмуудыг дагаж мөрдөж байгааг тогтмол хянах ёстой.

82. Ийм хяналт шинжилгээний үр дүн нь олон нийтийн хүртээл байх ёстой бөгөөд хүний эрхийг хангах талын зөрүү дутагдалыг тогтоосон тохиолдолд хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай.

Олон нийтийн боловсролын хяналт

83. Төр олон нийтийн боловсролыг хүний эрхийн дотоодын болон олон улсын үүрэгт нийцэж байгаа эсэхийг үнэлэх, үүнд үр дүнтэй, хараат бус, хангалттай нөөцтэй хяналтын системийг бий болгох замаар үнэлэх ёстой. Тэд мөн олон нийтийн боловсролын үйл ажиллагааны ил тод байдалд болон шийдвэр гаргахад бүрэн, үр дүнтэй оролцоог хангахын тулд шаардлагатай мэдээллийг олон нийтэд хүргэх ёстой.

Хувийн оролцооны хүрээнд хяналт тавих

84. Боловсролд оролцдог хувийн оролцогчдыг холбогдох стандарт, дүрэм журам, үүнд 54-77 дугаар Удирдах зарчмуудад заасан хамгийн минимум/бага стандартыг дагаж мөрдөж, сурч боловсрох эрхийн үүргийг биелүүлэхийн тулд төр үр дүнтэй хяналт болон хэрэгжүүлэх механизмыг бий болгох, сахих, зохих эх үүсвэрээр хангах ёстой.

85. Хяналтынхаа хүрээнд төр, хувийн боловсролын сургалтын байгууллагуудын сурч боловсрох эрхийг эдлэхэд үзүүлж буй нөлөөллийг үнэлэх зорилгоор тогтмол мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх ёстой. Ийм үнэлгээ нь дараах хоёр зүйлийг хэмжих ёстой. Үүнд:

- а. сурч боловсрох эрхийг эдлэхэд бодит болон нөлөөлж болзошгүй нөлөөллийг үнэлэх, богино болон урт хугацааны хувийн боловсролын сургалтын байгууллагуудын системийн үр нөлөө;
- б. хувийн сургалтын байгууллагууд үйл ажиллагаагаараа дамжуулан үүсгэж болох эсвэл хувь нэмэр оруулж болох хүний эрхийн хэрэгжүүлэлтэд үзүүлэх нөлөө.

86. Үнэлгээ нь дараах байдлаар байх ёстой. Үүнд:

- а. хувийн боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа, үйл ажиллагааны нөхцөл байдал өөрчлөгдөж хөгжихийн хэрээр сурч, боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд үзүүлэх нөлөөлөл цаг хугацааны явцад өөрчлөгдөж болохыг хүлээн зөвшөөрч тогтмол байх;
- б. олон нийтийн оролцоотой бөгөөд бүх оролцогч талууд, үүнд хүүхдүүд болон бусад суралцагчид, эцэг, эхчүүд эсвэл хууль ёсны асран хамгаалагчид, хүй олон, багшлах болон багш- биш ажилтнууд, боловсролын үйлдвэрчний эвлэлүүд, бусад иргэний нийгмийн байгууллагууд орно;
- в. олон нийтэд нээлттэй.

87. Энэхүү үнэлгээний үр дүн нь хувийн сургалтын байгууллагуудын оролцоо нь сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг дэмжиж, сулруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс төрөөс баримталж буй бодлого, зохицуулалтанд тусгагдах ёстой. Төр сөрөг үр дагаврыг хэрхэн шийдвэрлэсэн эсвэл шийдвэрлэх талаар тогтмол тайлан нийтэлж байх ёстой.

Ерөнхий зарчим 9. Төр сурч, боловсрох эрхийг зөрчсөн, боловсролын хувийн секторын тоглогчид хүний эрхийг зөрчсөн тохиолдолд үр дүнтэй залруулах арга хэмжээ авах боломжоор хангах ёстой.

88. Төр боловсрол эзэмших эрхийг зөрчсөн тохиолдолд үр дүнтэй залруулах арга хэмжээ авах боломжоор хангах ёстой, үүнд мөн төр бүтэлгүйтсэн тохиолдол багтана. Үүнд:

- а. олон нийтэд үнэ төлбөргүй, чанартай боловсрол олгох үүргээ биелүүлэх;
- б. хувийн секторын оролцогчид сурч боловсрох эрхээ эдлэхэд саад учруулахаас урьдчилан сэргийлэх.

89. Төр аливаа эрх бүхий этгээд, эсвэл боломжтой бол бусад холбогдох оролцогч талууд болох нийтийн ашиг сонирхлын бүлгүүд боловсролд оролцож буй хувийн оролцогчийн зүгээс аливаа хүний эрхийг зөрчсөн тохиолдолд түүнийг арилгах арга хэрэгслийг эрэлхийлэх, эрхээ шаардах чадвартай байх боломжийг бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд шүүх арга хэмжээг багтаасан өргөдөл гомдлыг барагдуулах, хянах механизмыг шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй, процедурын дагуу шударга, хараат бус байлгах механизмыг бэлэн байлгах ёстой. Тэд эдгээр гомдол, хянан шийдвэрлэх механизмыг хувийн эрх бүхий этгээд болон төр хоёул өөрсдийн эрх мэдлийн хүрээнд хангаж байх ёстой. Боловсрол эзэмших эрхийг урвуулан ашигласан хувийн секторын оролцогчдыг нөхөн төлбөрт хувь нэмэр оруулахыг шаардах ёстой.

90. Боловсролд хувийн секторын оролцогчдыг татан оролцуулахаас үүсэх сөрөг үр дагавар гарах, төр эдгээр асуудлыг зохих ёсоор өөрөө шийдвэрлэж чадахгүй байгаа тохиолдолд төрийн эсрэг гомдол гаргах боломжтой засах арга хэрэгслийг баталгаажуулах ёстой.

VI. УДИРДАХ ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Нийтлэг зарчим 10. Улс орнууд эдгээр Удирдах зарчмуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэрэгслээр хэрэгжүүлэх замаар баталгаажуулах ёстой, үүнд шаардлагатай тохиолдолд хууль эрх зүй, төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэх.

91. Хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглалыг багтаасан салбарууд эдгээр Удирдах зарчмуудыг бүх шаардлагатай арга хэрэгслээр үр дүнтэй хэрэгжүүлэх ёстой бөгөөд үүнд шаардлагатай тохиолдолд хууль эрх зүй, төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэх. Төр дотоодын, бүс нутгийн, дэлхийн хэмжээний боловсрол, хөгжлийн төлөвлөгөө, хууль, бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхдээ эдгээр Удирдах зарчмуудыг тусгаж, хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний, техникийн болон санхүүгийн нөөцийг зориулах ёстой.

92. Төр сурч, боловсрох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтынхаа хүрээнд эдгээр Удирдах зарчмуудыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй эгэх хариуцлагын механизмыг хянаж, бий болгох ёстой.

93. Төр эдгээр Удирдах зарчмуудыг холбогдох бүх эрх бүхий байгууллагууд, ялангуяа боловсролын байгууллагуудад бүх холбогдох хэл, форматаар түгээж, хүртээмж, хэрэгжилтийг хөнгөвчлөх ёстой. Төр шаардлагатай бол холбогдох албан тушаалтнууд болон боловсролын байгууллагуудад зорилтот сургалтыг өгөх ёстой.

94. Төр Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын үндсэн үүргийг хүлээн зөвшөөрч, хамтран ажиллаж, сурталчлах ёстой, үндэсний байгууллагуудын статустай холбоотой Нэгдсэн Үндэстний Байгууллагын зарчимд нийцүүлэн ажиллах, эдгээр Удирдах зарчмуудын хэрэгжилт, түгээлтэд хяналт тавих.


95. Төр сурч, боловсрох эрхээ эдлэхэд нөлөөлөх бодлогын талбаруудын уялдаа холбоог хангах, ялангуяа боловсролын бодлогод үүрэг гүйцэтгэдэг бүх шатны төрийн байгууллагууд, агентлагууд болон төрийн бусад байгууллагууд тус тусын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн хүний эрхийн үүрэг болон эдгээр Удирдах зарчимуудыг мэддэг, дагаж мөрддөг байх ёстой.

Олон улсын байгууллагууд

96. Олон улсын байгууллагууд бусад олон улсын ерөнхий хууль, олон улсын гэрээнд заасны дагуу боловсрол эзэмших эрхтэй холбоотой үүргээ биелүүлэх ёстой. Тухайн байгууллага өөрсдийн зан үйлийг эдгээр Удирдах зарчимтай уялдуулж байгаа эсэхийг баталгаажуулах ёстой.

97. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд, бүс нутгийн байгууллагууд болон хөгжлийн бусад оролцогчид эдгээр Удирдах зарчмуудыг хэрэгжүүлэхэд нь олон улсын хүний эрхийн хуулиар хүлээх хүний эрхийн үүргээс гадна дэмжлэг үзүүлэхийг уриалж байна. Ийм дэмжлэгт техникийн хамтын ажиллагаа, санхүүгийн туслалцаа, байгууллагын чадавхийг хөгжүүлэх, мэдлэг хуваалцах зэрэг орно.

Орчуулсан: Хүний эрхийн шинжээч Б.Болорсайхан



Б.ЛХАГВАСҮРЭН

Дотоод хэргийн их сургуулийн Ахисан шатны боловсролын сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙН “ШИНЖЛЭХ УХААНЫ БАТАЛГАА” НЬ ШИНЖЛЭН МАГАДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЮМ

Дотоод хэргийн их сургуулийн Ахисан шатны боловсролын сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Б.Лхагвасүрэнг “Хүний эрх” сэтгүүлийн зочноор урьж ярилцлаа.

Тэрбээр “Хүний эрхэд суурилсан шинжлэн магадлах үйл ажиллагаа: онол, арга зүйн асуудал” сэдвээр хууль зүйн докторын зэрэг хамгаалжээ.

“SCIENTIFIC GUARANTEE” OF RIGHT TO FAIR TRIAL IS A FORENSIC ANALYSIS PROCESS

As a guest of this issue we have invited Mr. B.Lkhagvasuren, Lieutenant Colonel of Police, Associate professor, Doctor of law, Director of School of Advanced Education, University of Interior Affairs. He acquired his doctoral degree in law by writing a thesis on “Human rights based forensics: theoretical and methodological issues.”

Таны докторын судалгааны сэдэв манай улсын хувьд анхдагч шинэлэг юм байна. Энэ сэдвийг сонгож судлах болсны учир шалтгаан юунд байв?

Юуны өмнө “Хүний эрх” сэтгүүлийг уншиж байгаа эрхэм уншигч, судлаачдын амгаланг эрье. Манай улс 1964-1993 оныг хүртэл дээд боловсролтой криминалистикийн шинжээчийг зөвхөн Зөвлөлт Холбоот Улсын Дотоод явдлын яамны их, дээд сургуульд бэлтгэж ирсэн. Миний бие дотооддоо бэлтгэсэн анхны боловсон хүчний нэг. Цагдаагийн академид 2005 онд бакалаврын хөтөлбөрийг дүүргэсэн. Дотооддоо бэлтгэсэн анхны “Эрх зүйч-криминалистикийн шинжээч” бакалаврын хөтөлбөрийн төгсөгч болсондоо их баярлаж, багш нараараа бахархаж явдаг. Мэргэжлээрээ 2 жил Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнд ажиллаад 2007 оноос Цагдаагийн академид багшаар томилогдсон. Сонсогч, суралцагчдад криминалистик, шинжлэн магадлах ухааны хичээлүүдийг заахдаа эдгээр шинжлэх ухаан бол яллахуйн арга, хэрэгсэл биш, харин хүний эрхийг шинжлэх ухааны аргаар хамгаалахын тулд бий болсон тусгай мэдлэгийн салбар юм шүү гэсэн сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлэхийн төлөө ажиллаж эхэлсэн. Хичээлээрээ дамжуулан хүний эрх, шинжлэн магадлах ухаан хоорондоо салшгүй холбоотой гэдэг ойлголтыг түгээхээс гадна уг үзэл баримтлалыг шинжлэх ухаан, онол, арга зүйн судалгаагаар батлах шаардлагатай гэж үзсэн. Докторын зэрэг горилсон диссертацийн судалгааны сэдвээ хүний эрхтэй уялдуулах шалтгаан нь тэр байсан.

Шинжлэн магадлахуй гэж юуг хэлээд байна вэ? Утгачилж тайлбарлавал?

Аливаа хэрэг, маргаанд хамааралтай зүйлийг магадлан шинжилж, дүгнэх арга зүй, технологийг боловсруулдаг “Forensic Science” хэмээх мэдлэгийн салбарыг “Шинжлэн магадлах ухаан” гэж монголчилдог бөгөөд энэ нь уг шинжлэх ухааны агуулга, мөн чанарыг оновчтой илэрхийлж чадна гэж үздэг.

1949 оны БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 14 дүгээр бүлэгт үзлэг, шинжилгээ хийх ажиллагааг “Магадлан үзэх” гэж нэрлэж байв. Мөн 1944 онд Цагдан сэргийлэх газарт “Шинжлэн магадлах техникийн 4 дүгээр тасаг”, 1959 онд Сангийн яаманд “Нягтлан бодох бүртгэлийн хянан магадлах товчоо”, 1960 онд Эрүүлийг хамгаалах яамны харьяанд “Шүүх эмнэлгийн магадлах товчоо” гэж шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг мэргэжлийн байгууллагуудыг анхлан нэрлэсэн байдаг. Энэ бүхэн санамсаргүй тохиолдол бус харин тухайн үед хэл шинжлэлийн эрдэмтдээс бүрдсэн Улсын нэр томъёоны комисс улсын дотор дагаж мөрдөх бүх нэр томъёог эрдэм шинжилгээний үндэстэйгээр боловсруулдаг байсны илрэл юм. Түүнчлэн Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 44 дүгээр

зүйлд криминалистик, шүүх эмнэлэг, санхүү, нягтлан бодох бүртгэл зэрэг шинжилгээ хийж, дүгнэлт гаргах эрх бүхий байгууллагуудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах арга хэмжээ авах талаар дурдахдаа эдгээр байгууллагыг нийтэд нь “магадлан шинжилгээний байгууллага” гэж тодотгосон байдаг.

Шинжлэн магадлах үйл ажиллагааг зориулалтаар нь шүүхийн шинжилгээ, шүүхийн бус шинжилгээ гэж хуваадаг. Тэгэхээр шинжлэх ухааныг дотор нь байдаг ухагдахуунаар нь бус, уг мэдлэгийн салбарын агуулга, мөн чанарыг нь харгалзаж нэрлэх нь зүйтэй. Магад гэдэг үгийн тухайд “лавтай, гарцаагүй, үнэн, нотолсон адилтгал” гэсэн утгатай. Нотолсон адилтгал гэдэг бол “нотлох баримтын эргэлзээгүй байдал” гэсэн агуулгатай дүйх ойлголт.

Шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэстэй явуулах зарчмыг гарцаагүй баримталж, улмаар шинжээчийн дүгнэлт, нотлох баримтын тусгай шалгуурыг хангах шаардлагад “магадлах” гэдэг утга дүйнэ. Өөрөөр хэлбэл “хэргийн бодит байдлыг эргэлзээгүй тогтоох” гэдэг ойлголт шинжээчийн дүгнэлт магадтай байхаас хамаарна.

Тэгвэл шинжлэн магадлахуй яаж хүний эрхтэй холбогддог юм бэ?

Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөнд эерэгээр нөлөөлөх эрх зүйн орчин бүрдсэн боловч хүний эрхийн зөрчил гарсаар л байна. Процесс хэрэгжүүлэгчид хуулийг ягштал мөрдөхийн зэрэгцээ шинжлэх ухаанч хандлагаа нэмэгдүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл хууль, шинжлэх ухаан хоёрын нэгдэл нь шударга шүүхийн орчин үеийн хөгжлийн загвар гэж хардаг. Харамсалтай нь процессын хууль тогтоомжид шинжлэх ухааныг зөв, үр дүнтэйгээр ашиглах талаар тусгасан нь бага. Манай улсын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомж болон практикт “шинжээчийн дүгнэлттэй үл маргах” эсвэл “шинжээчийн дүгнэлтийг баримтлах үүрэггүй” гэсэн харилцан нэгнээ үгүйсгэсэн үзэл баримтлалууд тусгалаа олж, хамтдаа оршсоор ирсэн нь хүний эрхийг ноцтойгоор зөрчих, эрх чөлөөг нь үндэслэлгүйгээр хязгаарлах нөхцөл болсоор байна.

Хүний эрхийн үзэл санаа, онолын үндэс болсон түүхэн эх сурвалжуудад хүнийг нотлох баримтгүйгээр хорьж шийтгэхгүй байх, нотлох хүртэл гэм буруугүйд тооцох зэрэг зарчмыг тогтоож өгсөн нь шударгаар шүүлгэх эрхийн суурь ойлголт болж өгсөн. Шударгаар шүүлгэх эрхийн “шинжлэх ухааны баталгаа” бол шинжлэн магадлах үйл ажиллагаа бөгөөд энэ нь шинжээчийн дүгнэлтийн эргэлзээгүй, найдвартай байдлаар хангагдана.

Шинжлэн магадлах үйл ажиллагааг хүний эрхэд суурилсан хандлагаар тодорхойлж, ойлгох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинжлэх ухаанч хандлагыг нэмэгдүүлнэ. Шинжлэх ухаанч хандлага төлөвшсөнөөр

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог хэлбэр болох “шинжлэн магадлах ухаан” хүний эрхийн баталгаа болох зүй тогтолтой.

Таны судалгааны бүтээл нийгэмд тулгамдаад буй хүний эрхийн олон асуудлыг шийдвэрлэхэд практик ач холбогдолтой гэж үзэж болох уу? Ялангуяа эрүү шүүлтээс ангид байх эрхийг хэрэгжүүлэхэд ямар хувь нэмэртэй вэ?

Магадлах (шүүх) шинжилгээний арга зүй бий болоогүй байсан эрт үед гэмтнүүдэд ял, шийтгэлээс зайлсхийх боломж их байв. Гэмт хэрэг илрүүлэх, шийдвэрлэхэд ихээхэн бэрхшээлтэй тулгардаг байсан ба үндсэн арга нь хүч хэрэглэн эрүүдэн шүүж хэрэг хүлээлгэх, эсвэл гэрч, хохирогчийн мэдүүлгийг ашигладаг байв. Өөрөөр хэлбэл хэрэг мөрдөх үндсэн зорилго нь ял тулгагдаж буй этгээдээр өөрөөр нь хэрэг хүлээлгэх явдал байв. Сэжигтэн хэрэг хүлээхгүй бол хүч хэрэглэн бие махбод, сэтгэл санаанд нөлөөлж, тарчлаан зовоож, хэргийг хүлээлгэсний дараа л байцаалтыг дуусгана. Энэ нь хилсээр ял шийтгэгдэх бас нэг шалтгаан болдог.

Мөн гэмт этгээд ял завшсан тохиолдолд нөгөө талд хохирогчийн зөрчигдсөн эрх сэргээгдэхгүйгээр золиос болдог. Хүний эрхийн баталгааг хангаж буй нэг чухал үзүүлэлт нь “тэгш боломж”-ийн асуудал юм. Тодруулбал хохирогч, сэжигтнүүдтэй ажиллахад ижил нөхцөл, боломжоор хангасан байх ёстой. Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн өнөөгийн ардчилсан нийгэмд эрх зүйн аливаа зөрчлийг зөвхөн байцаах, залхаах аргаар сэжигтэн, яллагдагчийг айдаст автуулан, хэрэг хүлээхээс аргагүй байдалд оруулж шийдэх бус, харин гэмтний хэргийн газарт үлдээсэн мөр, түүнийг магадлан шинжилсэн шинжээчийн дүгнэлтийг зөв үнэлэх буюу шинжлэх ухааны үүднээс “мөрдөж нотлох” учиртай. Олон улсад гэмт хэрэг мөрдөх, нотлох ажиллагааг “Forensic investigation” буюу шинжлэн магадлаж мөрдөх гэж нэрлэж, эрүү шүүлтээс ангид байх, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг үндсэн арга, хэрэгсэл бол “Forensic science” гэж л үзэж байна.

Докторын диссертация бичиж боловсруулахад хэр хүндрэл бэрхшээлтэй байв. Таны судалгааны бүтээлийн шүүмжлэгчээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн оролцсон гэсэн. Энэ тухай ярилцвал уншигчдад сонин байж болох юм?

Мэдээж хүндрэлтэй зүйл байсан. Хамгийн гол нь судалгааны ажлын хүнд хүчир гэхээс илүүтэй хатуу хэвшсэн үзэл баримтлал, зарчмын эсрэг санаа дэвшүүлж, хамгаална гэдэг нь хүнд байсан. Хүний эрхийг хангах шинжлэх ухааны баталгаа бол шинжлэн магадлах ухаан юмаа гээд л ярьж, судалж, бичиж эхлэхэд нийгэмд нэгэнт тогтсон “шинжээчийн дүгнэлт бол яллахуйн арга хэрэгсэл” гэсэн үзэл баримтлалтай тулгарч, хийж буй ажлыг

минь ойлгон хүлээж авах хүн цөөн байсан. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч багш, доктор, профессор Б.Бат-Эрдэнэ багш арга зүйн хувьд дэмжлэг үзүүлэхээс гадна гарцаа үгүй шинжлэн магадлах ухаан хүний эрхийг хангах зүй тогтолтой гэдэг итгэл үнэмшлийг минь бататгаж өгсөн.

Диссертацийн маань албан ёсны шүүмжлэгч байгууллагаар Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга асан доктор Ж.Бямбадоржийг, албан ёсны шүүмжлэгчээр доктор С.Цэрэндорж гуайг томилсон. Шүүмж иртэл айх, бахдахын завсараар их л догдолж хүлээсэн дээ. Айсан учир нь мэдээж, миний хувьд нарийн мэргэшээгүй салбар болох хүний эрх судлалыг хөндсөнийг маань хүний эрхийн салбарын томоохон төлөөлөгч эрдэмтэд шүүмжилнэ гэдэгт байсан. Харин бахдах зүйл нь хүний эрхийг хангахад шинжлэн магадлах ухааныг ашиглах санал дэвшүүлснийг минь хүний эрхийн мэдрэмжээр шүүж тунгаана гэж бодож билээ.

Диссертацийн албан ёсны шүүмжид хийсэн судалгааны ажил, хамгаалахаар дэвшүүлсэн асуудлыг бүрэн дэмжиж, амжилт хүссэн байгааг уншихад их л баярлаж, хамгаалалтад өөртөө итгэлтэй байх урам зориг болсон.


Шийдэл олох, гарц гаргалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлан таниулах нь судлаачдын хувьд үнэт зүйл нь байж мэдэх. Та докторын судалгааны сэдвээ цааш үргэлжлүүлэх үү? Магадгүй бодит амьдралд хэрэгжүүлэх талаар бодож төлөвлөсөн зүйл байгаа юу?

Нэгдүгээрт шинжлэн магадлах үйл ажиллагааны урьдчилсан нөхцөл болох хэргийн газрын үзлэг, эд мөртэй ажиллах арга зүйг хамтад нь уялдуулж хөгжүүлэх, хоёрдугаарт Монгол Улсын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжлэх ухаанч хандлагыг дэлхийн орчин үеийн хөгжлийн түвшинд хүргэхийн тулд шинжлэн магадлах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах арга зүй, технологийг улам боловсронгуй болгоход эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр ажиллана.

Хүний эрхийг бүдүүлгээр зөрчдөг эрүү шүүлтийн үндсэн хэлбэр болох “байцааж нотлох” гэсэн ойлголтыг хуульчдын сэтгэхүйгээс “арчиж”, гэмт хэргийг зөвхөн “шинжлэх ухааны аргаар мөрдөж нотлох” гэсэн үзэл баримтлал төлөвшүүлэх шаардлага өнөөгийн хууль зүйн онол, практикт бий болсон. Энэ хандлага, үзэл баримтлалыг шинжлэх ухааны хувьд гүнзгийрүүлэн судлах чин хүсэлтэй явдаг.

Цаг зав гаргаж ярилцсан танд баярлалаа.

*Ярилцсан: Монгол Улсын Хүний эрхийн
Үндэсний Комиссын референт З.Бадмаарга*



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, V давхар
Утас: 51-266506, 51-262902, Факс: 976-11-320284
Цахим хаяг: www.nhrctm.gov.mn, Цахим шуудан: info@nhrctm.gov.mn
Иргэдээс гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх утас: 7000-0222
Хүний эрхийн цахим номын сан: <https://lib4u.net/?lib=nhrctm>

ISSN: 2617-9288